



switchasia



МОНГОЛЫН НЭХМЭЛИЙН САЛБАРЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРҮҮДИЙН НОГООН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Мэдэгдэл: "Энэхүү тайлан нь Европын Холбооны санхүүжилтээр хэвлэгдэв. Хэвлэлд дурдагдсан аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг ТОС болон Гэрэгз Партнерс бүрэн хариуцах бөгөөд Европын Холбооны байр сүүрийг илэрхийлээгүй байж болно."

МОНГОЛЫН НЭХМЭЛИЙН САЛБАРЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРҮҮДИЙН НОГООН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Европын Холбооны SWITCH Asia хөтөлбөрийн хүрээнд 4 жилийн хугацаанд Монгол Улсад хэрэгжих “Монголын Нэхмэлийн Салбарын Тогтвортой Үйлдвэрлэл, Эко Тэмдэг” (STeP EcoLab) төслийн захиалга, санхүүжилтээр тус судалгааг гүйцэтгэв.

Төслийн ерөнхий зохицуулагчаар Хил хязгааргүй малын эмч нар (AVSF) олон улсын байгууллага ажиллаж, ТоС холбоо, Монголын Банкны Холбоо, Монголын Ноос Ноолуурын Холбоо, ШУТИС, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, Байгаль орчин аюулгүй байдлын төв, Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн нэгдсэн төв (CSCP, ХБНГУ) байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна.

Тус судалгааг Гэрэгэ Партнерс зөвлөх үйлчилгээний компанийн судлаачдын баг 2019 оны III улиралд гүйцэтгэв.¹

ГЭРЭГЭ ПАРТНЕРС ХХК

2019 он

¹ Тус судалгааны ажлыг гүйцэтгэхэд Гэрэгэ Партнерс ХХК ба судалгааны багийн гишүүдэд аливаа сонирхлын зөрчил байхгүй.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТОЙМ.....	2
1.1 ҮНДЭСЛЭЛ.....	2
1.2 ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	6
1.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	7
1.4 ДҮГНЭЛТ.....	8
БҮЛЭГ 2. АРГА ЗҮЙ, БҮТЭЦ, ХЭРЭГЛЭЭ БА ХЯЗГААРЛАЛТУУД.....	9
2.1 АРГА ЗҮЙ.....	9
2.2 ХАМРАХ ХҮРЭЭ.....	10
2.3 ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, БҮТЭЦ.....	10
2.4 ТАЙЛАНГИЙН ЗОРИУЛАЛТ, НУУЦЛАЛ.....	11
2.5 ХЯЗГААРЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС.....	11
БҮЛЭГ 3. НООС НООЛУУР БОЛОВСРУУЛАХ САЛБАР, САНХҮҮ ЗЭЭЛ.....	13
3.1 НООС, НООЛУУРЫН САЛБАРЫН ТОЙМ.....	13
3.2 БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	14
БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	16
4.1. МОНГОЛЫН НЭХМЭЛИЙН САЛБАРЫН НОГООН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ.....	16
4.1.1 Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн салбарт эзлэх байр суурь.....	16
4.1.2 Ноос ноолуурын үйлдвэрүүдэд шаардлагатай ногоон санхүүгийн эрэлтийн тооцоолол.....	17
4.1.3 Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн нэн тэргүүний зориулалт.....	21
4.1.4 Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн ногоон санхүүжилт, ногоон зээлийн талаарх ойлголт.....	21

4.1.5 Байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлуудад хандах хандлага.....	22
4.1.6 Ногоон санхүүжилт, ногоон зээл авахаар хандаж байсан туршлага, ирээдүйн чиг хандлага.....	22
4.1.7 Үйлдвэрүүдийн хувьд банкны зээл авахад тулгардаг саад, бэрхшээлүүд.....	23
4.1.8 “Ногоон зээл”-ийн нөхцөл, шаардлагын талаарх үйлдвэрүүдийн хүлээлт.....	24
4.2 НОГООН САНХҮҮГИЙН НИЙЛҮҮЛЭЛТ, БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭРҮҮД	25
4.2.1 Мэдээллийн эх сурвалж, хамрах хүрээ.....	25
4.2.2 Боломжит ногоон санхүүгийн нийлүүлэлтийн тооцоолол	26
4.2.3 Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдийн тойм, бүлгээр..	27
4.2.4 Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдэд байгаль орчин, нийгэм, тогтвортой хөгжлийн асуудал хэрхэн туссан байдал, тэдгээрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө.....	28
4.2.5 Арилжааны банкнуудын санал болгож буй зээлийн бүтээгдэхүүнүүдийн нөхцөл, нийтлэг шаардлага, шалгуурууд	31
4.2.6 Үйлдвэрүүдийн хувьд банкны зээл авахад тулгардаг саад, бэрхшээл, эрсдэлүүд – Банкнуудын зүгээс.....	32
4.2.7 Нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчдийн арилжааны банкнаас зээл хүсэх нийтлэг зорилго – Банкнуудын зүгээс	33
БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	34
ХАВСРАЛТУУД	

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

“Монголын нэхмэлийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлтийн судалгаа” нь Европын Холбооны SWITCH Asia II хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг” төслийн бүрэлдэхүүн судалгаануудын нэг юм. Тус төслийг AVSF Олон улсын байгууллага нь Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС), Монголын Ноос Ноолуурын Холбоо (МННХ) болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

1.1 ҮНДЭСЛЭЛ

ЯАГААД НОГООН САНХҮҮГ СУДЛАХ БОЛОВ?

Дэлхий нийтэд тулгараад байгаа байгаль орчин, хүрээлэн буй орчны доройтол, байгалийн нөөцийн хомсдол, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг тэргүүн зорилго болгодог хөгжлийн уламжлалт загвар давамгайлсан хүн төрөлхтний сүүлийн 150 гаруй жилийн үйл ажиллагааны үл мөр, үр дүн гэж хэлж болно. Бодлого төлөвлөлтгүй, нөөцийн хэмнэлтгүй бохир үйлдвэрлэл, хямд үнийн өрсөлдөөн, бараа бүтээгдэхүүний хэт үйлдвэрлэл, нийлүүлэлтийн улмаас хэмжээ хязгааргүй, замбараагүй, цамаан, нэг удаагийн хэрэглээний соёл, хандлага газар авч, нөгөө талаас баялгийн тэгш бус хуваарилалтын улмаас баян хоосны ялгаа, ялгарал улам нэмэгдсээр байна. Иймд эдийн засгийн хөгжлийг бий болгохдоо байгаль орчин, нийгмийн асуудлуудыг эн тэнцүү чухалчлах,

ач холбогдол өгөх ногоон хөгжлийн загвар нь ойрын ирээдүйд хамгийн оновчтой хөгжлийн загварт тооцогдож байна. Улс гүрнүүд өөрсдийн орны эдийн засаг, үйлдвэрлэл, иргэдийн хэрэглээ, дадал, амьдралын хэв маягийг эрс өөрчилж, байгальд ээлтэй, тогтвортой, ногоон хөгжлийн чиг хандлага баримтлах шаардлага урган гарсан.

Ногоон хөгжлийн амин тулгуурын нэг нь тогтвортой буюу байгальд ээлтэй үйлдвэрлэл ба хэрэглээ юм. Гэтэл ногоон үйлдвэрлэл, практик төдийлөн дэлгэрэхгүй, хэрэгжихгүй байгаа шалтгааны нэг бол иргэд, аж ахуйн нэгжүүд ногоон үйлдвэрлэлд шилжих шилжилтийг *нэмэлт зардал* гэж хардаг явдал мөн. Энэ хандлагыг эвдэх, ногоон үйлдвэрлэл, хэрэглээнд шилжихийг нэмэлт зардал биш харин шинэ боломж болгох арга нь ногоон санхүүжилт¹ юм. Тухайлбал, 2008 онд Их Британид “Уур амьсгалын өөрчлөлтийн баримт бичиг” (Climate Change Act)-ийг баталж, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес, аж ахуйн нэгжүүдээс “Уур амьсгалын өөрчлөлтийн татвар” (Climate Change Levy) авдаг болсон. Бизнесүүд энэ үйлдлийг “дэмжлэг биш татвар” хэмээн үзэж, ихэд буруушаасан тул Засгийн газраас “Carbon Trust” байгууллагыг шинээр байгуулж, эрчим хүчний үр ашгийн хөнгөлөлттэй зээлийн схем боловсруулж хэрэгжүүлсэн нь үр дүнд хүрсэн түүхтэй.²

2014 онд баталсан Монгол Улсын “Ногоон хөгжлийн бодлого”-д “Ногоон санхүүжилт гэж байгалийн нөөц баялаг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж, эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг хэлнэ” хэмээн томъёолсон байдаг.

¹ Тус тайланд ногоон санхүү, ногоон санхүүжилт хэмээх томъёоллуудыг адил утгаар ашигласан болно

² Азийн Хөгжлийн Банк, “Energy efficiency finance programs: best practices to leverage private green finance”, 2018

Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь санхүүгийн салбарт ч эрсдэлийг бий болгож, тодорхой бүс байдлыг нэмэгдүүлж байгаа тул ногоон санхүүг дэмжиж хөгжүүлэх шаардлага, үндэслэл болдог. Дэлхийн улс орнууд ногоон санхүүг хөгжүүлэх, санхүүгийн салбартаа нэвтрүүлэх хүчин чармайлтууд хийсээр байна. Тухайлбал, БНХАУ-ын ногоон зээлийн хэмжээ 2019 оны 1-р улиралд 4.3 хувиар өсөж, нийт зээлийнх нь 10 орчим хувийг бүрдүүлжээ. Мөн дэлхийн Тогтвортой хөрөнгө оруулалтын холбооны мэдээлснээр Ногоон хөрөнгө оруулалтын сан 2018 онд 31 их наяд ам.доллар болсон нь 2016 онтой харьцуулбал 34%-аар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 1/3 орчмыг эзлэх болжээ.³ Санхүүгийн салбар дахь ногоон санхүүгийн нэвтрэлт, чанарыг хэмждэг “Дэлхийн ногоон санхүүгийн индекс”-ээр тэргүүлэгч санхүүгийн төвүүдэд Амстердам, Люксембург, Копенхаген, Лондон, Парис, Хамбург, Цюрих зэрэг баруун Европын томоохон хотууд багтдаг.⁴

Монгол улсын банк санхүүгийн салбар тогтвортой санхүүг хөгжүүлэх, нэвтрүүлэх тал дээр үндэсний хэмжээнд манлайлан, идэвх санаачилгатай ажиллаж байна. Монголын арилжааны бүх банкнууд тогтвортой санхүүгийн зарчимд нэгдэн, ногоон санхүү, ногоон зээлийн шинэ бүтээгдэхүүнүүд хөгжүүлэн гаргаж эхэлсэн. Тухайлбал, ХасБанк нь Эко банкны хэлтэс байгуулан, мөн Уур Амьсгалын Ногоон Сангийн албан ёсны түнш болж хүлэмжийн хийг бууруулах зориулалттай зээлийн бүтээгдэхүүн гаргаж, ногоон санхүүг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна. Түүнчлэн, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй “ЯОУХАБ-ын 2 үе шаттай зээлийн төсөл”, “Монголын тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн үйлчилгээ” зэрэг ногоон санхүүгийн төслүүдийн хүрээнд

арилжааны банкнуудаар дамжуулан ААН ба хувь хүмүүст ногоон зээл олгож байна.

ЯАГААД НЭХМЭЛИЙН САЛБАРТ НОГООН САНХҮҮ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Нэхмэлийн салбарын ногоон санхүүг судлах болсон хэд хэдэн шалтгаан бий.

Нөхөн сэргээгдэх баялаг, стратегийн түүхий эдийн нөөц | Монгол улс бол хөдөө аж ахуйн, тодруулбал мал аж ахуйн орон тул МАА нь улсын эдийн засаг, нийгмийн харилцаанд чухал ач холбогдолтой салбар юм. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 2017 онд Монгол улсын ДНБ-ний 10.6 хувь, экспортын орлогын 8.4 хувийг бүрдүүлсэн бөгөөд үндэсний хэмжээнд нийт ажиллах хүчний 30 орчим хувь нь энэ салбарт ажиллаж байна. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах үндсэн нөхцөл нь болдог.

Ноос, ноолуур бол хоргүй, дахин ашиглах боломжтой, органик материал бөгөөд нүүрсхүчлийн хийг өөртөө шингээх онцлог шинж чанартай, “смарт” буюу ухаалаг, амьд, уургийн ширхэгт юм. Байгалийн ширхэгтүүд хоргүй энгийн нэгдлүүд болж бүрэн задралд ордог тул хүрээлэн буй орчинд хуримтлагдаж, бохирдуулдаггүй онцлогтой. Ноосон бүтээгдэхүүнийг хэрэглэгч дунджаар 2-10 жил өмсөж ашигладаг бол жишиг хөвөн даавуун эсвэл нийлэг эдээр хийсэн хувцас хэрэглэлийн ашиглалтын хугацаа 2-3 жил байдаг аж. Түүнчлэн, ноосон бүтээгдэхүүнийг угааж арчлах шаардлага, давтамж бага байдаг нь ноосон ширхэгт бохирдлыг түлхдэг, агаарт тавих төдийд өөрийгөө

³ Блүүмберг, <https://www.bloomberg.com/graphics/2019-green-finance/>

⁴ Уг индексийг MAVA сангийн санхүүжилтээр “Finance Watch”, “Long Finance” байгууллагууд хамтран 3 дахь удаагаа 2019 онд тооцсон. https://www.finance-watch.org/wp-content/uploads/2019/03/GGFI_3_Full_Report.pdf

цэвэрлэдэг байгалийн мөн чанартай нь холбоотой юм. Өөрөөр хэлбэл, ноосон бүтээгдэхүүн хэрэглэх нь эрчим хүч, усны хэмнэлттэй сонголт болдог. Эдгээр бүх шинж чанар нийлээд ноос ноолуурыг маш үнэ цэнэтэй, орлуулшгүй түүхий эд болгодог.⁵

Харин түүхий ноос, ноолуурыг боловсруулан бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд ус, эрчим хүч, химийн бодис, хүн хүч, олон төрлийн техник, тоног төхөөрөмж ашиглах шаардлага гардаг тул үйлдвэрлэл, боловсруулалт, тээвэр, борлуулалтын үйл ажиллагаа нь хүлэмжийн хийн ялгарлыг дагуулдаг. Үүний сацуу, түүхий эд бэлтгэлтэй холбоотой бэлчээрийн даац, сэлгэлт, хөрсний доройтол, цөлжилтийн асуудлууд зүй ёсоор хөндөгддөг.

Цогц үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний бодлого | Монгол улс, эх сурвалжаас хаамаран, түүхий ноолуурын 37⁶ хувиас 50⁷ хүртэл хувийг бэлтгэдэг, ноолуурын нөөцөөрөө дэлхийд 2-т ордог хэдий ч ноолууран түүхий эдийнхээ 90 орчим хувьд зөвхөн анхан шатны боловсруулалт хийж, дийлэнхийг экспортолдог. Үлдсэн 10 гаруй хувь түүхий эдээр эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, дотоод, гадаадын зах зээлд борлуулдаг. Нэхмэлийн салбарын үйлдвэрлэл нь сүүлийн таван жилд (2014-2018) аж үйлдвэрийн салбарын 2-3%, боловсруулах үйлдвэрлэлийн 11-17%, хөнгөн үйлдвэрийн 50 гаруй хувийг эзэлж, тус салбарын бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын 6-6.5%-ийг эзэлдэг бөгөөд үүнээс нэмүү өртөг шингээгүй угаасан ноолуурын экспорт дангаараа 4%-ийг эзэлж байна.

Улсын хэмжээнд ноос, ноолуурын боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүртгэлтэй нийт 300 гаруй үйлдвэрт 10,000-аад ажилчид

ажиллаж, тэдгээрийн дийлэнх буюу 85% нь эмэгтэйчүүд, 60% нь залуучууд байна.

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэрэг бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан Боловсруулах үйлдвэрлэлийн салбар, тэр дундаа ноос, ноолуурын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар, чанарыг нэмэгдүүлэн, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлснээр эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал байр суурь эзэлнэ хэмээн онцолсоор ирсэн. Үүний хүрээнд үндэсний “Ноолуур (2018-2021)” болон “Үйлдвэржилт 21:100 (2018-2021)” хөтөлбөрүүд 2018 онд батлагдан, хэрэгжиж байна. Нэмүү өртөг шингэсэн цогц үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар нэхмэлийн салбарыг тогтвортой хөгжүүлж чадвал цаашид Монголын эдийн засагт дорвитой нөлөө үзүүлэх болно.

2018 оноос хэрэгжиж эхэлсэн Ноолуур хөтөлбөрийн нөлөөгөөр нэхмэлийн салбарын үйлдвэрлэл болон экспорт мэдэгдэхүйц өсөж, 1570 ажлын байр шинээр нэмэгдсэн байна. 2018 онд нэхмэлийн бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос 22%-аар өсөж, нийт экспортын 6 орчим хувийг эзэлжээ. 2021 он хүртэл үргэлжлэх Ноолуур хөтөлбөрийн үр дүнд нэхмэлийн салбар ойрын жилүүдэд өргөжин тэлэх хандлагатай байна. Нэхмэлийн салбарын бас нэгэн онцлог бол жижиг дунд үйлдвэрлэгчдийн хувь хэмжээ их, эдийн засаг нийгмийн ач холбогдол өндөр байдаг юм.

⁵ <https://www.iwto.org/re-use-and-recycling>

⁶ <https://www.gschneider.com/2019/03/01/annual-cashmere-market-report/>

⁷ <http://www.mongoltextile.mn/?p=513>

Нөгөө талаас, **нэхмэлийн үйлдвэрлэл нь бохирдуулагч, нүүрсхүчлийн үл мөр өндөртэй салбар** | Аливаа улс орны нэхмэлийн⁸ салбар нь тухайн орны онцлогоос хамааран нийт хүлэмжийн хийн ялгарлынх нь 2-10%-ийг үүсгэдэг бөгөөд тус салбарын үйлдвэрлэл, хөгжил цаашид энэ эрчээрээ үргэлжилбэл 2050 он гэхэд энэ салбар дангаараа дэлхийн нийт нүүрсхүчлийн хий (CO₂)-н ялгарлын 1/4-ийг гаргадаг болно гэж эрдэмтэд тооцоолжээ (*Sustainable Fashion Academy, The Swedish Textile Initiative for Climate Action*).

Иймд сүүлийн жилүүдэд дэлхий нийтийн хандлага өөрчлөгдөж, түүхий эд бэлтгэлээс эхлээд, үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалтын шат дамжлага бүрийг байгальд ээлтэйгээр шийдвэрлэх, эрчим хүч, усны хэмнэлттэй техник технологи нэвтрүүлэх, хүн ба байгальд сөрөг нөлөөгүй химийн бодис ашиглах, салбарын хүний нөөцийн чадавх, аюулгүй ажиллагаа, нийгмийн асуудлуудад түлхүү анхаардаг болжээ.

"Монголын ноос, ноолуур боловсруулах салбарын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн суурь үнэлгээ"-гээр нэхмэлийн үйлдвэрүүд эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг зохих түвшинд авдаг, харин ус, химийн бодисын зохистой хэрэглээ, хэмнэлт, хаягдал усыг цэвэршүүлэх асуудал дээр хангалтгүй ажиллаж байгаа нь тогтоогджээ. Ноос, ноолуурын үйлдвэрүүд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг одоогийн 10 хувиас 50 хувь эсвэл 90 хувь хүртэл өсгөвөл усны хэрэглээ 1.7-4.8 сая тонн, эрчим хүч 26.7 сая кВтцаг-аас 160-250 сая кВтцаг хүрч, хаягдал усны хэмжээ нь Төв цэвэрлэх байгууламжийн ачааллыг нэмэгдүүлэх тооцоо гарсан. Хэрвээ нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, цэвэрлэх

байгууламжуудыг баривал дээрх хэрэглээнүүд 20-30%-иар буурах боломжтой, цаашлаад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах боломжтойг тооцоолсон байна.

Худалдан авагч (зах зээл) тогтвортой бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг шаардаж, сонгож байна | Хэрэглэгчид худалдан авалт хийхдээ байгаль орчны асуудлыг илүү их анхаардаг болсноор тогтвортой бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна. Европын жижиглэнгийн худалдаачдын 85% нь сүүлийн 5 жилд тогтвортой бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдсэн гээд, тэдний 92% нь ирэх 5 жилд тогтвортой бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.⁹

АНУ-ын зарим бүтээгдэхүүний зах зээлд тогтвортой гэсэн ангилалд багтах бүтээгдэхүүний борлуулалт нийт бүтээгдэхүүний борлуулалтаас өндөр өсөлттэй¹⁰ мөн АНУ-ын хэрэглэгчдийн 47% нь тогтвортой бүтээгдэхүүнд илүү өндөр үнэ төлөхөд бэлэн байгаагаа илэрхийлжээ.¹¹

Санхүүжилт, ногоон санхүүжилт хангалтгүй, ЖДҮ-т хүртээмж муу | Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөхүйц чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тогтвортой үйлдвэрлэл эрхлэх хүсэл эрмэлзэл салбарын үйлдвэрлэгчдэд байгаа хэдий ч тохирох санхүүжилт хангалтгүй, хөрөнгө оруулалттай холбоотой саад бэрхшээлүүд их тулгарч байна. Тухайлбал, өнгөрсөн таван жилд боловсруулах салбарт нийт 4.5 их наяд төгрөгийн зээл олгогдсоны 55-60% нь 1-5 жилийн хугацаатай, 4-5% нь л 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 30 гаруй хувь нь төслөөр хэрэгжсэн зээл байна. Жил ирэх тутам тус салбарын хугацаа хэтэрсэн зээлийн бүтэц өссөөр, 2018 оны жилийн эцсийн байдлаар боловсруулах

⁸Тус тайланд Нэхмэлийн салбар гэж Текстилийн салбарыг ерөнхийд нь ойлгоно

⁹http://www.intracen.org/uploadedFiles/intracenorg/Content/Publications/EU%20Market%20for%20Sustainable%20Products_Report_final_low_res.pdf

¹⁰ <https://www.nielsen.com/wp-content/uploads/sites/3/2019/04/whats-sustainability-got-to-do-with-it.pdf>

¹¹ <https://www.globenewswire.com/news-release/2019/01/10/1686144/0/en/CGS-Survey-Reveals-Sustainability-Is-Driving-Demand-and-Customer-Loyalty.html>

салбарын хугацаа хэтэрсэн зээл дотроо 28%-ийг эзэлжээ. Өөрөөр хэлбэл зах зээлд одоогоор борлуулагдаж буй жилийн 13-20%-ийн хүүтэй, 1-5 жилийн хугацаатай зээлийн бүтээгдэхүүний нөхцөлүүд нь салбарын жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн шаардлага, хэрэгцээг хангаж чадахгүй, төлбөрийн чадвараас давсан үнэтэй, эрсдэл өндөртэй байна.

Дүгнэвэл, нэг талаас нэхмэлийн салбарыг тэлэх, үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хувь хэмжээг өсгөх улсын бодлого хэрэгжиж байгаа энэ чухал эгзэгтэй цаг үед зах зээлийн шаардлага, худалдан авагчийн хүсэлд нийцүүлэн байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийн арга хандлага, зарчмуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлж хэрэгжүүлэх олзурхууштай цонх үе гарч байна. Үүний тулд салбарын жижиг дунд үйлдвэрүүдэд шаардлагатай байгаа ногоон санхүүгийн эрэлт хэрэгцээг, нөгөө талаас санхүүжүүлэгч байгууллагуудаас санал болгож буй боломжит нийлүүлэлт ямар байгааг судлах шаардлага урган гарсан.

2018-2022 онд хэрэгжих “Монголын нэхмэлийн салбарын байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг төсөл (Step EcoLab)”-ийн ерөнхий зорилго нь Монгол улсын нэхмэлийн салбарт байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээг бий болгоход дэмжлэг үзүүлж, үүнд шаардлагатай судалгаа, шинжилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

1.2 ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү судалгааны зорилго нь Монголын ноос, ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн ногоон санхүүгийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг тодорхойлоход орших бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх юм, үүнд:

- Одоогийн ногоон санхүүгийн эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ, ногоон санхүү, хөрөнгө оруулалтын нийт зах зээлийн хэмжээ, боломжит хөрөнгө оруулалтын хэрэгцээнүүдийг тодорхойлох;
- Монголын арилжааны банкнууд, Монгол Улсын Хөгжлийн банк, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд, банк бус санхүүгийн байгууллагууд, нэхмэлийн үйлдвэрүүдтэй ярилцлага хийх замаар эдгээрийн хооронд байгаа болон бий болох боломжит бизнесийн холбооснуудыг тодорхойлох;
- Нэхмэлийн үйлдвэрүүдэд нэн тэргүүнд ногоон санхүүгийн ямар хэрэгцээ байгааг тодорхойлох;
- Нэхмэлийн салбарын жижиг, дунд үйлдвэрт зориулсан ногоон санхүүгийн бүтээгдэхүүний судалгаа хийх буюу тэдэнд ямар төрлийн оновчтой санхүүгийн шийдэл байж болох судалгаа, шинжилгээ хийх;
- Банкнуудын ногоон зээлийн бүтээгдэхүүний гол шаардлагуудыг тодорхойлох, өөрөөр хэлбэл банкнууд нэхмэлийн үйлдвэрүүдэд ямар шаардлага тавьдаг, үйлдвэрүүдийн ногоон зээл авахад тулгардаг саад бэрхшээлүүд, банкнууд үйлдвэрүүдээс ямар төрлийн эрсдэлүүдийг олж хардаг талаар судлах;
- Нэхмэлийн үйлдвэрүүд “ногоон зээл” гэдэгт юуг багтаан ойлгож байгаа, ногоон зээлээс хүлээж байгаа зээлийн хэмжээ, зээлийн хүү, зээлийн хугацааг тодорхойлох;
- Нэхмэлийн үйлдвэрүүдийн ногоон санхүү авахаар хандаж байсан оролдлого, түүхүүд болон авсан ногоон зээлийн хэмжээг тодорхойлох, ногоон зээл авах ямар төлөвлөгөө, төсөөлөлтэй байгааг тодорхойлох зорилтууд багтана.

1.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

МОНГОЛЫН НЭХМЭЛИЙН САЛБАРЫН НОГООН САНХҮҮГИЙН ЭРЭЛТ

Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдээс өгсөн тоон ба чанарын мэдээлэлд үндэслэн нийт ноос, ноолуурын салбарын ногоон санхүүгийн эрэлт хэрэгцээг аль болох бодитой тооцоолохыг зорьсон.

Ярилцлага судалгаанд хамрагдсан, идэвхтэй үйл ажиллагаатай **17 үйлдвэрт 2019 оны 10-р сарын байдлаар нийт 24.5 тэрбум төгрөгийн ногоон санхүүгийн эрэлт** байна. Тус эрэлтийн 10.7 тэрбум төгрөг (44%) нь үйлдвэрийн барилга, байгууламжийн дулааны алдагдлыг бууруулах шийдэлд, 4.41 тэрбум төгрөг (18%) нь цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи нэвтрүүлэхэд, 4.1 тэрбум төгрөг (17%) нь бохир усны цэвэрлэх байгууламж барихад, үлдсэн 21% нь үйлдвэрлэл, үйлчилгээг ногоон, тогтвортой болгох бусад хэрэгцээнд шаардлагатай байна. Нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд ногоон санхүүд хамруулах боломжтой нийт 42 нэр төрлийн зориулалтыг тодорхойлсон болно.

Нийт нэхмэлийн салбарын ЖДҮ-ийн ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр 250 тэрбум төгрөг, харин зорилтот төсөөллөөр 576 орчим тэрбум төгрөг байна гэж тооцоолов. Бодит гэдэг нь судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн салбарт эзлэх хувьд тулгуурлаж тооцоолсныг, харин зорилтот гэдэг нь үндэсний бодлого, хөтөлбөрүүдэд тусгасан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг ойрын ирээдүйд нэмэгдүүлэх зорилттой уялдуулж бодсон тооцоолол юм.

Бидний ашигласан аргачлал бол нэгдүгээрт боловсруулж буй түүхий эдийн хэмжээ ба боловсруулалтын түвшнийг ашиглах, хоёрдугаарт үйлдвэрлэлийн хэмжээ, эцсийн бүтээгдэхүүний гарцад түшиглэх, гуравдугаарт үндэсний бодлого, хөтөлбөрт салбарын үйлдвэрлэлийг

ойрын ирээдүйд хэдий хэмжээнд хүргэхээр зорьсон зорилтот түвшинд тулгуурлах байлаа. Судалгаанд хамрагдсан 17 компанийн үйлдвэрлэлийн гарц нь салбарын нийт үйлдвэрлэлийн 20 орчим хувийг; харин үйлдвэрлэлийн дамжлагаас хамааран нийт зах зээлийн 8.6-37.2%-ийг эзэлж байв. Нэг зүйлийг онцолж хэлэхэд, ажлын даалгавар ёсоор нэхмэлийн салбарын *жижиг дунд үйлдвэрүүдийн ногоон зээлийн эрэлтийг* тодорхойлох зорилттой байсан тул Говь (2019 онд Гоёо компанитай нэгдсэн) компанийг тус судалгаанд оруулаагүй. Учир нь Говь компани бол зөвхөн үндэсний хэмжээнд ч биш олон улсын хэмжээнд ноолууран бүтээгдэхүүний хамгийн том үйлдвэрлэгчдийн нэгт зүй ёсоор багтана.

НОГООН САНХҮҮГИЙН НИЙЛҮҮЛЭЛТ БУЮУ БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭР

Монголын нэхмэлийн салбарын ногоон санхүүгийн нийлүүлэлтийг **нэхмэлийн салбарын ААН-үүд авах боломжтой, ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийн нийт боломжит эх үүсвэрээр 75 тэрбум төгрөг** гэж тодорхойлов. Уг тодорхойлолтод нийцэх зээлийн бүтээгдэхүүн одоогоор 3 байна. Харин нийт ААН-д (зөвхөн нэхмэлийн салбарын бус) зориулсан ногоон зээлийн 5 бүтээгдэхүүн байгаа бөгөөд нийт эх үүсвэр нь 112 тэрбум төгрөг байна. Нэхмэлийн салбарын хувьд одоогоор ногоон зээл авсан тохиолдол маш бага (1 ААН 150 сая төгрөг) байгаа бол ЖДҮ-д чиглэсэн (ногоон гэх заалтгүй) зээл авсан байдал харьцангуй өндөр байна (118 ААН нийт 298.4 тэрбум төгрөг). Үүний шалтгаан нь энэ төрлийн зээлийн бүтээгдэхүүн илүү олон (тус судалгаанд 7 бүтээгдэхүүн хамруулсан), мөн боломжит эх үүсвэр нь 5-6 дахин их (402 тэрбум төгрөг) байгаатай холбоотой.

Ногоон санхүүгийн эрэлт нийлүүлэлтийг тодорхойлсон судалгааны дэлгэрэнгүй үр дүнг 4-р бүлэгт оруулсан болно.

1.4 ДҮГНЭЛТ

Нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр 250 тэрбум төгрөг, зорилтот төсөөллөөр 576 тэрбум төгрөг байна гэж тооцоолсон. Нөгөө талаас, нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүдэд тохирох, ногоон тодотголтой зээл, санхүүжилтийн боломжит нийлүүлэлт 75 тэрбум төгрөг байна гэж тогтоосон. Иймд тус салбарын ЖДҮ-үүд үйл ажиллагаагаа байгальд ээлтэй, ногоон болгоход шаардлагатай ногоон санхүүгийн эрэлтийг хангах хэмжээний санхүүжилт одоогоор зах зээлд хангалтгүй буюу эрэлт хэрэгцээ нь боломжит нийлүүлэлтээсээ 3.3-7.6 дахин өндөр байна.

Судалгаанд хамрагдсан компанийн удирдлагууд үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа байгальд ээлтэй, ногоон болгох нийтлэг хүсэл эрмэлзэлтэй байгаа ч дийлэнх нь (80%) энэ чиглэлд ямар нэг санаачилга, арга хэмжээ авч хэрэгжүүлж чадаагүй байна.

Жижиг, дунд, цогцолбор том үйлдвэрүүдийн хувьд санхүүгийн эрэлт хэрэгцээ, нэр төрөл, хэмжээ, зориулалт, хүлээлт тус бүр өөр өөр тул санхүүжилтийн нэг загвар, хандлагаар ногоон санхүүгийн асуудлыг шийдэх боломжгүй харагдаж байна.

ЖДҮ-үүд зөвхөн ногоон үйлдвэрлэлтэй болох зорилгоор зээл, санхүүжилт авах сонирхол бага, санхүүгийн дарамт, эрсдэлээс эмээдэг, тэдний хувьд зээл, нэмэлт санхүүжилтийг эргэлтийн хөрөнгө, үйл ажиллагааны зардал, үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад зарцуулах сонирхолтой байна.

Өөрөөр хэлбэл, урамшууллын эсвэл захиргааны нэмэлт хөшүүргүүд байхгүй тохиолдолд хангалттай хэмжээний, харьцангуй хөнгөн нөхцөлтэй ногоон санхүүгийн эх үүсвэр бүрдлээ ч бодит байдалд ногоон зээлийн бүтээгдэхүүний борлуулалт төлөвлөснөөс бага эсвэл

удаан байж болзошгүй. Одоо зах зээлд 75 тэрбум төгрөгтэй тэнцэх, ногоон гэж үзэж болох санхүүжилтийн эх үүсвэр нэхмэлийн ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нээлттэй байгаа ч бидэнд мэдэгдэж байгаагаар ганцхан ААН 150 сая төгрөгийн зээл авсан нь тогтоогдсон.

Ноос, ноолуурын салбарынхан ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүдээс хүртэхгүй байгаа нь санхүүгийн эрсдэлд орох хүсэлгүй; төлбөрийн чадвар хүрэхгүй; зээлийн шаардлага, шалгуурыг биелүүлэх чадваргүй; зээлийн материал бүрдүүлэх хүн хүч, чадвар, туршлага хангалтгүй; байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийн мэдлэг туршлага хангалтгүй; байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг бүрэн хийдэггүй; дээрх бүх чиглэлийн мэдлэг, мэдээлэл дутмагтай холбоотой гэж дүгнэж болно.

Олон улсын туршлагаар нөөцийн үр ашигтай үйлдвэрлэл явуулахад хамгийн түрүүнд хийх алхам нь ус, эрчим хүч, химийн бодисын хэрэглээг хэмждэг, бүртгэдэг болохоос эхлэх бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар, бага зардалтай, өгөөж өндөртэй байдаг. Үүний жишгээр Монголын нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд тогтвортой үйлдвэрлэлд шилжих хамгийн эхний, энгийн, хямд алхам бол нийтээрээ бүхий л төрлийн хэрэглээгээ хэмждэг, бүртгэдэг болохыг зорих гэж дүгнэж болно. Ингэж чадсан тохиолдолд дараа дараагийн хэмнэлтийн арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэх эсэхийг төлөвлөх нь зүйтэй.

Монголын нэхмэлийн салбарын жижиг дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн эрэлт хэрэгцээ, ногоон санхүүгийн боломжит нийлүүлэлтийг тодорхойлох судалгаа нь цаг үеэ олсон, шинэлэг, салбарын хэмжээнд хийгдсэн анхны, ач холбогдол өндөртэй ажил болсон гэж найдаж байна.

БҮЛЭГ 2. АРГА ЗҮЙ, ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ХЭРЭГЛЭЭ БА ХЯЗГААРЛАЛТУУД

2.1 АРГА ЗҮЙ

Ногоон санхүүгийн зах зээл, ногоон зээлийн нөхцөл байдлыг судлахдаа суурь судалгааны аргыг ашигласан бол нэхмэлийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн талаарх ойлголт, хүлээлт, ногоон санхүүгийн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, мөн арилжааны банкнууд дахь тус салбарын одоогийн зээлийн мэдээллийг шинжлэхдээ банк, санхүү болон нэхмэлийн салбарын удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүдээс асуулга авах, ярилцлага хийх замаар тоон болон чанарын суурь мэдээллүүдийг цуглуулж боловсруулав.

Суурь судалгаа:

- Монгол улсад хэрэгжүүлэн олгогдож буй ногоон санхүү, ногоон зээлийн бүтээгдэхүүн, ногоон хөгжлийг дэмжсэн дотоод гадаадын төсөл, хөтөлбөр, санаачилгуудын тойм судалгааг боловсруулав. Ингэхдээ зээлийн бүтээгдэхүүн бүрээр зээлийн нөхцөл, зээлийн шаардлага, санхүүгийн эх үүсвэр, зээл/санхүүжилтийн нийт хэмжээ зэрэг мэдээллүүдийг нэгтгэн шинжилсэн;

Асуулга:

- Монголын Ноос Ноолуурын Холбоо (МННХ)-той хамтран, салбарыг төлөөлөхүйц нийт 40-50 том, дунд жижиг үйлдвэрээс ногоон санхүүгийн эрэлтийн судалгааг цахим асуулгын аргаар

авахыг зорьсон. Тус асуулга нь компанийн ерөнхий мэдээлэл, үйлдвэрлэлийн бүтээмж болон нөөцийн хэрэглээний мэдээлэл, санхүү ногоон зээлийн мэдээлэл гэсэн үндсэн гурван бүлгийг хамарсан.

- Мөн Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС)-той хамтран ногоон зээл, нэхмэлийн үйлдвэрүүдийн зээлийн мэдээллийн судалгааг Монгол улсын бүх арилжааны банкнуудаас авахыг зорив. Тус асуулгад банк тус бүрээс нэхмэлийн салбарын үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээлийн хэмжээ, зээлдэгчдийн тоо зэрэг мэдээллүүд багтсан.¹²

Ярилцлага:

- Сонгогдсон анхан шатны 7, сүлжмэлийн 6, цогцолбор болон хагас цогцолбор 7, нийт 20 үйлдвэрийн удирдах түвшний албан тушаалтантай уулзаж, ярилцлага авах зорилттой ажилласан. Ярилцлага авахдаа дээр дурдсан асуулгаар судалгаа авч, үйлдвэр тус бүрийн өнөөгийн болон ирээдүйн ногоон санхүүгийн хэрэгцээг нарийвчлан тодорхойлох, ногоон зээлийн ойлголт, хүлээлт, зээлийн шаардлага нөхцөлөөс үүсэж буй хүндрэл, бэрхшээлүүдийн талаарх сэдвүүдийн хүрээнд ярилцав.
- Үйлдвэр, компаниуд ногоон санхүүгийн эрэлт, хэрэгцээгээ тэр бүр тодорхойлсон нь ховор, хэрхэн тодорхойлох тухай мэдлэг, аргачлал хангалтгүй байсан тул судалгааны багийн зүгээс нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд ногоон тодотголд орж болох нийтлэг хэрэгцээ, зориулалтуудыг тодорхойлж, чиглэл болох загвар маягт боловсруулан үйлдвэрлэгчдийн ногоон санхүүгийн эрэлтийн мэдээллийг цуглуулсан.

¹² Монгол улсын хэмжээнд зээлийн мэдээлэл үндсэн 18 дэд салбараар гарч, Боловсруулах салбарын нэгдсэн зээлийн дүнд нэхмэлийн салбарын зээлийн хэмжээ агуулагддаг байна. Одоогийн байдлаар нэхмэлийн салбарт нийт хэчнээн хэмжээний

зээлийн өрийн үлдэгдэл ногдож байгааг харуулсан нэгдсэн тоон мэдээлэл, эсвэл судалгаа шинжилгээ хийгдээгүй байна.

- Мөн банк санхүүгийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн байгууллагуудын холбогдох төлөөллүүдтэй уулзаж, ярилцлага хийж шаардлагатай мэдээлэл цуглуулсан болно.

2.2 ХАМРАХ ХҮРЭЭ

Монголын нэхмэлийн салбарын ногоон санхүүгийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгааны цар хүрээг тогтоохдоо судалгааг захиалагч STeP EcoLab төсөл, төслийн хамтрагч байгууллагууд болох Монголын Ноос Ноолуурын Холбоо (МННХ) ба ТоС Холбоотой зөвлөлдсөн. Улмаар нэгдүгээрт, салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 40-50 том, дунд, жижиг үйлдвэрээс цахим асуулгаар судалгаа авах; хоёрдугаарт, салбарыг төлөөлөхүйц жижиг дунд 20 үйлдвэрийн удирдах түвшний албан тушаалтантай биечлэн уулзаж ярилцлага авах замаар тухайн үйлдвэрийн ногоон санхүү, зээлийн хэрэгцээг тодорхойлох зорилтууд тавьж ажилласан. Дээрх аргаар цуглуулсан мэдээлэлд үндэслэн салбарын хэмжээнд ЖДҮ-ийн ногоон санхүүгийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох зорилттой ажилласан.

Ноос, ноолуурын салбарт өрхийн жижиг цехүүдийг оруулбал нийт 300 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй ч тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 120 гаруй үйлдвэр бий гэж тооцдог. Иймд, хэрэв 40-50 үйлдвэрийг судалгаанд хамруулбал, салбарын үйлдвэрүүдийн зохих хэмжээний оролцоог хангаж, төлөөлөл болохуйц мэдээлэл цуглуулж чадна гэж тооцсон болно.

Нөгөө талаас, Монгол улсын ногоон санхүүгийн нийлүүлэлт буюу боломжит эх үүсвэр, нийт зах зээлийн хэмжээг тодорхойлохдоо Монголд хэрэгжиж буй ногоон ба/эсвэл жижиг дунд үйлдвэрлэгчдэд чиглэсэн боломжит санхүүжилт, зээл, хөтөлбөр, төслүүдийг судалж, арилжааны 13 банкаар дамжин хэрэгжиж буй хамаарал бүхий зээлийн

бүтээгдэхүүнүүдийг судалсан. Үүнд: ААН-д зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүн 5, иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүн 5, ногоон санхүүжилт нь эхлээгүй байгаа төсөл 2, олголт нь зогссон ногоон зээлийн бүтээгдэхүүн 3, ЖДҮ-д чиглэсэн (ногоон гэх хязгаарлалтгүй) зээлийн бүтээгдэхүүн 7, мөн ББСБ-уудын томоохон 4 төлөөллийн бизнесийн зээлийн бүтээгдэхүүн тус тус багтсан.

2.3 ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, БҮТЭЦ

Судалгааны тайлан нийт 5 бүлэг, 7 хавсралттай. Үр дүнгийн хэсэг нь судалгааны зорилтуудтай уялдан 11 дэд агуулгатай. Үүнд: 1) ноос ноолуурын жижиг, дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүжилт, ногоон зээлийн талаарх мэдлэг, ойлголт; 2) ногоон зээл авахаар арилжааны банк, санхүүгийн байгууллагуудад хандаж байсан эсэх, тэдгээрийн туршлага болон ирээдүйн чиг хандлага; 3) банкны зээл авахад тулгардаг саад, бэрхшээлүүд; 4) үйлдвэрүүдэд банкны зээл авахад тулгардаг саад бэрхшээл, банкны зүгээс ямар эрсдэлүүд байдаг тухай; 5) ногоон зээлийн нөхцөл, шаардлагын талаарх үйлдвэрүүдийн хүлээлт; 6) арилжааны банкнуудын зээлийн бүтээгдэхүүний нөхцөл, шаардлага; 7) үйлдвэрүүдийн ногоон санхүү, ногоон зээлийн нэн тэргүүний зориулалт; 8) үйлдвэрүүдийн банкны зээл авах нийтлэг зорилго; 9) сонгогдсон 20 үйлдвэрт шаардлагатай байгаа ногоон санхүүгийн нийт мөнгөн дүнгийн тооцоолол; 10) ногоон санхүүгийн нийт ба боломжит нийлүүлэлтийн тооцоолол; 11) нэгдсэн ерөнхий дүр зураг багтав.

Байгальд ээлтэй шинэ технологи, тоног төхөөрөмж судалж сонгоход ихээхэн хүндрэлтэй байдаг тухай үйлдвэрлэгчид дурдаж, хэрэг болох анхан шатны судалгааг гүйцэтгэж өгөх хүсэлтийг судалгааны багийнханд тавьсан юм. Иймд байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай цэвэрлэх байгууламж, ус зөөлрүүлэгч

төхөөрөмж, барилгын дулаалгын материалын талаарх зах зээлийн товч судалгааг гүйцэтгэж хавсаргав.

Түүнчлэн, судлагдсан бүх зээлийн бүтээгдэхүүний тойм, Монгол улсад хэрэгжиж буй ногоон хөгжлийн болон нэхмэлийн салбарыг дэмжсэн олон улсын байгууллагуудын төслүүдийн тойм, нэхмэлийн салбарт ногоон санхүүг амжилттай хэрэгжүүлсэн олон улсын туршлагыг судлан тус тус хавсралтаар оруулав.

2.4 ТАЙЛАНГИЙН ЗОРИУЛАЛТ, НУУЦЛАЛ

Тус тайлан нь Европын Холбооны Step EcoLab төсөл, үг төслийг хэрэгжүүлэгч AVSF олон улсын байгууллага болон төслийн түнш байгууллагууд ToC холбоо, МННХ-ы дотоод хэрэгцээнд зориулагдсан болно.

Тус судалгааны үр дүн нь судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд болон арилжааны банкуудаас өгсөн тоон мэдээлэлд шууд үндэслэгдсэн. Мэдээлэл нууцлалын хувьд Гэрэгэ Партнерс компанийн судлаачид ToC Холбоо ба МННХ-той харилцан нууц хадгалах гэрээ байгуулсан. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал, дотоод зөрчилдөөнтэй эсэхэд шинжилгээ хийсэн боловч, аудитын эсвэл хараат бус шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Энэхүү судалгаанд ашигласан эх сурвалж, тоон мэдээллүүд нь судалгааны ажлын зорилготой нийцэх ба судалгааны үр дүн нь ашигласан мэдээллүүдийн хүрээнд хүчинтэй. Судалгаанд хамгийн сүүлийн, боломжит мэдээллийг ашиглахыг зорьсон.

2.5 ХЯЗГААРЛАХ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгааны аргачлал, үр дүнтэй холбоотой дараах хязгаарлах хүчин зүйлс бий, үүнд:

- Жижиг дунд 20 үйлдвэрийн удирдлагатай ярилцлага хийж, том жижиг дунд 40-50 үйлдвэрээс цахим асуулга авна гэж төлөвлөсөн хэдий ч салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн судалгаанд оролцох оролцоо хангалтгүй, сул байлаа. Иймд мэдээлэл боловсруулж өгсөн нийт 22 үйлдвэрийн мэдээлэлд үндэслэн тооцоог гаргаж, тайлагнав.
- Судалгааны зорилтуудын нэг нь ноос, ноолуурын салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийн хувьд ногоон зээлд хамрагдахад ямар саад, бэрхшээлүүд байна вэ гэдгийг судлах байв. Гэвч судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн хувьд ногоон зээлийн туршлага байгаагүй тул бизнесийн эсвэл төслийн зээлд хамрагдахад ямар бэрхшээл тулгардгийг тогтоохыг зорьсон.
- Ногоон зээлийн бүтээгдэхүүн ба төслийн талаарх шаардлагатай тоон мэдээллийн олдоц хангалтгүй байв. Тухайлбал ногоон зээлийн бүтээгдэхүүний судалгаанд нийт 13 банкнаас 10 банк хариу ирүүлсэн, цаашлаад эдгээр 10-с 4 нь ногоон зээлийн бүтээгдэхүүнгүй эсвэл нэхмэлийн салбарт олгосон зээлийн түүх байхгүй гэсэн тул үлдсэн 6 банкны мэдээлэлд үндэслэн судалгааны үр дүнг гаргав. Мөн Монгол Банк, Санхүүгийн Зохицуулах Хороо зэрэг төрийн байгууллагуудын зээлийн мэдээлэл салбараар задарч гардаггүй тул нэхмэлийн салбарт хамаарах тоон мэдээлэл авах боломжгүй байв.
- Ногоон зээлийн дүнгүүд гадаад валют (ам.доллар, евро)-аар илэрхийлэгдсэн үед ханшийг хөрвүүлэх шаардлагатай болсон. Тухайлбал, зарим төслийн хувьд нийт эх үүсвэрийн хэмжээ ам.доллараар, харин олголтын мэдээлэл монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн тул боломжит эх үүсвэрийн хэмжээг тооцохын тулд нийт эх үүсвэрийн хэмжээг төгрөгт шилжүүлэхдээ төсөл хэрэгжиж эхэлснээс хойших хугацааны дундаж ханшийг ашигласан. Харин эх үүсвэр олголтын аль аль нь ам.доллараар

илэрхийлэгдсэн бол боломжит эх үүсвэрийг ам.доллараар илэрхийлэн гаргаж, түүнийгээ 2019 оны 8 сарын ханшаар төгрөгт шилжүүлсэн. Тиймээс ханшийг өөр аргаар тооцох тохиолдолд судалгааны үр дүнгийн төгрөгөөр илэрхийлсэн дүнгүүд өөрчлөгдөнө.

- Монгол улсад одоогоор зөвхөн нэхмэлийн салбарт чиглэсэн ногоон зээлийн бүтээгдэхүүн байхгүй учраас энэ судалгаанд хамруулсан ногоон зээлийн ихэнх бүтээгдэхүүнүүд нь нэхмэлийн салбарт хамааралгүй, эсхүл нэхмэлийн салбарт олгогдоогүй байна. Түүнчлэн нэхмэлийн салбарт олгогдож буй ихэнх зээл нь ногоон үйлдвэрлэлд чиглээгүй, харин эргэлтийн хөрөнгө олгох, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх, нэмүү өртөг, экспортыг нэмэгдүүлэх зэрэг ерөнхий чиглэлд олгогддог байна.
- Удирдах албан тушаалтнууд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэрэгцээ бий гэдгийг ярилцлагын явцад илэрхийлсэн боловч бэлэн тооцоолол, мэдээлэл хомс байлаа. Цаашлаад хэрэгцээт санхүүжилт нь “ногоон” санхүүд багтах эсэх, ногоон санхүү гэдгийн дор яг юуг хамарч болох тухай мэдлэг дутмагаас хамаарч мэдээлэл цуглуулах явц сунжрах, тоон мэдээлэл дутмаг байх, найдвартай биш байх зэрэг хязгаарлагдах хүчин зүйлүүд үүссэн.

БҮЛЭГ 3. МОНГОЛЫН НООС НООЛУУР БОЛОВСРУУЛАХ САЛБАР, САНХҮҮ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1 НООС, НООЛУУРЫН САЛБАРЫН ТОЙМ

МУ-ын хэмжээнд ноос, ноолуурын боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бүртгэлтэй нийт 300 орчим үйлдвэр байгаагаас 15 нь иж бүрэн цогцолбор том үйлдвэр, 23 анхан шатны боловсруулах үйлдвэр, 59 сүлжмэлийн ЖДҮ, 150-200 өрхийн жижиг цех байна. Тус салбарт 10 мянга гаруй ажилчид ажиллаж, тэдгээрийн дийлэнх буюу 85% нь эмэгтэйчүүд, 60% нь залуучууд байна.

МННХ-ны мэдээлснээр дэлхийн ноолуурын нөөцийн 40 орчим хувийг Монгол улс эзэлж Хятадын (48%) дараа орж байна. 2018 онд Монгол улсын хэмжээнд 9,600 тн ямааны ноолуур, 1,300 тн тэмээний эм ноос, 33,000 тн хонины ноос, 250 тн сарлагийн хөөвөр бэлтгэжээ. Ноолуур боловсруулах салбарын үйлдвэрлэлийн дамжлага тус бүрээр суурилагдсан хүчин чадлын хувьд угаах дамжлага 9,100 тн, самнах 4,589 тн, ээрэх 1,810 тн, сүлжих 3,449 мянган ширхэг, нэхмэл 2,000 мянган метр байна (2018 он, ХХААХҮЯ). Гэвч, угаахаас бусад дамжлагууд суурилагдсан хүчин чадлынхаа 30-65% хувийг л ашиглаж байгаа гэсэн тооцоо бий.

Хүснэгт 3.1 Ноос, ноолуурын салбарын эдийн засгийн байр суурь, нөлөөлөл

Эдийн засгийн үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
ДНБ-д салбарын эзлэх байр суурь, бүт эц (100%)					
Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь	10.6%	9.1%	8.8%	10.7%	10.9%
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд эзлэх байр суурь, бүтэц (100%)					
Боловсруулах аж үйлдвэр	28.1%	35.9%	33.3%	32.3%	33.3%
Нэхмэлийн үйлдвэрлэл	2.2%	2.1%	2.2%	1.6%	1.8%
Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтад эзлэх байр суурь, бүтэц (100%)					
Боловсруулах аж үйлдвэр	22.8%	20.9%	21.0%	24.2%	24.9%
Нэхмэлийн үйлдвэрлэл	2.7%	3.3%	3.6%	2.7%	3.0%
Боловсруулах салбар доторх Нэхмэлийн үйлдвэрлэл, %	11.8%	15.6%	17.1%	11.3%	12.2%
МУ-ын нийт экспортод эзлэх байр суурь					
Нийт экспорт, сая.\$ (100%)	5,774.3	4,669.3	4,916.3	6,200.6	7,011.8
Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	338.8 (5.9%)	302.7 (6.5%)	300.2 (6.1%)	335.5 (5.4%)	409.8 (5.8%)
Угаасан ноолуурын экспорт	223.8 (3.9%)	197.2 (4.2%)	192.5 (3.9%)	205.6 (3.3%)	252.0 (3.6%)
Самнасан ноолуурын экспорт	61.9 (1.1%)	40.7 (0.9%)	33.2 (0.7%)	38.5 (0.6%)	54.9 (0.8%)
Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспортын өсөлт, жилээр	20%	-11%	-1%	12%	22%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо ба Гаалийн ерөнхий газар

2018 онд тус салбарын борлуулалтын орлого 1.2 их наяд төгрөг болж, үүнээс 86% нь экспортын үлдсэн 14% нь дотоодын зах зээлээс олсон орлого байна. Угаасан ноолуурын экспорт дангаараа 55%-ийг эзэлж, самнасан ноолуур болон эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспорт харгалзан 12% ба 18% байжээ. Угаасан ноолуурыг Хятад, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг улсуудад голдуу экспортолж байна (ХХААХҮЯ).

2018 оноос хэрэгжиж эхэлсэн Ноолуур хөтөлбөрийн нөлөөгөөр нэхмэлийн салбарын үйлдвэрлэл болон экспорт мэдэгдэхүйц өсөж, 1570 ажлын байр шинээр бий болжээ. 2018 онд нэхмэлийн бүтээгдэхүүний экспорт өмнөх оноос 22%-иар өсөж, нийт экспортын 6 орчим хувийг эзэлжээ¹³. 2021 он хүртэл үргэлжлэх Ноолуур хөтөлбөрийн хүрээнд нэхмэлийн салбар ойрын жилүүдэд өргөжин тэлэх хандлагатай байна.

3.2 БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


2018 оны байдлаар МУ-ын хэмжээнд нийт 17.1 их наяд төгрөгийн зээлийн эцсийн үлдэгдэл (арилжааны банкнуудад) байсан бөгөөд үүний 8% буюу 1.4 их наяд нь боловсруулах салбарын зээл байв. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт харьяалагдах 24 дэд салбар байх ба эдгээрийн нэг нь нэхмэлийн салбар юм (*Үндэсний статистикийн хорооны “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” ёсоор Боловсруулах үйлдвэрлэлд хүнсний бүтээгдэхүүн; ундаа; тамхины үйлдвэрлэл; ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх*

үйлдвэрлэл; хувцас үйлдвэрлэл; арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл; тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл; цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл; хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа; кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл; химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл; үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл; резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл; төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл; металл боловсруулах үйлдвэрлэл; машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл; компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл; цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл; дээр дурдсан дэд салбарт оороогүй бусад машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэл; моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл; тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл; тавилга үйлдвэрлэл; боловсруулах бусад үйлдвэрлэл; машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ багтана гэж заажээ).

Харин тухайн жилд олгосон нийт зээлийн 6%-ийг (1.3 их наяд ₮) боловсруулах салбарын хувийн хэвшилд олгожээ. Хэдийгээр дээрх үзүүлэлтүүд өнгөрсөн 5 жилийн хугацаанд харьцангуй тогтвортой байсан ч боловсруулах салбарын хувьд чанаргүй зээлийн үлдэгдэл тасралтгүй өсөж иржээ (Зураг 3.1). 1-5 хүртэл жилийн хугацаатай зээл нь салбарын нийт зээлийн 50 гаруй хувийг эзэлж ирсэн бол сүүлийн жилүүдэд 5 ба түүнээс дээш хугацаатай зээл 10 орчим хувийг бүрдүүлсэн бөгөөд үүний 70-80% нь төслөөр хэрэгжсэн зээл байна.

¹³ ¹³ “Ноолуур” хөтөлбөрийн 2018 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний [тайлан](#)

Зураг 3.1 Боловсруулах салбарын зээл, зээлийн төрлөөр (хувь)



Эх сурвалж: Арилжааны банкнуудын зээлийн тайлан, Монголбанк

Тайлбар: 2019* нь 7-р сарын байдлаарх тоо мэдээлэл

Боловсруулах салбарын хувьд төслөөр хэрэгжсэн зээлийн дүн харьцангуй өндөртэй салбарт орж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 2 жилд МУ-д төслөөр хэрэгжсэн нийт зээлийн үлдэгдлийн 35 орчим хувь буюу 472-522 тэрбум төгрөгийн зээл боловсруулах салбарт байна. Төслөөр хэрэгжсэн зээлийн чанар мөн ялгаагүй сүүлийн жилүүдэд муудах хандлага ажиглагдаж, 100 гаруй тэрбум төгрөгийн зээл нь хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээлүүдийн төрөлд багтжээ.

Хүснэгт 3.2 Төслөөр хэрэгжсэн зээл (сая төгрөг)

Зээлийн мэдээлэл	2017 он	2018 он	2019* он
Төслөөр хэрэгжсэн зээл	522,804	472,467	438,348
Салбарын зээлд эзлэх хувь	38%	33%	31%
Үүнд: Хугацаандаа байгаа зээл			
1 хүртэл жилийн	16,516	3,147	10,487
1-5 хүртэл жилийн	269,834	209,441	160,134
5 ба түүнээс дээш жилийн	121,883	137,451	111,856
Чанаргүй зээл	114,571	122,429	155,871

БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1. МОНГОЛЫН НЭХМЭЛИЙН САЛБАРЫН НОГООН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

4.1.1 Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн салбарт эзлэх байр суурь

Судалгаанд хамрагдсан нийт 6 бүрэн ба хагас цогцолбор үйлдвэрийн 1 нь 700 гаруй ажилчидтай том үйлдвэр, бусад 5 нь дунджаар 90 ажилчидтай; анхан шатны 5 үйлдвэрээс 1 нь 250, бусад 4 нь 10-80 ажилчидтай; сүлжмэлийн 6 үйлдвэрээс 1 нь 140, бусад 5 үйлдвэр нь 10-50 хүртэлх тооны үндсэн ажилчидтай буюу дийлэнх нь **жижиг, дунд үйлдвэрүүд** байв.

Хамгийн багадаа 40 үйлдвэрийг хамруулах зорилготой цахим асуулгад ердөө 6 үйлдвэр (15%) хариулсан бол дэлгэрэнгүй ярилцлага авахаар зорьсон 20 үйлдвэрээс 18 (90%) хамрагдаж, 17 нь ногоон санхүүгийн эрэлтийн тоон мэдээллийг бүрэн гүйцэт гаргаж өгсөн. Цахим асуулгад оролцсон 6¹⁴ үйлдвэрийн 4 нь дэлгэрэнгүй ярилцлагад хамрагдсан үйлдвэрүүд байв. Ногоон санхүүгийн эрэлт тодорхойлох товч асуулгаар нэмэлт 2 үйлдвэр мэдээлэл ирүүлсэн тул нийлбэр дүнгээр салбарын 22 үйлдвэр тус судалгаанд хамрагдсан байна.

Өөрөөр хэлбэл, бидний судалгаанд салбарын үйлдвэрүүдийн 20 орчим хувь¹⁵, үүнд цогцолбор үйлдвэрүүдийн 40%, анхан шатны 26%, сүлжмэлийн жижиг, дунд үйлдвэрүүдийн 17% тус тус хамрагджээ. Эдгээр үйлдвэрүүдийн 2018 оны үйлдвэрлэлийн хэмжээ, салбарт эзлэх

байр суурийг дамжлага тус бүрээр тооцоолсон байдлыг Хүснэгт 4.1-т үзүүлэв.

Хүснэгт 4. 1 Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээлд эзлэх байр суурь (2018 он)

	Угаасан ноолуур (т н)	Самнасан ноолуур (т н)	Ээрмэл (т н)	Нэхмэл (мян.м)	Сүлжмэл (мян.ш)
Салбарын нийт үйлдвэрлэл (2018)*	13,518.5	1,520.2	1,570.4	1,501.3	2,446.9
Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн дүн	1,637 (12%)	567 (37%)	230 (15%)	129 (9%)	754 (31%)
1. Цогцолбор, хагас цогцолбор үйлдвэр	178	157	211	129	524
2. Анхан шатны боловсруулах үйлдвэр	1,459	403	12		2
3. Сүлжмэлийн үйлдвэр		6	7		229

Эх сурвалж: Үйлдвэрүүд, МННХ, ХХАХҮЯ ба ҮСХ-ны мэдээлэлд үндэслэж тооцсон дүн.

* Салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг тогтоохдоо 2019 оны 11-12-р сард ХХАХҮЯ-ны захиалгаар МННХ гүйцэтгэсэн нэхмэлийн салбарын аттестат, судалгааны дүнг ашиглав.

¹⁴ Цахим асуулгад оролцсон 6 үйлдвэрт нийлбэр дүнгээр 18.5 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилтийн хэрэгцээ бий гэж тодорхойлсон. Ногоон санхүүжилтийн тухай нэгдсэн ойлголт хангалтгүй байсан тул эдгээр үйлдвэр хэт өндөр дүн өгсөн

гэж үзээд дэлгэрэнгүй судалгаанд оролцсон 17 үйлдвэрийн мэдээлэлд үндэслэж судалгааны үр дүнг гаргав.

¹⁵ Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг 150-200 жижиг цехийг оруулахгүй тохиолдолд

4.1.2 Ноос ноолуурын үйлдвэрүүдэд шаардлагатай ногоон санхүүгийн эрэлтийн тооцоолол

Ярилцлагад хамрагдсан **17 үйлдвэр өөрсдийн үйлдвэрлэлийг байгальд ээлтэй, ногоон болгоход нийт 24.5 тэрбум төгрөгийн эрэлт хэрэгцээ байна** хэмээн тооцоолов. Үүнээс 15.3 тэрбум төгрөг (62%) нь эрчим хүчний хэмнэлттэй холбоотой арга хэмжээнд, ялангуяа дулааны алдагдалгүй үйлдвэрлэлийн барилга, байгууламжтай болоход 10.7 тэрбум төгрөг (44%) хэрэгцээтэй гэжээ. Ус хэмнэх, усны бохирдлыг бууруулах арга хэмжээнд, ялангуяа цэвэрлэх байгууламж барих хэрэгцээ нь 4.1 тэрбум төгрөг буюу 17%-тай тэнцэнэ (Хүснэгт 4.2).

Ногоон санхүүгийн хэрэгцээ мөнгөн дүнгээр цогцолбор үйлдвэрүүдэд хамгийн өндөр буюу 14.3 тэрбум төгрөг (58.2%), анхан шатны үйлдвэрүүдэд 8.2 тэрбум төгрөг (33.3%) харин сүлжмэлийн үйлдвэрүүдэд харьцангуй бага буюу 2.1 тэрбум төгрөг (8.4%) байна.

Эдгээр ногоон санхүүгийн хэрэгцээ нь үйлдвэрлэлийн төрлөөс хамаарч ихээхэн хэлбэлзэж байна. Тухайлбал, цогцолбор үйлдвэрүүдийн хувьд дулааны хэмнэлттэй болох хэрэгцээ нь нийт ногоон санхүүгийн эрэлтийн 71%, сүлжмэлийн үйлдвэрүүдийн хувьд 19%, харин анхан шатны үйлдвэрүүдийн хувьд хамгийн бага буюу 3%-тай тус тус тэнцэж байна.

Цаашлаад, анхан шатны үйлдвэрүүдийн хувьд ногоон санхүүгийн 30 орчим хувь нь цэвэрлэх байгууламжид төлөвлөгдсөн бол сүлжмэлийн үйлдвэрүүдийн хувьд ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулах, эко сав баглаа боодолтой болох, хог хаягдлын менежментийг бий болгох, сайжруулах, үйлдвэрлэлийн хүчин чадлаа илүү ногоон дэвшилтэт технологи ашиглан өргөжүүлэх сонирхол, шаардлага 50 орчим хувийг эзэлж байна.

Нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд байгальд ээлтэй, тогтвортой, ногоон үйлдвэрлэл явуулахад ногоон санхүү, хөрөнгө оруулалтын үндсэн 7 дэд чиглэл, хэрэгцээ байгааг тодорхойлсныг Хүснэгт 4.2-с үзнэ үү.

Үндсэн 7 дэд чиглэлийн хүрээнд нийт 42 нэр төрлийн ногоон санхүүгийн хэрэгцээ байгааг тогтоосон бөгөөд хамгийн чухал зориулалтуудыг түүвэрлэн Зураг 4.1-д үзүүлэв (бүх 42 зориулалт тус бүрийн эрэлт ба нийт эрэлтэд эзлэх хувийг Хавсралт 6-д оруулав).

Цахим асуулга болон ярилцлага судалгаа аль алинд хамрагдсан үйлдвэрүүд ногоон санхүүгийн хэрэгцээгээ гаргахдаа өөр өөр дүнгүүд тооцоолж өгсөн. Цахим асуулгаар тодорхойлсон ногоон санхүүгийн хэрэгцээт хэмжээ ярилцлага хийх замаар цуглуулсан дүнгээс ямагт өндөр байв. Цахим асуулгад хариулахдаа үйлдвэрүүд шаардлагатай бусад санхүүжилтийн дүнг нэмж оруулсан эсвэл ногоон ангилалд багтахгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээг нэмж тооцсонтой холбоотой гэж үзээд нэхмэлийн салбарын жижиг дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн нийт эрэлтийг тогтоохдоо **ярилцлагад хамрагдсан 17 үйлдвэрийн бодит хэрэгцээнд** үндэслэв.

Ингээд, 2019 оны III улирлын байдлаар, судалгаанд хамрагдсан 17 үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал, зах зээлд эзлэх байр сууриар төлөөлүүлж тооцоод **салбарын ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр нийт 250 тэрбум төгрөгтэй** тэнцэнэ гэж тогтоов.

Хүснэгт 4. 2 Судалгаанд оролцсон 17 үйлдвэрийн ногоон санхүү, хөрөнгө оруулалт ын хэрэгцээг үндсэн 7 дэд чиглэлээр ангилсан нь

Ногоон санхүүгийн зориулалтууд	Шаардлагатай нийт санхүүжилт		Цогцолбор, хагас цогцолбор үйлдвэрүүд		Анхан шатны боловсруулах үйлдвэрүүд		Сүлжмэлийн үйлдвэрүүд	
	Сая ₮	Хувь	Сая ₮	Хувь	Сая ₮	Хувь	Сая ₮	Хувь
БҮГД	24,486	100%	14,257	100%	8,161	100%	2,068	100%
1. Эрчим хүч хэмнэлтийн	15,286	62%	10,602	74%	4,126	51%	558	27%
Үүнд:								
Цахилгаан	4,374	18%	445	3%	3,769	46%	161	8%
Дулаан	10,685	44%	10,052	71%	237	3%	396	19%
Уур	227	1%	106	1%	121	1%	1	0%
2. Ус хэмнэлтийн	4,899	20%	2,124	15%	2,590	32%	185	9%
Үүнд: Цэвэрлэх байгууламж барих	4,140	17%	1,887	13%	2,254	28%	-	-
3. Хог хаягдлын менежментийн	284	1%	34	0.2%	38	0.5%	213	10%
4. Химийн бодисын хэрэглээг бууруулах, эко болгох	8	0.03%	-	-	-	-	8	0.4%
5. Нийгмийн асуудал сайжруулах	1,659	7%	634	4%	589	7%	436	21%
6. Үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилготой тоног төхөөрөмж авах	1,008	4%	130	1%	600	7%	278	13%
7. Бусад	1,342	5%	734	5%	218	3%	390	19%
Үүнд: Эко сав, баглаа боодол	606	2%	289	2%	-	-	317	15%

Үүний зэрэгцээ, Монгол улсын хөгжлийн стратеги, ноос ноолуур боловсруулах салбарт баримтлах үндэсний бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулан ойрын ирээдүйд нэхмэлийн салбарт шаардлагатай болох ногоон санхүүгийн зорилтот эрэлтийг тодорхойлов. 2018 оны 2-р сард батлагдсан “Ноолуур” хөтөлбөр нь 2018-2021 оны хугацаанд хэрэгжих бөгөөд тус хөтөлбөрт “...түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэнэ”, мөн “...сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2021 онд 2.200 мянган ширхэг”-т хүргэнэ хэмээн салбарын үйлдвэрлэлийн зорилтот түвшнийг тус тус тогтоосон. Салбарын өнөөгийн

боловсруулалтын түвшин ба хэмжээг “Ноолуур” хөтөлбөрт тусгагдсан зорилтот боловсруулалтын түвшин ба бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээтэй харьцуулан, тооцоолуураар үржүүлэн 2021 он гэхэд **Монголын нэхмэлийн салбарт шаардлагатай ногоон санхүүгийн эрэлт зорилтот төсөөллөөр нийт 575.9 тэрбум төгрөгтэй тэнцэнэ** гэж тооцоолов.

Хүснэгт 4.3 Нэхмэлийн салбарын ногоон санхүүгийн эрэлт ийн шинжилгээ

Сая төгрөг

Нэхмэлийн салбарын ногоон санхүүгийн эрэлтийн шинжилгээ	САЛБАРЫН ЭРЭЛТ		ТОДОРХОЙЛСОН БОДИТ ЭРЭЛТ	
	Бодит төсөөлөл	Зорилтот төсөөлөл	17 үйлдвэр (ярилцлага)	4 үйлдвэр (асуулга)
НИЙТ	250,038	575,977		
Нийлбэр дүн, эрэлт	247,266	573,205	24,486	
Цогцолбор үйлдвэр	159,263	485,201	14,257	
Анхан шатны үйлдвэр	57,055	57,055	8,161	
Сүлжмэлийн үйлдвэр	30,949	30,949	2,068	6,083

‘Ноолуур’ хөтөлбөр (2018-2021)-ийн зорилтот түвшинд тулгуурлаж гаргасан тооцоолуур

Бүрэн боловсруулалтыг 60%-д хүргэх

60%

5.0¹⁶


Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл

2,200,000

1.0

Ноолуурын бүрэн боловсруулалт 12% (2017 он)


12%



W

¹⁶ Түүхий эд бэлтгэлийн нөөц харьцангуй тогтвортой үргэлжилнэ гэж үзэв

Зураг 4.1 Сүдэлгаагаар тогт оогдсон ногоон санхүүгийн бодит эрэлт ба зориулалт үүд (сая т өгрөг)



4.1.3 Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн нэн тэргүүний зориулалт

Ногоон санхүүгийн 42 зориулалтыг нэн тэргүүний, өндөр ач холбогдолтой байдлаар эрэмбэлэв. Үүний тулд хэдэн үйлдвэр тус зориулалтыг хэрэгцээтэй хэмээн үзэж хүсэлт гаргасан давтамж, мөн эрэлтийн нийлбэр үнийн дүнг ашигласан болно, Зураг 4.2.

Зураг 4.2 Ногоон санхүүгийн нэн тэргүүний зориулалт үүд (хүсэлт гаргасан давт амж, эрэлт ийн нийлбэр үнийн дүнгээр)



Салбарын үйлдвэрүүд эрчим хүчний хэмнэлттэй дулааны алдагдалгүй барилга, бохир усны цэвэрлэх байгууламж, орчны тохижилт, усны нөөцийн сав болон эко сав баглаа боодолтой болоход ногоон санхүү нэн тэргүүнд хэрэгцээтэй байна хэмээн үзжээ. Тухайлбал, ярилцлагад хамрагдсан 4 үйлдвэр цэвэрлэх байгууламжийн талаар тодорхой

хэмжээний судалгаа хийж, үнэ өртгийн мэдээлэл авсан байсан ч санхүү, хөрөнгө оруулалтын асуудлаа шийдэж чадаагүй байв. Үүнээс гадна, жишээ нь ус зөөлрүүлэгч төхөөрөмж мөнгөн дүнгээр нийт ногоон санхүүгийн эрэлтэд бага хувийг эзлэх хэдий ч байгалийн нөөцийг хэмнэх (ус, химийн бодисын хэрэглээг бууруулах) өндөр ач холбогдолтой тул нийт үйлдвэрүүдийн 50-с дээш хувь нь ус зөөлрүүлэгч төхөөрөмж суурилуулах, шинээр авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн болно.

Дээрх зориулалтуудаас гадна, анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийн хувьд эцсийн ба дамжлага дундын бүтээгдэхүүний баглаа, шуудай савыг олон дахин хэрэглэх боломжтой, чанартай, удаан эдэлгээтэй, эко буюу даавуун, тааран шуудайгаар орлуулах сонирхол өндөр байсан бол сүлжмэл болон цогцолбор үйлдвэрүүдийн хувьд гялгар уутны хэрэглээг бууруулж, эцсийн бүтээгдэхүүний борлуулалтад цаасан, даавуун сав баглаа, боодол ашигладаг болох сонирхол, хэрэгцээ өндөр хэмээн тодорхойлжээ.

Ногоон санхүүд багтахгүй ч салбарын жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хувьд хамгийн нэн тэргүүний санхүүгийн хэрэгцээ бол жилийн жилд түүхий эд бэлтгэл, татан авахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийн асуудал байв. Ноолуур бэлтгэл нь богино хугацаанд хийгддэг, өрсөлдөөн өндөртэй, их хэмжээний хөрөнгө мөнгө шаарддаг онцлогтой тул “Ногоон зээл”-ийг уг зориулалтаар ашиглах боломжтой эсэхийг олон үйлдвэрлэгчид тодруулан асууж байсныг энд дурдах нь зүйтэй.

4.1.4 Ноос, ноолуурын үйлдвэрүүдийн ногоон санхүүжилт, ногоон зээлийн талаарх ойлголт

Судалгаанд хамрагдсан бүх үйлдвэрүүдэд ногоон санхүүжилт, ногоон зээлийн талаарх ойлголт бага, мэдээлэл дутмаг байна.

- Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэл эрхлэх гэдгийн дор цэвэр ус, бохир ус, цахилгаан,

дулаан, химийн бодисын хэрэглээ, эдгээрт зарцуулах зардлаа бууруулах, нөөцийн үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх, хаягдал багатай үйлдвэрлэл, хаягдал нь байгаль орчин болон хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх, бага зардлаар өндөр бүтээмжтэй ажиллах багтана гэж хариулжээ.

- Ногоон үйлдвэрлэл эрхлэх нь уламжлалт, энгийн, ногоон биш үйлдвэрлэлтэй харьцуулахад богино хугацаандаа зардал өндөртэй, өндөр санхүүжилт шаардагдах чиг хандлагатай гэж үйлдвэрүүд үзэж байна.
- Ногоон үйлдвэрлэлийн тухай ойлголт байгаа ч “Ногоон санхүүжилт” гэдэгт яг ямар зориулалтын хөрөнгө оруулалт, санхүүг багтаах талаарх ойлголт хязгаарлагдмал байна.
- Ус, уур, цахилгааны хэмнэлттэй тоног төхөөрөмж худалдан авах, нар ба салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй болох, дулаан алдагдал багатай үйлдвэрийн барилга байгууламжтай болох, цэвэрлэх байгууламж барих зэрэг үйл ажиллагаанд Ногоон санхүүжилтийг олгоно гэсэн анхан шатны хүлээлт үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд байна.

4.1.5 Байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлуудад хандах хандлага

- Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүд 100 хувь байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой, эерэг байр суурь, хандлагатай байгаагаа илэрхийлжээ. Гэвч тэдгээрийн дийлэнх буюу 80 орчим хувь нь байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл эрхлэхэд чиглэсэн ямар нэгэн үйлдэл, санаачилга, үйл ажиллагаа авч хэрэгжүүлээгүй хэмээн мэдэгдэв.
- Салбарын үйлдвэрүүд үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа ногоон болгох хүсэл, хандлагатай нь сайшаалтай хэдий ч бодит ажил болгож чадаагүй үндсэн хоёр шалтгаан бий гэж үзэж байна.

Нэгдүгээрт, байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл эрхлэхэд юуг анхаарч ажиллах, ямар санаачилга, ажил хэргүүдийг хэрэгжүүлбэл зохистой тухай мэдлэг, ойлголт хязгаарлагдмал байна. Хоёрдугаарт, 10-аас 30 ажилтантай жижиг үйлдвэрүүдийн хувьд үйлдвэрлэл үйл ажиллагааны зардлыг хэмнэсэн, эсвэл компанийн ашгийг шууд нэмэгдүүлэхэд тустай санхүүжилт биш л бол бусад төрлийн хөрөнгө оруулалт хийх боломж, сонирхол алга байна. Өөрөөр хэлбэл, ийм үйлдвэрүүд байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахын тулд өндөр хүүтэй, олдоц муутай, “хөөцөлдөхөд” хүн хүч болон цаг хугацаа ихээр шаардагддаг зээл авч санхүүжилт хийх сонирхол болон ямар нэг хөшүүрэг байхгүй; зөвхөн өөрийн хөрөнгөөр (тийм боломж байдаг бол) урт хугацаанд, шат дараалалтай хөрөнгө оруулалт хийж, сайжруулахыг илүүд үзэж байна.

- Тогтвортой хөгжлийн үндсэн тулгууруудын нэг болох нийгмийн асуудлууд (жишээ нь ажлын байрны эрүүл ахуй, тав тухтай, аюулгүй байдлыг сайжруулах г.м.)-ыг сайжруулах, шийдвэрлэхэд зарцуулсан санхүүжилт нь ногоон санхүүд багтах хүчин зүйл гэдгийг үйлдвэрүүд тэр бүр мэдэхгүй байна.

4.1.6 Ногоон санхүүжилт, ногоон зээл авахаар хандаж байсан туршлага, ирээдүйн чиг хандлага

- Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдээс ногоон санхүүжилт, ногоон зээлийн хүсэлт гаргаж банк, санхүүгийн байгууллага, олон улсын байгууллагуудад хандсан тохиолдол үгүй байна. Ерөнхий тохиолдолд, ноос, ноолуур боловсруулах салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүд “Ногоон зээл” авч байсан түүх, оролдлого маш бага байна гэж дүгнэж болно.

- Судалгаанд оролцсон 17 үйлдвэрийн 8 нь арилжааны банкны зээлтэй, эдгээрийн 4 нь төслийн зээл байлаа. Мэдэгдэж байгаагаар 5 үйлдвэр нийлбэр дүнгээр 7 гаруй тэрбум төгрөгийн зээл авахаар судалж, материалаа өгсөн ба 4 нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах зорилготой “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн зээл, 1 нь ЖДҮ-г хөгжүүлэх сангийн зээл байв. Эдгээр зээлийн гол зориулалтууд нь эргэлтийн хөрөнгө, үйлдвэрийн байр өргөтгөх, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой тоног төхөөрөмж худалдан авах гэсэн үндсэн гурван чиглэлд зарцуулагдахаар төсөвлөгджээ.
- Байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэл эрхлэхэд ногоон санхүүжилт, зээлийн шаардлага, хэрэгцээ байгаа талаар судалгаанд хамрагдсан бүх үйлдвэрийн төлөөллүүд хариулсан болно.

4.1.7 Үйлдвэрүүдийн хувьд банкны зээл авахад тулгардаг саад, бэрхшээлүүд

- Үйлдвэрүүдийн хувьд арилжааны банкны (төслийн болон бусад) зээлд хамрагдахад учирдаг хамгийн том бэрхшээл бол зээлийн хүү хэт өндөр байх, зээлийн хугацаа хэт богино байх гэж хариулжээ.
- Судалгаанд хамрагдсан 17 үйлдвэрээс 4 нь барьцаа хөрөнгийг бэрхшээлтэй асуудал мөн гэж хариулсан бөгөөд тэдний хувьд нийтлэг зүйл нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүд байв. Түүнчлэн, зээл хүсэгч аль нэг банканд барьцаа хөрөнгөө тавьсан тохиолдолд өөр банкнаас зээл хүсэх тохиолдолд асуудал үүсдэг гэжээ.
- Жилд нэг тохиох түүхий эдийн худалдан авалтын үеэр хөрөнгө мөнгө, санхүүгийн хэрэгцээ их тулгардаг, энэ үед санхүүжилтээ шийдэж чадаагүй үйлдвэр түүхий эдийн хомсдолд орох эрсдэл үүсдэг байна.
- Нийтлэг биш ч тодорхой давтамжтай үүсдэг саад, бэрхшээлүүд:
 - Төслийн зээлд хамрагдахад бүрдүүлэх бичиг баримт олон, жижиг үйлдвэрүүдийн хувьд шаардлага өндөр ба хүндрэлтэй, чирэгдэл их байсан тул зээлийн хүсэлт гаргаж чадаагүй;
 - Ноос ноолуурын компаниудын орлого зарлага бусад салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжээс ялгаатай, улирлын хэлбэлзэл ихтэй байдаг. Хавар ноолуур самнах үед өндөр үнэтэй түүхий эдээ бэлтгэдэг тул их хэмжээний зардал гаргана. Зуны улиралд үйлдвэрлэл явуулж үйл ажиллагаагаа санхүүжүүлнэ. Намар үйлдвэрлэл явуулахын зэрэгцээ бэлэн болсон бүтээгдэхүүнээ агаарын, газрын болон далайн тээврээр захиалагчид хүргүүлнэ (хэрэв экспорт хийдэг бол). Ингээд хүйтний улиралд буюу намрын адаг, өвлийн эхэн үед ноос ноолууран бүтээгдэхүүний борлуулалт идэвхэждэг. Иймд, дотоодын болон экспортын борлуулалтын орлого бүтэн жил дамжин, дараа жилийн хавар компанид орж ирэх тохиолдол элбэг байдаг. Зээлийн эргэн төлөлт тогтвортой, тогтмол байх шаардлага тавьдаг банкнуудад дээрх хэлбэлзэл нь өндөр эрсдэлтэйд тооцогддог. Салбарын үйлдвэрүүдийн хувьд мөнгөний үрсгалыг зөв тооцоолох, санхүүгийн төлөвлөлтийг орлого зарлагатайгаа уялдуулан хийж сурах хэрэгцээ бий;
 - Үйлдвэр, компанийн гадаад хөрөнгө оруулагч, хамтран эзэмшигчид Монголын арилжааны банкны зээлийн хүүг

өндөр, зээлд хамрагдах нь өндөр эрсдэлтэй гэж үздэг тул ямар ч төрөл, зориулалтын зээл авах сонирхол бага байдаг.

4.1.8 “Ногоон зээл”-ийн нөхцөл, шаардлагын талаарх үйлдвэрүүдийн хүлээлт

- Үйлдвэрүүд “Ногоон зээл”-ийн нөхцөл, шаардлагад дараах хүчин зүйлсийг заавал тусгах хэрэгтэй гэж үзсэн, үүнд:
 - Түүхий эд бэлтгэл, татан авалтаас эхлээд эцсийн борлуулалт хүртэлх орлого, зарлагын өвөрмөц мөчлөгтэй, улирлын онцлог шинж чанартай салбар тул зээлийн эргэн төлөлтийн графикт үүнийг тусгах;
 - Байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэл явуулах нь энгийн, уламжлалт үйлдвэрлэлтэй харьцуулахад богино, дунд хугацаанд илүү их хэмжээний санхүүжилт шаарддаг;
 - Тус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг тул дагалдах нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх санхүүжилтийг багтаах, анхаарал хандуулах (үйлдвэр, аж ахуйн нэгжийн дэргэд цэцэрлэг, өдөр өнжүүлэх байгуулах, эрүүл мэндийн үзлэг, сувиллыг дэмжих гэх мэт).
- Судалгаанд хамрагдсан анхан шатны 2 үйлдвэрийн өгсөн мэдээлэл ёсоор ногоон тодотголд багтах цэвэрлэх байгууламжийн өртөг нь энгийн цэвэрлэх байгууламж барих өртгөөс 30-50%-ийн илүү зардалтай, харин дулааны алдагдалгүй, цахилгаан, усны хэмнэлттэй ногоон барилга, байгууламж нь ойролцоогоор 20%-аар илүү өртөгтэй байна.¹⁷

- Байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэлийг дэмжих ногоон санхүүжилт нь богино, дунд хугацаанд зардлыг ихэсгэж ашгийг бууруулах тул бусад зээлтэй харьцуулахад илүү урт хугацаатай, бага хүүтэй байх хэрэгтэй гэж үйлдвэрүүд үзэж байна. Гэсэн хэдий ч ногоон үйлдвэрлэл нь урт хугацаандаа үр ашигтай, хэмнэлттэй гэдгийг үйлдвэрүүд ойлгож, эерэг ханддаг байна.
- Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн 80 гаруй хувь нь ямар нэг төслийн зээлд хамрагдаж байсан эсвэл хамрагдах хүсэлтээ өгсөн туршлагатай бөгөөд жилийн 12-13%-ийн хүүтэй төслийн зээлийг үйлдвэрүүдийн хувьд өндөр хүүтэй гэж үзэж байна. Харин Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн жилийн 8%-ийн хүүтэй зээлийг боломжийн гэж үзэж буйгаа илэрхийлжээ.
- Нэхмэлийн салбарын Ногоон зээлийн бүтээгдэхүүн жилийн 3-8% хүүтэй, харин зээлийн хугацаа нь аль болох урт буюу хамгийн багадаа 5 жил байвал үйлдвэрлэгчдийн хувьд таатай зээлийн нөхцөл үүснэ хэмээн ярилцлагад хамрагдсан үйлдвэрүүдийн 90 гаруй хувь нь онцлов.

¹⁷ Уг 20%-ийн санхүүгийн нэмэгдэл, зөрүүг ногоон барилгатай байснаар хэмнэх эрчим хүчний хэрэглээний зардлаар тооцвол 15 жилийн дараа нөхөгдөх тооцоо гарсныг ярилцлагад хамрагдсан төлөөллүүдийн нэг онцолсон.

4.2 НОГООН САНХҮҮГИЙН НИЙЛҮҮЛЭЛТ, БОЛОМЖИТ ЭХ ҮҮСВЭРҮҮД

4.2.1 Мэдээллийн эх сурвалж, хамрах хүрээ

Ногоон санхүүгийн нийлүүлэлтийн судалгаанд үндсэн 3 мэдээллийн эх сурвалжийг ашиглав, үүнд:

- 1) Арилжааны банкнуудаас авсан ногоон зээлийн бүтээгдэхүүний судалгаа,
- 2) Ногоон санхүүтэй холбоотой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудаас авсан мэдээлэл,
- 3) Суурь судалгааны мэдээлэл багтана.

Арилжааны банкнуудын ногоон зээлийн бүтээгдэхүүний судалгаанд нийт 13 банкнаас 10 нь хариу ирүүлсэн. Эдгээр 10 банкнаас 4 нь ногоон зээлийн бүтээгдэхүүн байхгүй эсвэл нэхмэлийн салбарт олгосон зээлийн түүх байхгүй тул тоон мэдээлэл өгөх боломжгүй байсан бөгөөд судалгааны үр дүнг мэдээлэл өгсөн 6 банкны хариулт дээр тулгуурлан гаргасан. Тус судалгааны асуулгыг Хавсралт дахь Асуулга 2-оос харж болно.

Арилжааны банкнуудаас гадна дараах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудаас холбогдох тоон мэдээллийг цуглуулсан, үүнд:

- ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн нэгж
- Сангийн Яам
- МТЭХСҮ төслийн нэгж
- АХБ-ны ХААХХ төслийн нэгж
- МУХБ-ны Зээлийн Газар
- Органик Монгол төслийн нэгж
- Зээлийн Батлан Даалтын Сан
- ЖДҮХС-ийн Зээлийн удирдлагын хэлтэс

Судалгаанд нийт 5 бүлэгт хамаарах 26 зээлийн бүтээгдэхүүнийг хамруулан авч үзлээ, үүнд:

1. ААН-д зориулсан ногоон зээл:

- 1) Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилтийн Үйлчилгээ (МТЭХСҮ) төслийн зээл
- 2) ЯОУХАБ (JICA)-ын 2 үе шаттай зээлийн хөтөлбөр (TSL)-ийн 2-р үе шат: байгаль орчныг хамгаалах
- 3) Органик Монгол хөтөлбөрийн зээл
- 4) Хас банкны Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор олгох бизнесийн зээл
- 5) БОАЖЯ – Аялал жуулчлалын салбарын ногоон зээл

2. Иргэдэд зориулсан ногоон зээл:

- 6) БОАЖЯ – Иргэдэд зориулсан ногоон зээл
- 7) ХААН Банк: Иргэдэд зориулсан ногоон зээл
- 8) Төрийн Банк: Ногоон зээл
- 9) Ариг Банк: Эко автомашины зээл
- 10) ХХБанк: Эко автомашины зээл
- 11) Капитрон Банк: Цахилгаан дугуйны зээл
- 12) Транскапитал ББСБ: Ногоон зээл

3. ЖДҮ-д чиглэсэн зээл (ногоон гэж заагаагүй):

- 13) Ноолуур хөтөлбөрийн зээл
- 14) Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийн зээл
- 15) Германы КФВ банкны ЖДҮ-г дэмжих төслийн зээл
- 16) Азийн Хөгжлийн Банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл
- 17) Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангийн зээл
- 18) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээл

- 19) “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээл
- 20) Банк бус санхүүгийн байгууллагуудын бизнесийн зээл
- 21) ЯОУХАБ (JICA)-ын 2 үе шаттай зээлийн хөтөлбөр (TSL)-ийн 2-р үе шат: ЖДҮ-ийг дэмжих

4. Олголт нь зогсонги байгаа ногоон зээл:

- 22) Ногоон зээлийн баталгааны сан
- 23) Хас Банкны Хүлэмжийн хийг бууруулахад зориулсан орон сууцны зээл
- 24) Хас Банкны Эко автомашины зээл

5. Олгогдож эхлээгүй байгаа ногоон зээл:

- 25) Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл
- 26) Switch-Off Air Pollution буюу “Дулаан шийдэл” төсөл


4.2.2 Боломжит ногоон санхүүгийн нийлүүлэлтийн тооцоолол

Ногоон санхүүгийн нийлүүлэлтийн тооцоонд судлагдсан 5 бүлэг зээлийн бүтээгдэхүүн дотроос 1) Аж ахуйн нэгжүүдэд зориулсан ногоон зээл ба 2) Нэхмэлийн салбарт чиглэсэн, нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчид авч болох ЖДҮ-д зориулсан (ногоон байх ёстой гэсэн заалт, шалгуургүй) зээлийн бүтээгдэхүүнүүд гэсэн 2 бүлэг зээлийн бүтээгдэхүүнийг багтаав. Учир нь бусад 3 бүлэг буюу олголт нь зогссон эсвэл эхлээгүй байгаа, иргэдийн хэрэглээнд зориулагдсан ногоон

зээлийн бүтээгдэхүүнүүд нь нэхмэлийн салбарын зээлийн нийлүүлэлт гэдэгт агуулга, зориулалтад тохирохгүй гэж үзэв.

Дээрх үндэслэлээр **зээлийн боломжит эх үүсвэрийн хэмжээгээр нийт нийлүүлэлтийг 514 тэрбум төгрөг** байна тооцов.¹⁸

Зураг 4.3 Нэхмэлийн салбарын ногоон зээлийн боломжит эх үүсвэрийн нийлүүлэлт



Нэхмэлийн салбарын жижиг, дунд үйлдвэр, ААН-үүд авах боломжтой зээлийн нийт боломжит нийлүүлэлтийг 75 тэрбум төгрөг, үүнд ААН-д зориулсан ногоон зээлүүд дотроос дараах 3 зээлийн бүтээгдэхүүнийг хамруулсан болно.

- ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээл

¹⁸ Энэ нь зээлийн нийт эх үүсвэрээс олгогдсон зээлийн дүнг хассан, олгогдоогүй байгаа боломжит эх үүсвэрийн хэмжээ юм

- МТЭХСҮ төслийн зээл
- Хас Банкны Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээл

Учир нь судлагдсан бүх бүтээгдэхүүн дотроос эдгээр 3 бүтээгдэхүүн л “нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчид авах боломжтой”, “ногоон” зээлд хамаарч байгаа юм. Одоогийн байдлаар, ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээлээс нэхмэлийн салбарын 1 ААН 150 сая төгрөгийн зээл авсан байгаа бол бусад зээлийн бүтээгдэхүүнээс нэхмэлийн салбарын нэг ч ААН зээл аваагүй байна.

ААН-д зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнд дээрх 3 бүтээгдэхүүнээс гадна Органик Монгол хөтөлбөрийн зээл болон БОАЖЯ-наас гаргасан аялал жуулчлалын салбарын ногоон зээл багтах бөгөөд нийт боломжит эх үүсвэр нь 37 тэрбум төгрөг байна.

ЖДҮ-д чиглэсэн ногоон биш зээлүүдийн хувьд ногоон зээлтэй харьцуулахад боломжит эх үүсвэр их буюу 402 тэрбум төгрөг байгаагаас гадна нэхмэлийн салбарын ААН-үүд харьцангуй их зээл авсан буюу 118 ААН нийт 298.4 тэрбум төгрөгийн зээл авсан байна.¹⁹

4.2.3 Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдийн тойм, бүлгээр

1. ААН-д зориулсан ногоон зээл | Энэ бүлгийн 5 бүтээгдэхүүний хүрээнд анхны эх үүсвэр нь 238 тэрбум төгрөг байснаас одоогийн байдлаар 112 тэрбум төгрөгийн боломжит эх үүсвэр байна. Энэ эх үүсвэр нь гадаад, дотоодын хэд хэдэн байгууллагын эх үүсвэрүүдээс санхүүжиж байна. Тухайлбал, МТЭХСҮ төслийн зээлийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, 2 үе шаттай төслийн зээлийг Японы Олон Улсын Хамтын

Ажиллагааны Байгууллага санхүүжүүлж байна. Органик Монгол хөтөлбөрийн хувьд Макс Групп, Петровис зэрэг дотоодын компаниудаас санхүүжилтээ авдаг. Харин Аялал жуулчлалын салбарын ногоон зээлийг БОАЖЯ-аас санаачилж банкуудын эх үүсвэрээс олгох бол Хас Банкны хүлэмжийн хийг бууруулах зээлийн эх үүсвэр Уур амьсгалын ногоон сан тэргүүтэй гадаад эх үүсвэрүүдээс бүрддэг. Энэ бүлгийн бүтээгдэхүүнүүдийг ХААН, Хас, Голомт, ХХБ, УБХБ зэрэг 5 банк санал болгож байна. Хэрэгжиж эхэлсэн хугацааны хувьд 2 үе шаттай төслийн 1-р үе шат 2006 онд, Органик Монгол 2009 онд, 2 үе шаттай төслийн 2-р үе шат 2011 онд, хүлэмжийн хийг бууруулах зээл 2013 онд, МТЭХСҮ төслийн зээл 2014 онд, аялал жуулчлалын салбарын ногоон зээл хамгийн сүүлд буюу 2019 оны 8-р сараас хэрэгжиж эхэлсэн.

2. Иргэдэд зориулсан ногоон зээл | Энэ бүлэгт 5 арилжааны банк, 1 ББСБ-ын өөрсдийн эх үүсвэрээр олгож буй ногоон зээл, мөн БОАЖЯ-аас санаачлан гаргасан ногоон зээл багтаж байна. Эдгээр бүтээгдэхүүнүүдийн хүрээнд нийт 15 тэрбум орчим төгрөгийн зээл олгогдсон байна. ХААН Банкны ногоон зээл 2017 онд, ХХБ-ны ногоон зээл 2018 онд анх гарсан бол бусад зээлүүдийн хувьд 2019 онд шинээр гарсан бүтээгдэхүүн байна. Эдгээр зээлийн зориулалт нь эко тээврийн хэрэгсэл, орон сууц, хэрэглээний бараа болон дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж зэрэг байна.

3. ЖДҮ-д чиглэсэн зээл (ногоон гэж заагаагүй) | Энэ бүлэгт нэхмэлийн салбарт чиглэсэн болон нэхмэлийн салбарт олгогдох боломжтой 9 зээлийн бүтээгдэхүүнийг хамруулсан бөгөөд тэдгээрийн анхны нийт эх үүсвэр нь 963.4 тэрбум төгрөг байснаас одоогийн боломжит эх үүсвэр нь 402 тэрбум төгрөг байна. Уг эх үүсвэр нь гадаад, дотоодын олон эх

¹⁹ Нэхмэлийн салбарын зээлийн мэдээлэл нь зөвхөн “Ноолуур хөтөлбөр”, “ХААХХ төслийн зээл”, “ЗБДТДЗЭЗТАЭНТ-ийн зээл”-ийн мэдээлэл болно.

үүсвэрээс бүрдэж байна. Тухайлбал, АХБ-аас 3 зээлийн бүтээгдэхүүн, Германы КФВ банкнаас 1 зээлийн бүтээгдэхүүн, ЯОУХАБ-аас 1 зээлийн бүтээгдэхүүн санхүүжилтээ авж, нийт 5 зээлийн бүтээгдэхүүн гадаадын эх үүсвэртэйгээр олгогдож байна. Харин үлдсэн 3 зээлийн бүтээгдэхүүнийг МУХБ, ЖДҮХС, ХЭДС зэрэг дотоодын эх үүсвэрүүд санхүүжүүлж байна. Эдгээр бүтээгдэхүүнийг нийт 11 арилжааны банк болон МУХБ-аас олгож байна. Хэрэгжиж эхэлсэн хугацааны хувьд, ХЭДС-ийн жижиг зээл 2002 онд, 2 үе шаттай төслийн 1-р үе шат 2006 онд, ЖДҮХС-ийн зээл 2009 онд, 2 үе шаттай төслийн 2-р үе шат 2011 онд, ХААХХ төслийн нэмэлт санхүүжилт болон ЗБДТДЗЭЗТАЭН төслүүд 2016 онд, Ноолуур хөтөлбөр хамгийн сүүлд буюу 2018 онд хэрэгжиж эхэлсэн.

4. Олголт нь зогсонги байгаа ногоон зээл | Энэ бүлэгт Хас Банкны эко орон сууцны зээл болон эко машины зээл, мөн ногоон зээлийн баталгааны сан багтаж байна. Эдгээр зээлүүд олгогдож байх хугацаанд нийт 12.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. 2006 онд байгуулагдсан ногоон зээлийн баталгааны сангийн хувьд 2007-2009 онд үйл ажиллагаа явуулсан бөгөөд тухайн үед 385 сая төгрөгийн баталгаа гаргаж байжээ.

5. Олгогдож эхлээгүй байгаа ногоон зээл | Энэ бүлэгт Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл болон Switch-Off Air Pollution буюу “Дулаан шийдэл” төслүүд багтсан. Эдгээр төслүүд хэрэгжиж эхэлсэн боловч ногоон санхүүжилт олгох үйл ажиллагаа нь эхлээгүй байгаа юм. Ногоон орон сууцны төслийн хувьд санхүүжилтийн эх үүсвэр нь Уур Амьсгалын Ногоон Сан, Өндөр Түвшний Технологийн Сан, Азийн Хөгжлийн Сан зэрэг бөгөөд нийт 202 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ногоон зээлд зарцуулахаар төлөвлөж байна.

Судлагдсан бүх зээлийн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй тойм мэдээллийг бүлэг бүлгээр нь багцлан Хавсралт 2-д оруулав.

4.2.4 Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдэд байгаль орчин, нийгэм, тогтвортой хөгжлийн асуудал хэрхэн туссан байдал, тэдгээрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө

Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдийн ихэнх нь байгаль орчин, нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр тусгасан байна. Ерөнхийдөө, ногоон зээлүүдийн хувьд хүлэмжийн хийн ялгарал, агаар, хөрсний бохирдол, эрчим хүчний хэмнэлт ба үр ашиг гэх мэт байгаль орчны асуудлуудад зорилго нь чиглэгдэж, зарим төслийн хувьд хүрэхээр төлөвлөсөн үр дүн нь тоогоор илэрхийлэгдэж байна. Харин ногоон биш зээлүүдийн хувьд ихэнхдээ ажлын байр, ядуурал гэх мэт нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгддэг боловч, Ноолуур хөтөлбөр, ЖДҮХС-ийн зээл гэсэн 2 бүтээгдэхүүн дээр байгаль орчны асуудал нэмж хөндөгдсөн байна. Хэрэгжиж эхлээгүй байгаа ногоон санхүүжилтийн 2 төсөл дээр үндсэн байгаль орчны зорилтуудаас гадна хүмүүсийн амьдрах орчныг сайжруулах, эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжих, хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг нийгмийн асуудлууд хөндөгдсөн байна. Түүнчлэн, зарим төслийн хувьд байгаль, нийгэмд хор үршигтай үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх замаар байгаль орчин, нийгмийн асуудлыг хөнджээ.

ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН	БО, НИЙГЭМ, ТХ АСУУДЛЫГ ТУСГАСАН ЭСЭХ	БО, НИЙГЭМ, ТХ-Д ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ
JICA - TSL ТӨСӨЛ	Уул уурхай, архи тамхи, зугаа цэнгэл, цэрэг дайн, БО-д сөрөг ү/а санхүүжүүлэхгүй	36.8 сая квт.ц эрчим хүч, 55.5 мян тонн нүүрс, 134 мян тонн CO2 жил бүр бууруулсан 3577 шинэ а/байр үүсгэсэн, үүнийг дагаад 34.3 тэрбум төг жилийн орлого үүснэ, 14308 хүний амьжиргааг сайжруулна
EBRD - MONSEFF ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахыг дэмжсэн	107.5 сая квт.ц эрчим хүч, 28.5 мян тонн CO2 жил бүр бууруулсан
ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ	Органик Монгол хөтөлбөрийн зорилго: байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон алдагдал, хаягдал багатай, байгаль орчны бохирдол доройтлоос сэргийлсэн буюу байгальд ээлтэй үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид төсөл сонгон шалгаруулах замаар санхүүжилт олгох	"Органик Монгол" төсөл хэрэгжсэнээр танд болон нийгэмд үр өгөөжөө өгч байна уу? Санал асуулгын хариу 66.5% тийм
БОАЖ ЯАМ - АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН НОГООН ЗЭЭЛ	Тусгасан	Байгаль орчны бохирдол буурна
ХАСБАНК - ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛАХ БИЗНЕСИЙН ЗЭЭЛ	Тусгасан	Эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахыг дэмжсэн; Эмэгтэй бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй хүү санал болгодог.
ОББҮХ-НЫ НОГООН ЗЭЭЛ	Тусгасан	Агаар хөрсний бохирдлыг бууруулна, иргэдийн амьдрах орчин сайжирна
ХАСБАНК - ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛАХ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Хүлэмжийн хийг бууруулах
ХАСБАНК - ЭКО МАШИНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын бохирдол бууруулах
ХААН БАНК - ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эко хэрэглээг дэмжих
ТӨРИЙН БАНК - ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын бохирдол бууруулах, Замын түгжрэл багасах
АРИГ БАНК - ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын бохирдол бууруулах
ХХБАНК - ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын бохирдол бууруулах
КАПИТРОН БАНК - ЦАХИЛГААН ДУГУЙНЫ ЗЭЭЛ	Тусгасан	Агаарын бохирдол бууруулах, Замын түгжрэл багасах
ТРАНСКАПИТАЛ ББСБ - НОГООН ЗЭЭЛ	Тусгасан	Байгаль экологид ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, агаарын болон хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих
ADB - UB GREEN AFFORDABLE HOUSING ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Амьдрах орчинг сайжруулах, Улаанбаатар хотыг илүү аюулгүй, эрүүл, ногоон хот болгож, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх зорилготой Эмэгтэйчүүд, ядуучууд болон бусад эмзэг бүлгүүдэд чиглэсэн нийгмийн элементтэй: Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй болон ядуу өрхүүдийг эко дүүрэгт орох	8500 ногоон орон сууцны зээл олгогдох ба зээлдэгчдийн дор хаяж 40% эмэгтэйчүүд байх Шинээр бий болох ажлын байрны дор хаяж 40% нь орон нутгийн иргэдэд, түүний ядаж 40% эмэгтэйчүүдэд, 15% эмзэг бүлэгт зориулагдана. 200,000 хүн-сар ажлын байр бүтээн байгуулалтын үеэр бий болно.

	боломжоор хангах, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эмэгтэйчүүдийг ажилд авах г.м БЗХӨ, ДОХ-ын тархалтын эсрэг арга хэмжээ Орон нутгийн иргэдийг ажилд авах, хүүхдийн болон албадан хөдөлмөрөөс татгалзах	80 гарааны бизнест 20 удаагийн сургалт явуулж, тэдгээрт 160 хүн хамрагдаж, тэдний ядаж тал нь эмэгтэй байна Эко дүүрэг дэх бизнесийн ядаж 40% эмэгтэй удирдлагатай байна
SWITCH ASIA - ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Өрх гэрийн амины орон сууц дулаан алдахгүй, эрчим хүчний хэмнэлттэй болгож зассанаар хүмүүсийн хандлагыг өөрчилж, урт хугацаанд хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлөх; Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн амины орон байрны түлш ашиглалт, CO2 болон бичил тоосонцрын түвшнийг багасгах ЖДҮ эрхлэгчдийг мэргэжил, арга зүйн хувьд дэмжин дулаан алдагдлыг бууруулах загварчлалыг бий болгох	1000 өрхийн орон байрыг дулаалж, дулаан алдагдлыг 20%-аар бууруулахаар нийт 1600 сая тонн түүхий нүүрс, 6000 орчим тонн нүүрсхүчлийн хийг арилгана.
НООЛУУР ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ	Тусгасан	...байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж... БОНБУнэлгээ заавал хийхийг шаарддаг
ADB - ХААХХ ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Тусгасан	...хөдөөгийн хөгжлийг дэмжин, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад төслийн зорилго оршино.
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Тусгасан	Ажил эрхлэлт нэмэгдүүлэх; Тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа, Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зэрэгт батлан даалт гаргахгүй.
KFW "ХАА, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ" ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Тусгаагүй	байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардлагагүй.
АХБ "АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ" ТӨСЛИЙН ЗЭЭЛ	Тусгасан	Хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэх
ЖДҮХ САНГИЙН ЗЭЭЛ	Тусгасан	Төсөл сонгон шалгаруулах журмын 1.4.7: Байгаль орчин, хүний эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь тогтоогдсон бол зээл өгөхгүй.
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗЭЭЛ	Тусгасан	Шинээр бий болгох ажлын байрны тоо, Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн, эмзэг бүлгийн иргэдээс ажилд авах тоог харгалзан жижиг зээл олгоно.

4.2.5 Арилжааны банкнуудын санал болгож буй зээлийн бүтээгдэхүүнүүдийн нөхцөл, нийтлэг шаардлага, шалгуурууд

Энэ хэсэгт судалгаанд хамруулсан зээлийн бүтээгдэхүүнүүдийн шаардлага, шалгуурыг арилжааны банкнууд болон төсөл хэрэгжүүлж буй байгууллагуудаас авч, нэгтгэн, нийтлэг шаардлага, шалгууруудыг тодорхойлсон.

- ААН-үүдэд зориулсан ногоон зээлүүдийн бүтээгдэхүүнүүд (МТЭХСҮ төслийн зээл, ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээл, Органик Монгол төслийн зээл, Хас Банкны хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээл)-ийн тавьж буй нийтлэг шалгуурууд нь эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн бууралтын хэмжээ зэрэг зорилтот үзүүлэлтүүд байхаас гадна хөрөнгө оруулалтын өгөөжийн доод хувь хэмжээ (10-13%)-г заасан байна.
- Харин иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд нь иргэдэд зориулсан бусад (ногоон биш) бүтээгдэхүүнүүдтэй ерөнхийдөө ижил шаардлагатай байна. Тухайлбал, орлого нотлох боломжтой байх, хугацаа хэтэрсэн чанаргүй зээлгүй байх, худалдан авах бараагаа сонгосон байх, байнгын тогтвортой хаягтай байх зэрэг нийтлэг шаардлага байна. Гэхдээ ногоон зээлүүдийн ялгарах онцлог бол худалдан авах бараа бүтээгдэхүүн нь заавал байгаль орчин, нийгэмд ээлтэй байх шаардлага тавьдаг.

Хүснэгт 4. 4 Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийн нэмэлт шаардлага

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ	ШААРДЛАГА
ОББҮХ-ны ногоон зээл	Байгаль орчинд ээлтэй технологи сонгосон байх
Хас Банк - Хүлэмжийн хийг бууруулах орон сууцны зээл	Гэр хороололд амьдардаг бол орон сууц худалдан авах; 1997 оноос өмнө ашиглалтад орсон орон сууцанд амьдардаг бол 1997 оноос хойш ашиглалтад орсон эсвэл эрчим хүчний хэмнэлттэй орон сууц худалдан авах ёстой;
Хас Банк - Эко машины зээл	2008 оноос хойш үйлдвэрлэгдсэн, гадаад улсад ашиглагдаж байсан боловч МОНГОЛ УЛСАД АШИГЛАЖ БАЙГААГҮЙ, УЛСЫН ДУРААР АВААГҮЙ, хүлэмжийн хийн бууралтыг дор хаяж 20%-аар бууруулж буй гибрид, цахилгаан хөдөлгүүртэй автомашин байх
ХААН Банк - Иргэдэд зориулсан ногоон зээл	ХААН банктай гэрээтэй бэлтгэн нийлүүлэгчээс эко бараа бүтээгдэхүүн авах
Төрийн Банк - Эко автомашины зээл	Худалдан авах бараа нь 100 хувь цахилгаан хөдөлгүүрт автомашин эсвэл унадаг дугуй, цахилгаан скүүтер байх
Ариг Банк - Эко автомашины зээл	Худалдан авах бараа нь Цахилгаан, бензин хосолсон эсвэл дан цахилгаан хөдөлгүүртэй, Сүүлийн 10 жилийн дотор үйлдвэрлэгдсэн, Монгол улсын хилээр орж ирснээс хойш 1 жилээс (12 сар) илүүгүй хугацаа өнгөрсөн, Өнгө үзэмжтэй, зээлдэгч нэмэлт засвар, үйлчилгээ хийлгүй ашиглах боломжтой автомашин байх

ХХБанк - Эко автомашины зээл	Худалдан авах бараа нь Цахилгаан хос тэжээлт болон шингэрүүлсэн хий, цахилгаан тэжээлт ЭКО автомашин байх
Капитрон Банк - Цахилгаан дугуйны зээл	Худалдан авах бараа нь цахилгаан скүүтэр байх
Транскапитал ББСБ - ногоон зээл	Худалдан авах бараа нь эко орон сууц, эко автомашин, эко ахуйн бараа байх

- Нэхмэлийн салбарт олгогдох боломжтой “Ногоон гэж заагаагүй” буюу ЖДҮ-д зориулсан бусад төслийн зээлүүдийн нийтлэг шаардлага нь Монгол улсад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг ААН эсвэл иргэн байх, хэрэгжүүлэх төслөө бичсэн байх, зарим төслийн хувьд шинээр ажлын байр бий болгож байх, мөн ЖДҮ эрхлэгч байх зэрэг шалгуур тавьдаг.
- Ихэнх зээлийн бүтээгдэхүүний хувьд нийтлэг тавигдаж буй ерөнхий шалгуурууд нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлгүй байх, барьцаа хөрөнгөтэй байх, ажлын туршлагатай, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байх, орлогоо нотлох боломжтой байх зэрэг байна.

Судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдийн нөхцөлийг бүлгээр нь авч үзвэл дараах байдалтай байна. Нийт судлагдсан зээлийн бүтээгдэхүүнүүдээс нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчдийн хүлээлтэд нийцсэн буюу 8%-иас хэтрэхгүй хүүтэй зээлүүдэд ЖДҮХСангийн зээл, ХЭДСангийн жижиг зээл, ХААХХ төслийн зээл, ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээл гэсэн 4 бүтээгдэхүүн байгаа бол бусад зээлийн

бүтээгдэхүүн дор хаяж 10% буюу түүнээс дээш хүүтэй байна. Харин зээл олгох дээд хугацааны хувьд 7 зээлийн бүтээгдэхүүн нь 5 жил буюу түүнээс дээш хугацаатай, үлдсэн 5 зээлийн бүтээгдэхүүн нь 5 жилээс бага хугацаатай байна.²⁰

Хүснэгт 4.5 Зээлийн бүт ээгдэхүүнүүдийн нөхцөл, бүлгээр

Зээлийн төрөл	Зээлийн хүү %	Хэмжээ сая төгрөг	Хугацаа сар
ААН-д зориулсан ногоон зээлүүд	8.0-16.8	20-5645	36-120
Иргэдэд зориулсан ногоон зээлүүд	9.0-21.6	10-150	30-240
ЖДҮ-д зориулсан ногоон биш зээлүүд	3.0-18.0	20-6774	24-120
ББСБ-уудын зээл	25.5-58.8	100-2000	36-60

4.2.6 Үйлдвэрүүдийн хувьд банкны зээл авахад тулгардаг саад, бэрхшээл, эрсдэлүүд – Банкнуудын зүгээс

Нэхмэлийн салбарын ААН-үүдийн хувьд хангахад хүндрэл учирдаг шалгуурууд болон банкны зүгээс нэхмэлийн салбарт харж буй эрсдэлийн мэдээллийг арилжааны банкнууд болон төсөл хэрэгжүүлэгч зарим байгууллагуудаас авч, нэгтгэн, нэхмэлийн салбарт санхүүжилт авахад учирч буй нийтлэг бэрхшээлүүд, тулгарч буй нийтлэг эрсдэлүүдийг тодорхойлсон.

- Нэхмэлийн салбарын ААН-үүдийн хангахад бэрхшээлтэй шалгуурт барьцаа хөрөнгө, борлуулалтын орлогын тогтвортой

²⁰ Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд, ББСБ-уудын зээлийг оруулаагүй.

байдал, өр, орлогын харьцаа багтдаг. Учир нь ноос ноолуурын үйлдвэрүүд, компаниудын борлуулалтын орлого улирлын онцлогтой, хэлбэлзэл ихтэй байдаг.

- Арилжааны банкнуудын зүгээс нэхмэлийн салбарын үйлдвэрүүдэд санхүүжилт, зээл олгоход учирдаг түгээмэл эрсдэлүүдэд төлбөрийн чадвар, хүний нөөц, технологийн чадавх гэж тодорхойлсон байна.
- Эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн бууралтыг хэмжихэд банкнууд болон зээл хүсэгчдэд хүндрэл гардаг. Учир нь тогтсон суурь үзүүлэлт байдаггүй тул төслийн нөлөөг бодитоор үнэлэх боломж хомс байдаг. Түүнчлэн эрчим хүчний аудит хийх зардлыг банк, зээл хүсэгч 2-ын хэн нь гаргах гэдэг асуудал дээр маргаан үүсдэг.
- Санхүүгийн салбарт “ногоон” эсвэл “ногоон биш” гэсэн үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, ангилал, шалгуур одоогоор байхгүй. Энэ нь ногоон зээл олгох, авахад хүндрэл учруулдаг.

4.2.7 Нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчдийн арилжааны банкнаас зээл хүсэх нийтлэг зорилго – Банкнуудын зүгээс

Энэ хэсэгт нэхмэлийн салбарын ААН-үүд зарим гол зээлийн бүтээгдэхүүнийг авсан болон авахаар хүсэлт гаргасан зорилго, тэдгээр зээлийн бүтээгдэхүүний гол зориулалтуудыг арилжааны банкнуудаас авсан судалгаанд үндэслэн, нэгтгэн гаргасан.

- *ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн зээлийн хувьд:* нэхмэлийн салбарын ААН-үүд ихэвчлэн шинэ тоног төхөөрөмж худалдан авах болон барилгын өргөтгөл хийх зорилгоор зээлийн хүсэлт гаргадаг.
- *ХААХХ төслийн зээлийн хувьд:* шинэ тоног төхөөрөмж авах, эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх, борлуулалт нэмэгдүүлэх нь нэхмэлийн салбарын ААН-үүдийн зээл хүсэх гол шалтгаанууд болдог байна.

БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Дэлхийн уур амьсгал сая сая жилийн түүхэнд олон удаа өөрчлөгдөж, асар ихээр хэлбэлзэж ирсэн хэдий ч аж үйлдвэржилт эхэлснээс хойших 260 орчим жилд хүний үйл ажиллагаанаас улбаатай хүлэмжийн хийн ялгаруулалт эрс нэмэгдсэн. Дэлхий дахинаа малтмал чулуужсан түлшний хэрэглээ, хамаарал дээд цэгтээ тулж, хүн амын хэт өсөлтөөс үүдэлтэй хүнс, бүтээгдэхүүний хэрэглээг хангахын тулд олон зуун жилийн настай ширэнгэн ой модыг устгаж тариалангийн газар болгох, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, азотын агууламж өндөртэй бордоо хэрэглэх зэрэг үйл ажиллагаа нь нүүрсхүчлийн хий, метан, азотын хий гэх мэт хийн ялгарлыг дагуулж, хүлэмжийн эффект үүсгэж байна. Улмаар, жишээ нь Монгол улсад 20 дугаар зууны 2 дугаар хагас, сүүлийн 70-хан жилийн хугацаанд агаарын дундаж дулаан 2 хэмээр нэмэгдээд байна. Иймд, улс орон, салбар харгалзахгүй бүх түвшинд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүний буруутай үйл ажиллагааг зогсоох, байгаль орчин, хүрээлэн буй орчны доройтлыг нэн даруй багасгах нь хүн төрөлхтний цаашид орших, эс орших тухай, сонголтын бус асуудал болоод байна.

1970-аад оноос эхлэн өндөр хөгжилтэй орнуудад байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах, байгаль орчныг хайрлаж хамгаалах иргэний хөдөлгөөнүүд идэвхтэй өрнөж эхэлсэн. Ингээд, сүүлийн 20-иод жилийн хугацаанд загварын ертөнц, хувцас үйлдвэрлэл, нэхмэлийн салбарт байгаль, ан амьтанд ээлтэй, хаягдалгүй, бохирдолгүй үйлдвэрлэлийн сэдэв чухал байр суурийг эзлэх болсон. Үүнтэй уялдаад Монголын нэхмэлийн салбарын жижиг дунд үйлдвэрүүдийн ногоон санхүүгийн эрэлт хэрэгцээ, боломжит нийлүүлэлтийг тодорхойлох судалгааг хийсэн нь цаг үеэ олсон, шинэлэг ажил байлаа. Тодорхойлолт, хамрах хүрээ, аргачлал, тоон мэдээллийн олдоц, ойлголтын зөрүү гэх зэрэг хүчин зүйлсээс улбаатай сорилтууд тулгарсан хэдий ч төслийн захиалагч

болон холбогдох сонирхлын бүлгүүдийн төлөөлөлтэй удаа дараалан уулзаж, санал, мэдээлэл солилцсоны үндсэн дээр харьцангуй бодитой үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтүүдийг хийж болно, үүнд:

- Байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл, ногоон санхүү, ногоон зээлийн тухай ойлголт, концепци нь Монголын нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн хувьд харьцангуй шинэ сэдэв, ойлголт болох нь ярилцлагын шатанд илэрхий болсон. Иймд судлаачдын зүгээс зохих суурь мэдээллийг ярилцлагад хамрагдсан хүмүүст өгч, чиглүүлэх шаардлага гарч байв.
- Нэхмэлийн салбарын ЖДҮ-үүдийн ногоон санхүүгийн эрэлт бодит төсөөллөөр 250 тэрбум төгрөг, зорилтот төсөөллөөр 576 тэрбум төгрөг байна гэж тооцоолсон. Нөгөө талаас, нэхмэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүдэд тохирох, ногоон тодотголтой зээл, санхүүжилтийн боломжит нийлүүлэлт 75 тэрбум төгрөг байна гэж тогтоосон. Иймд тус салбарын ЖДҮ-үүд үйл ажиллагаагаа байгальд ээлтэй, ногоон болгоход шаардлагатай ногоон санхүүгийн эрэлтийг хангах хэмжээний санхүүжилт одоогоор зах зээлд хангалтгүй буюу эрэлт хэрэгцээ нь боломжит нийлүүлэлтээсээ 3.3-7.6 дахин өндөр байна.
- Судалгаанд хамрагдсан компанийн удирдлагууд үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа байгальд ээлтэй, ногоон болгох нийтлэг хүсэл эрмэлзэлтэй байгаа ч дийлэнх нь (80%) энэ чиглэлд ямар нэг санаачилга, арга хэмжээ авч хэрэгжүүлж чадаагүй байна. Энэ нь үйлдвэрлэлийг ногоон болгох шаардлага, ач холбогдлыг ойлгодог ч хэрэгжүүлэх арга зам, алхмуудыг сайн мэдэхгүй, мэдээлэл мэдлэг хангалтгүй, мөн тухайн компани, аж ахуйн нэгжийн хувьд ногоон үйлдвэрлэл нь шийдвэрлэвэл зохих нэн тэргүүний чухал асуудал биш зэргээс үүдэлтэй гэж хэлж болно.

- 10-50 ажилтантай жижиг үйлдвэр, 50-200 ажилчидтай дунд үйлдвэр, 200-с дээш ажилчидтай цогцолбор, хагас цогцолбор том үйлдвэрүүдийн хувьд санхүүгийн эрэлт хэрэгцээ, нэр төрөл, хэмжээ, зориулалт, хүлээлт тус бүр ялгаа ихтэй байгаа тул санхүүжилтийн нэг загвар, хандлагаар ногоон санхүүгийн асуудлыг шийдэх боломжгүй харагдаж байна.
- Зөвхөн ногоон үйлдвэрлэлтэй болох зорилгоор зээл, санхүүжилт авах сонирхол бага, санхүүгийн дарамт, эрсдэлээс эмээж байгаа тухайгаа ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид илэрхийлж байв. Тэдний хувьд зээл, нэмэлт санхүүжилтийн хамгийн чухал хэрэгцээ нь түүхий эд бэлтгэл, тоног төхөөрөмжтэй болох эргэлтийн хөрөнгө, ажилчдын цалин, үйл ажиллагааны зардал, үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахтай холбоотой хөрөнгө оруулалт гэж онцлов. Жижиг дунд үйлдвэрүүдийн хувьд үйл ажиллагаа нь цөөхөн сараар тасалдахад л ажилчид болон мэргэшсэн боловсон хүчнээ алдах, хүн хүчгүй болох өндөр эрсдэлтэй байдаг гэв.
- Өөрөөр хэлбэл, хангалттай хэмжээний, харьцангуй хөнгөн нөхцөлтэй ногоон санхүүгийн эх үүсвэр бүрдлээ ч бодит байдалд ногоон зээлийн бүтээгдэхүүний борлуулалт төлөвлөснөөс бага эсвэл удаан байж болзошгүй. Энэ тохиолдолд урамшууллын эсвэл захиргааны нэмэлт хөшүүргүүд шаардлагатай болно.
- Дээрх дүгнэлтэд хүрэх болсон нэг хүчин зүйл бол одоогийн байдлаар нэхмэлийн жижиг дунд үйлдвэрүүдэд нээлттэй ногоон санхүүгийн 75 тэрбум төгрөгтэй тэнцэх нийлүүлэлт байгаа ч салбарын үйлдвэрүүдээс ганцхан аж ахуйн нэгж 150 сая төгрөгийн санхүүжилт авсан буюу маш бага хамрагдсан байгаатай холбоотой юм.
- Ноос, ноолуурын салбарынхан ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүдээс хүртэхгүй байгаа нь санхүүгийн эрсдэлд орох хүсэлгүй; төлбөрийн чадвар хүрэхгүй; зээлийн шаардлага, шалгуурыг биелүүлэх чадваргүй; байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийн

мэдлэг туршлага хангалтгүй; байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг бүрэн хийдэггүй; дээрх бүх чиглэлийн мэдлэг, мэдээлэл дутмагтай холбоотой гэж дүгнэж болно.

- Зээлийн материал бүрдүүлэх нь хүн хүч, цаг их шаарддаг процесс тул банк санхүүгийн байгууллагуудын зүгээс богино хугацаатай сургалтыг (зээлийн материалаа бүрэн бүрдүүлэх, цаг хэмнэж, зээлийн хорооны дүгнэлтийг сайн гаргуулах, зээлийн хүсэлтээ амжилттай батлуулах сэдэвт) тодорхой давтамжтай зохион байгуулбал нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчид ногоон санхүүжилт авах боломж нэмэгдэх нь гарцаагүй.
- Аливаа үйлдвэр, аж ахуйн нэгжийн санхүүжилтийн хэрэгцээ, үүн дотроо ногоон санхүүтэй холбоотой ойрын ба хэтийн стратеги, тэлэлтийн бодлого, төлөвлөлтийг компанийн жинхэнэ хувьцаа эзэмшигчид, эзэд мэддэг тул зөвхөн гүйцэтгэх удирдлага эсвэл зохих газар хэлтсийн мэргэжилтэн, инженерээс мэдээлэл авахад хангалтгүй байв. Иймд судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн аль болох хувьцаа эзэмшигчийн түвшний хүмүүсээс ярилцлага авсан нь тус судалгааны нэг онцлог юм.
- Олон улсын туршлага ёсоор, жишээ нь Бангладеш улсад Олон Улсын Санхүүгийн Корпорацын хэрэгжүүлсэн Partnership for Cleaner Textile (PaCT) төслийн туршлагаас харахад нөөцийн үр ашигтай үйлдвэрлэл явуулахад хамгийн түрүүнд хийх алхам нь ус, эрчим хүч, химийн бодисын хэрэглээг хэмждэг, бүртгэдэг болохоос эхлэх ба үүнийг хэрэгжүүлэхэд харьцангуй хялбар, бага зардалтай, өгөөж өндөртэйг онцолсон байдаг. Үүний жишгээр Монголын нэхмэлийн үйлдвэрүүдийн хувьд тогтвортой үйлдвэрлэлд шилжих хамгийн эхний, энгийн, хямд алхам бол нийтээрээ бүхий л төрлийн хэрэглээгээ хэмждэг, бүртгэдэг болохыг зорих гэж дүгнэж болно. Үүний дараа хэмнэлтийн арга хэмжээ, үйл ажиллагааг ногоон зээлээр санхүүжүүлэх эсэхээ төлөвлөх нь зүйтэй.

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ СУДАЛГАА: ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ, УС ЗӨӨЛРҮҮЛЭГЧ ТӨХӨӨРӨМЖ, ДУЛААЛГЫН МАТЕРИАЛ

Ноос, ноолуурын үйлдвэрүүдэд байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй үйлдвэрлэл эрхлэхэд нь зарим тоног төхөөрөмж, шийдлүүдийн талаарх мэдээллээр хангах зорилготой дараах нэмэлт судалгааг хийсэн болно. Үйлдвэрүүдийн нийтлэг хэрэгцээнд тулгуурлан бид цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн барилгын дулаалгын материал, ус зөөлрүүлэх төхөөрөмж гэсэн 3 үндсэн бүтээгдэхүүний үнэ ханш, технологи, давуу тал болон хаанаас авах боломжтой зэрэг мэдээллүүдийг боловсруулав.

1. Цэвэрлэх байгууламж

Үйлдвэрээс гарч буй хаягдал усыг цэвэрлэдэг, дахин ашигладаг системтэй үйлдвэрүүд маш цөөн бараг байхгүй, дийлэнх нь төвийн шугамд нийлүүлдэг болох нь судалгаанаас ажиглагдсан, мөн цэвэрлэх байгууламж барих сонирхолтой ирээдүйд барихаар төлөвлөсөн үйлдвэр олон байсан тул бид цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтын өртөг, технологийн шийдэл зэргийг тоймлон судлахыг зорьсон.

Бид ахуйн ба үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламжийн системийг нэвтрүүлж, хэрэгжүүлж буй 4-5 томоохон компаниудтай холбогдсон. Цэвэрлэх байгууламжийн үнэ өртөг нь тухайн үйлдвэрийн хоногт хэрэглэж буй цэвэр ба бохир усны хэмжээ, ачаалал, химийн бодисуудын хэрэглээ, усны бохирдлын түвшин зэрэг хүчин зүйлсээс хамааран ялгаатай горим, хүчин чадалтайгаар тухайн үйлдвэрт зориулж хийгддэг тул цэвэрлэх байгууламжийн тогтсон үнэ ханшийн ойлголт компаниудад ховор байлаа.

Ноос, ноолуурын салбарын үйлдвэрүүдэд цэвэрлэх байгууламжийн талаарх үнэ ханшны баримжаа өгөх үүднээс цуглуулсан мэдээллүүдийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт Х1. 1 Цэвэрлэх байгууламжийн үнэ, борлуулагч, т ехнологи

Барагцаа т өсөв		Технологи, байгууламжийн хүчин чадал г.м
BAUHAUS компани	(үнийн мэдээлэл нь тухайн	Герман улсын бохирын бие даасан систем. Бохирын септик систем нь

	үйлдвэрт зориулагдаж янз бүр гарах боломжтой тул өгөх боломжгүй гэв) Хоногт 200 – 300 айл өрхийн хэрэглээг хангах хүчин чадалтай ахуйн цэвэрлэх байгууламж барихад – 2-2.5 тэрбум ₮	бохирыг олон үе шаттайгаар цэвэрлэн байгаль орчинд нь шингээдэг технологийн шийдэлтэй. Бохир усыг 90-99% цэвэршүүлж газарт шингээдэг . Ашиглалтын зардал багатай ба тухайн ахуйн, үйлдвэрлэлийн усны хэмжээнээс хамааран септик системийн хэмжээ янз бүр байна. Тус компани нь Чингэлтэй дүүргийн 7-р хорооны гэр хорооллын “Дэд бүтцийн төв”-ийн цэвэрлэх байгууламжийг барьж дуусгаад байгаа. Энэ нь 200-300 айл өрхийн хэрэглээний бохир усыг цэвэршүүлэх хүчин чадалтайгаар баригдсан.
Ультрасоник ХХК	Зөвхөн тоног төхөөрөмжийн барагцаалсан өртөг, хоногт хэрэглэх усны хэрэглээгээр хүчин чадлыг тогтоосон: 50 м3 – 350 сая ₮ 100 м3 – 600 сая ₮ 200 м3 – 900 сая ₮	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж нь Германы мембран биореакторын (MBR) арга болон WSB (хөвөгч эргэлдэх биет биореактор) технологийн зарчмаар ажилдаг. WSB технологитой байгууламжийн хүчин чадал нь 5-5000 хүний хэрэглээнд тохирсон. Бохир усыг 97% цэвэршүүлдэг, өвчин үүсгэгч нянгуудыг микробиологийн аргаар устгадаг, бүрэн автомат ажиллагаатай, Монгол орны эрс тэс уур амьсгалд бүрэн тохирсон, цэвэрлэгдсэн усыг хөрсөнд шууд шингээх боломжтой.
Атмор ХХК	(үнийн мэдээлэл нь тухайн үйлдвэрт зориулагдаж янз бүр гарах боломжтой тул	Септик систем, цэвэршүүлэх системдээ цахилгаанаар ажилладаг агаар үлээгч эсвэл агаарын дифузер ашигладаггүй тул ашиглалтын зардал бага.

	өгөх боломжгүй гэв)	
Алтай Эколог ХХК	(үнийн мэдээлэл нь тухайн үйлдвэрт зориулагдаж янз бүр гарах боломжтой тул өгөх боломжгүй гэв) Ахуйн цэвэрлэх байгууламжийн өртөг, Жш: 32 м3 – 160 сая ₮ (Топазро-32 Пр) 60 м3 – 260 сая ₮ (Астра-300)	ОХУ-ын Бохир ус цэвэрлэх байгууламжууд болох “ЮНИЛОС”, “ТОПОЛ-ЭКО” компаниудын албан ёсны дистрибьютер компани. Бохир усыг 98% цэвэршүүлэх хүчин чадалтай, цэвэрлэсэн ус нь MNS 4943:2011 бохир усны стандартыг хангадаг. Цэвэрлэх байгууламжийг зээлээр суурилуулах боломжтой, зээлийн үйлчилгээ нэвтрүүлсэн.
Ховд тул ХХК Монгол инженерүүд (Д.Басандорж)	☐ Ноолуур боловсруулах цогцолбор үйлдвэрт 200 гаруй сая ₮-ийн цэвэрлэх байгууламж барьсан, ☐ Анхан шатны үйлдвэрт цэвэрлэх байгууламжийг 200-300 сая ₮ өртөгтэй босох боломжтой гэж тооцсон.	

2. Барилгын дулаалгын материал

Чанартай, эко дулаалгын материал ашигласнаар барилгын дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох давуу талтай, цаашлаад байгальд ээлтэй үйлдвэрлэлийн орчин, нөхцөл бүрдэж байгаа юм.

Орчин үед олон төрлийн дулаалгын материал хэрэглэж байгаа боловч энэхүү судалгаанд барилга, байгууламжид нийтлэг хэрэглэж байгаа хөөсөн полистирол хавтан, шилэн хөвөн болон бусад харьцангуй өртөг өндөртэй боловч илүү чанартай, эко, хүний эрүүл мэндэд хоргүй, галын аюул багатай зэрэг материалууд болох чулуун хөвөн, эрдэс хөвөн, хонины ноосон дулаалгуудыг сонгон, тэдгээрийн нэгдсэн ерөнхий мэдээллүүдийг тусгалаа. Доорх дулаалгын материалуудыг барилгын гадна хана, хамар хана, давхар хоорондын хучилт, дуу тусгаарлах, дээврийн дулаалга, суурь, хөрс зэрэгт ашиглана (хөөсөн полистирол хавтанг тусгаарлах хананд ашиглах тохиромжгүй). Дулаалгын материалын үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь дулаан

дамжуулалтын коэффициент бөгөөд уг үзүүлэлт бага байх тусам дулаан тусгаарлалт сайтайн шинж байдаг.

Хүснэгт Х1. 2 Дулаалгын мат ериалуудын үндсэн үзүүлэлт, харьцуулалт

Мат ериалын нэр	Дулаан дамжуулалт ын коэффициент	Нягт кг/м3	Уур нэвт рүүлэх чанар мг/(м.ч.Па)
Хөөсөн полистирол EPS хавтан	0.036 – 0.050	25 – 50	0.02 – 0.05
XPS хавтан	0.029 – 0.031	30 – 50	0.02
Ноосон дулаалга	0.039 – 0.042	30 – 40	0.35
Чулуун хөвөн /Эрдэс хөвөн/	0.035 – 0.045	40 – 125	0.38 – 0.60
Шилэн хөвөн	0.038 – 0.045	15 - 100	0.53

Эх сурвалж: Дулаалгын материалуудын сонголт ба харьцуулалт, barilgachin.mn

Хүснэгт Х1. 3 Дулаалгын мат ериалуудын т өрөл, үнэ ханш, худалдаалж буй байгууллагуудын харьцуулалт

	Зузаан	Марк/нягт	Үнэ	Байгууллага
Хөөсөн EPS хавтан		14-15 кг/м3	94,600 ₮ (1м3)	Barilgachin.mn
		20-22 кг/м3	132,600 ₮ (1м3)	
		31-33 кг/м3	197,600 ₮ (1м3)	
EPS хөөсөнцөр хавтан (Монгол)		20-22 кг/м3	132,600 (1м3)	Пирамид Индастри ХХК
		23-24 кг/м3	145,600 (1м3)	
Хар саарал хөөсөнцөр NEOPOR (Монгол)		20-22 кг/м3	147,000 (1м3)	
Пеноплекс XPS хавтан (Орос)	5 см		285,000 ₮ (1м3) 14,000 ₮ (1м2)	Росторг
Хонины ноосон дулаалга (Монгол)	10 см		20,900 ₮ (1м2) 1 боодолдоо 9.135 м2	Эко Ноос ХХК
Чулуун хөвөн хавтан		100 кг/м3	215,000 ₮ (1м3)	Монголбаза льт ХК
		120 кг/м3	275,000 ₮ (1м3)	

(Монгол)	10 см	100 кг/м3	21,500 ₮ (1м2)	(НӨАТ-гүй дүн)
	5 см	60 кг/м3	7,250 (1м2)	
Эрдэст хөвөн хавтан (Орос - Тепло KNAUF)	10 см	12 кг нягт	46,084 ₮ (6 м2)	Росторг
		16 кг нягт	60,060 ₮ (6 м2)	
Шилэн хөвөн (Орос - Урса)	5 см		47,025 ₮ (16.8 м2)	Росторг

Эх сурвалж: Монголбазальт, Росторг, Пирамид Индастри компанийн албан ёсны вэбсайт, Barilgachin.mn. 2019 оны 9-р сарын байдлаарх үнийн мэдээлэл.

Тайлбар: “Дулаалга аян тайлан 2017-2018” судалгааны ажилд сонгогдож, тусгагдсан барилгын компаниудын дулаалгын материалуудын мэдээллийг оруулахыг зорьсон болно.

Хөөсөн хавтан, шилэн хөвөн, чулуун хөвөн, эрдэс хөвөн, ноосон дулаалгууд нь бүгд дулаан тусгаарлах чадвар сайн хэдий ч бүгд өөрсдийн гэсэн давуу ба сул

талуудтай тул хэрэгцээ, шаардлагадаа нийцүүлэн сонгох нь зүйтэй. Тухайлбал шилэн хөвөн, хөөсөн хавтангууд нь харьцангуй үнэ хямдтай боловч галд тэсвэртэй чадвар бусад гурвыг бодвол сул. Хонины ноосон дулаалга нь органик, галд тэсвэртэй, химийн хорт бодис шингээж цэвэршүүлэх үүрэг гүйцэтгэх чадвартай зэрэг давуу тал ихтэй боловч харьцангуй өндөр үнэтэй, мөн хортон шавж үүрлүүлэх боломжтой байдаг байна.

Монголд зөвхөн барилгын гадна фасад, тааз, дулаалгын ажлыг гүйцэтгэдэг барилгын компани, үйлчилгээний бригад, хувь хүмүүс олон байх бөгөөд 1 м2 гүйцэтгэлийн ерөнхий үнэ ханш нь ямар материалыг дулаалгад ашиглахаас шалтгаалан өөр өөр байна. Дийлэнх тохиолдолд захиалагч тал нь материалаа гарган гүйцэтгэгч нь 1 м2 гүйцэтгэлийн ажлын хөлсийг тохиролцон хийдэг байна. 1 м2 барилгын гадна фасад, дулаалгын ажлын хөлс 15,000-40,000 төгрөгийн хооронд байх ба хөөсөн хавтангаар дулаалга хийх тохиолдолд хамгийн хямд 15,000 төгрөг, шилэн хөвөн, чулуун хөвөн зэргийг ашиглаж хийх тохиолдолд ажлын хөлс илүү өндөр байдаг байна.

3. Ус зөөлрүүлэгч төхөөрөмж

Хүснэгт Х1. 4 Ус зөөлрүүлэгч төхөөрөмж

Борлуулагч	Үнэ (т өгрөг)	Марк, хүчин чадал, хэмжээ г.м
Аргил сувд ХХК	6,500,000	HWS – 1044, 1.0 м3/цагт, 559х334х658 мм
Тот Ком Сервис ХХК	242 – 119,730 USD	Усны урсцын хурд, хүчин чадал зэргээс хамаараад үйлдвэрийн зориулалттай ус зөөлрүүлэгч үнэ харилцан адилгүй. Минутада дээд тал нь 7.5л, доод тал нь 2.5 л урсдаг бол 242 USD үнэтэй, уг хязгаар нь дээд нь 8892 л, доод нь 2964 л байхад 119,730 USD.
Aqua electronics	7,500,000	Pure Pro-1500G, суурилуулах газарт ус боловсруулах төхөөрөмж рүү 3 бар даралттай 0.4 м3/ц боловсруулагдах ус шахагдах насос ашигладаг. Номиналь урсгалын хэмжээ 4 м3/ц. Хамгийн их даралт 10 бар.
	1,500,000	Multi Housing 7 загвар, даралтын дээд хэмжээ 0.6МПа, өдөрт 5-10 тн усны хэрэглээтэй үйлдвэрүүдэд суурилагдана. БНСУ-д үйлдвэрлэгдсэн.
Монвеком ХХК (Ecowater Shop)	6,700,000	RO-600 загвар, хүчин чадал 3-4 тн/х, шүүх хэмжээ 0.0001 микрон, 1-10 хүртэл бохирдлыг шүүнэ.
	13,000,000	Зөөлрүүлэгч төхөөрөмж нь тусдаа механик болон цаасан шүүлтүүртэй ба тодорхой хугацаанд эдгээрийг солих шаардлагатай. [Микро шүүлтүүр, хүчин чадал 10 тн/ц, шүүх хэмжээ 05 микрон. Микро шүүлтүүрийг шүүж буй усны чанар, хэрэглээнээс хамааран тодорхой хугацааны дараа шүүлтүүрийг сольж хэрэглэнэ.]

Эх сурвалж: Компаниудын албан ёсны вэбсайт. 2019 оны 9-р сарын байдлаарх үнийн мэдээллүүд болно

ХАВСРАЛТ 2. СУДЛАГДСАН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Бүлэг Х.1. Монгол улсад одоогоор олгогдож байгаа ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

Бүлэг Х.1.1 Аж ахуйн нэгжүүдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

Боломжит эх үүсвэрийн ДҮН – 112 тэрбум төгрөг

Зээлийн бүтээгдэхүүн 1. Монголын Тогтвортой Эрчим Хүчний Санхүүжилтийн Үйлчилгээ (МТЭХСУ) төслийн зээл – 21.4 тэрбум төгрөг (8 сая ам.доллар)

Энэ хөтөлбөрийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк болон Уур Амьсгалын Ногоон Сангаас санхүүжүүлж байгаа бөгөөд эрчим хүчний хэрэглээгээ багасгахаар зорьж байгаа байгууллагуудад арилжааны банкуудаар (ХААН Банк, Хас Банк) дамжуулан 2014 оноос хойш санхүүжилт олгож байна (Хүснэгт Х2.1). Хөтөлбөрийн нийт санхүүжилт 25 сая ам.доллар бөгөөд одоогоор 17 сая ам.долларын санхүүжилт батлагдсан байна. Уг хөтөлбөрөөс үндсэн 2 чиглэлд зээл олгодог: А) Компанийн эрчим хүчний үр ашгийн зээл Б) Сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалт. Түүнчлэн төсөлд хамаарах үндсэн салбарууд нь үйлдвэрлэл, барилга, хөдөө аж ахуй, тээврийн хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүч байна.

Зээлийн шаардлагыг хангахын тулд төсөл нь дараах үр дүнг үзүүлэх шаардлагатай байдаг:

- ☐ Түлшний хэрэглээ болон эрчим хүчний зардал тогтвортой буурсан байх.
- ☐ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр нь тухайн объектын эрчим хүчний хэрэгцээг хэсэгчлэн аль эсвэл бүрэн хангаж байх.
- ☐ Шинээр бүтээн байгуулалт хийгдэж байгаа бол ашиглагдаж байгаа технологи нь зах зээлийн дундаж болон тухайн улсын барилгын стандартыг хангасан аль эсвэл давуулан биелүүлсэн байх.

А) Эрчим хүчний хэрэглээг багасгахад зориулсан зээлд дараах төрлийн технологиуд хамаарна:

- ☐ Хэмнэлттэй гэрэлтүүлэг
- ☐ Зуух

- ☐ Хэмнэлттэй халаалт болон хөргөлтийн систем (HVAC)
- ☐ Хэмнэлттэй хөлдөөх байгууламж
- ☐ Хэмнэлттэй цахилгаан мотор
- ☐ Хэмнэлттэй цахилгаан трансформер
- ☐ Даралтат агааржуулалтын систем
- ☐ Цахилгааны хэмнэлттэй систем
- ☐ Барилгын дулаалга
- ☐ Хувьсах хурдны хөдөлгүүр
- ☐ Дулаан барих систем
- ☐ Нарны эрчим хүчээр хөргөх систем
- ☐ Нарны PV панел
- ☐ Нарны ус халаах систем
- ☐ Усан цахилгаан үүсгүүр
- ☐ Бичил дулаан цахилгааны генератор

Төсөлд тавигдах техникийн шаардлага:

- ☐ Хөрөнгө оруулалтын үр дүнд гарсан эрчим хүчний хэмнэлт нь хамгийн багадаа 15% байх
- ☐ Хөрөнгө оруулалтын үр дүнд байгууллагын дотоод өгөөжийн хувь хамгийн багадаа 10%-р өссөн байх
- ☐ Төслийн хөрөнгө оруулалтаар худалдаж авсан тоног төхөөрөмж нь бүгд шинэ байх (ЕСБХБ зарим тохиолдолд ашиглагдсан тоног төхөөрөмж худалдаж авахыг зөвшөөрдөг)
- ☐ Хөрөнгө оруулалтын үр дүнд озоны давхаргад хортой аль эсвэл азбест агуулсан бүтээгдэхүүн гаргахгүй байх
- ☐ Солигдсон хуучин төхөөрөмжийг даруй актлах бөгөөд дахин борлуулахгүй байх

Б) Сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтад усан цахилгаан үүсгүүр, салхин цахилгаан үүсгүүр, байгалийн хийн болон нарны цахилгаан үүсгүүр хамаарна. Хөрөнгө оруулалт нь зөвхөн дотоодын хэрэгцээндээ зориулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт олгогдоно.

Сэргээгдэх эрчим хүчний зээл нь дараах чиглэлийн төслүүдэд олгогддог:

- 1) Photovoltaic (PV, нарны зай хураагуур) төхөөрөмж
- 2) Салхин сэнс
- 3) Бичил усан болон биомассын цахилгаан үүсгүүр
- 4) Амьтан болон ургамлын хаягдлаас байгалийн хий гарган авах төсөл

Техникийн шаардлага:

1. Бүх хөрөнгө оруулалт нь байгууллагын бүтээмжийн үнэлгээнд эергээр нөлөөлсөн байх

2. Бүх сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж нь тухайн объектын эрчим хүчний хэрэглээг бүхэлд нь эсвэл тодорхой хувийг хангаж байх

Хүснэгт Х2. 1 МТЭХСҮ т өслийн хүрээнд зээл олгож буй банкнууд, зээлийн нөхцөл

Банк	ХААН	Хас ²¹
Жилийн хүү	13.8-16.8%	14.4-15%
Зээлийн хэмжээ	500 сая төгрөгөөс 2.5 сая ам.доллартой тэнцэх хүртэл төгрөг	Уян хатан
Хугацаа	5 жил	5 жил
Юуг санхүүжүүлэх вэ?	Эрчим хүчийг хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих, тоног төхөөрөмж, үйлдвэрийн шугам шинэчлэх	Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч бизнес эрхлэгч болон уг бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл, угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжинэ

Нэхмэлийн салбар: Энэ төслийн хүрээнд нэхмэлийн салбарын ААН-үүд одоогоор санхүүжилт аваагүй байна. Нийт 8-9 ААН тоног төхөөрөмж шинэчлэх зорилгоор зээлийн хүсэлт гаргаж байсан бөгөөд тэдгээр ААН-үүд санхүүгийн чадавх хангалтгүй байдлаас буюу давхар зээлийн асуудлаас шалтгаалан зээл авах боломжгүй болж байжээ. Түүнчлэн уг төслийн хүрээнд зөвхөн 500 сая төгрөгөөс доошгүй хэмжээний зээл өгдөг тул ихэнх жижиг, дунд ААН-үүдэд хаалттай байдаг байна.

Зээлийн бүтээгдэхүүн 2. ЯОУХАБ (JICA)-ын ЖДҮ-ийг дэмжих, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн хөтөлбөр (TSL)-ийн 2-р үе шат – Нийт 55 сая ам.долларын санхүүжилт (10 сая ам.доллар нь байгаль орчин хамгаалах, 45 сая ам.доллар нь ЖДҮ дэмжих) олгогдож дууссан бөгөөд одоогоор эргэн төлөлтийн сангаас зээл олгогдож байна.

ус хөтөлбөр нь ЖДҮ эрхлэгчдийг дэмжих, ядуурлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор Японы Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байна. Уг төслийн нэгдүгээр үе шат 2006-2011 онд хэрэгжиж дууссан бол хоёрдугаар үе шат нь 2011 оноос хэрэгжиж байгаа бөгөөд үндсэн 2 чиглэлээр зээл олгодог: ЖДҮ-г дэмжих ба байгаль орчныг хамгаалах. Зээлийг одоогоор арилжааны 5 банкаар дамжуулан олгож байна (Хүснэгт Х2.2).

Ерөнхий шаардлага:

- ☐ Монгол талын өмч (>51%)
- ☐ Ажилчдын тоо 299 хүртэл
- ☐ Төслийн нийт санхүүжилтийн 20 хувийг өөрөө санхүүжүүлэх
- ☐ Хөрөнгө оруулалтын өгөөж 13 хувиас өндөр байх
- ☐ БОНБУнэлгээ хийгдсэн байх

Байгаль орчин хамгаалах зээлийг дараах чиглэлд олгодог:

- ☐ Усан халаалтын болон нам даралтын уурын зуух, өрхийн халаалтын зуухыг шинэчлэх, түлшний хэмнэлттэй зуухаар солих, үйлдвэрлэх
- ☐ Түүхий нүүрс боловсруулж, үртсэн болон шахмал түлш үйлдвэрлэх зэргээр түлшний чанар сайжруулах
- ☐ Нүүрсний хэрэглээг багасгаж, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, бохирдол бууруулах бусад төсөл

²¹ Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн нөхцөлтэй ижил

Хүснэгт Х2. 2 TSL т өслийн хүрээнд зээл олгож буй банкнууд, зээлийн нөхцөл

Банк	Юуг санхүүжүүлэх вэ?	Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
ХААН	Эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, бизнесээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж худалдан авах болон үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламж барих, өргөтгөх	800 сая төгрөг	8%	10 жил
Хас	100 хувь үндсэн хөрөнгө санхүүжүүлнэ	10,000 – 400,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	10 жил
Голомт	Эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж болон үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламжийн өргөтгөлийн санхүүжилтийг хангах	400,000 хүртэл ам.доллартой тэнцэх төгрөг	8%	10 жил
ХХБ	Бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний барилга барих, худалдан авах, засварлах, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, багаж хэрэгсэл, техник, машин, механизм худалдан авах	400,000 хүртэл ам.доллартой тэнцэх төгрөг	8%	10 жил
УБХБ	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх	600,000 ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөг	8%	10 жил

Зээлийн бүтээгдэхүүн 3. Органик Монгол хөтөлбөрийн зээл – 4 тэрбум төгрөг

Энэхүү хөтөлбөрийг МҮХАҮТанхим, Петровис ХХК, Макс Групп, Энержи ресурс ХХК, NTV ТВ, Хас Банк нар хамтран 2009 онд хэрэгжүүлж эхэлсэн ба байгальд ээлтэй бичил бизнес, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих үндсэн зорилготой. Хөтөлбөрт хамрагдах боломжтой салбарууд нь газар тариалан, гар урлал, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ боловсруулах, тахиа, өндөг, зөгийн аж ахуй болон бусад байгальд ээлтэй, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл байсан бол одоогийн байдлаар зөвхөн газар тариалан, хүнсний ногоо тариалагчдад зориулан зээл олгож байна. Уг хөтөлбөрийн хүрээнд Хас Банк дараах нөхцөлтэй ногоон зээлийг олгож байна:

- ☐ Жилийн хүү: 12%
- ☐ Зээлийн хэмжээ: ААН 60 сая төгрөг хүртэл, Иргэн 20 сая төгрөг хүртэл
- ☐ Хугацаа: 3 жил хүртэл

Төслийн санхүүжилт жил бүр 550 сая төгрөг арилжааны банканд байршдаг (Хас банканд 350 сая, Капитал банканд 200 сая) бөгөөд төсөл хэрэгжиж эхэлснээс хойш нийт 700 гаруй төсөлд 2 тэрбум орчим төгрөгийн зээл олгосон байна.

Иймд одоогийн боломжит эх үүсвэрийг 2009-2019 онд батлагдсан нийт эх үүсвэр болох 6 тэрбум төгрөгөөс олгогдсон 2 тэрбум төгрөгийг хасаж, 4 тэрбум төгрөг гэж тооцсон.

Зээлийн бүтээгдэхүүн 4. Хас Банкны Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор олгох бизнесийн зээл – 53.7 тэрбум төгрөг (20.1 сая ам.доллар)

Хас Банк нь 2013 оноос хойш энэхүү зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Уг бүтээгдэхүүн нь эрчим хүчний хэмнэлттэй эсхүл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч бизнес эрхлэгч болон уг бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл, угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд зориулсан зээл бөгөөд дараах нөхцөлтэй:

- ☐ Жилийн хүү: 14.4-15%
- ☐ Хугацаа: 5 жил хүртэл
- ☐ Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: 12 сар хүртэл

Зээл хүсэгчдэд 20% болон түүнээс дээш хувиар эрчим хүчийг хэмнэх эсхүл хүлэмжийн хийн ялгарлыг бууруулснаа баталгаажуулсан байх шалгуур тавьдаг бөгөөд дараах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг дэмждэг:

- ☐ Барилгын засвар, сайжруулалт
- ☐ Эрчим хүчний хэмнэлттэй сууц
- ☐ Халаалт, хөргөлтийн систем
- ☐ Тоног төхөөрөмжийн шинэчлэл
- ☐ Сэргээгдэх эрчим хүч
- ☐ Цэвэр/сайжруулсан түлш
- ☐ Бусад

Тус зээлийн эх үүсвэр нь Уур Амьсгалын Ногоон Сан, МТЭХСҮ төсөл зэрэг хэд хэдэн эх үүсвэрээс бүрдэж байгаа бөгөөд МТЭХСҮ төслийн эх үүсвэрийг хасаж тооцвол 39.5 сая ам.долларын эх үүсвэр байснаас 19.4 сая ам.долларын зээл олгогдсон байна. Иймд одоогийн боломжит эх үүсвэр 20.1 сая ам.доллар гэж тооцогдов.

Зээлийн бүтээгдэхүүн 5. БОАЖЯ – Аялал жуулчлалын салбарын ногоон зээл – 33 тэрбум төгрөг (ХААН, Хас, Төрийн Банкаар дамжуулан зээлдүүлэх)

Тус зээлийн бүтээгдэхүүнийг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас жуулчны баазын үйл ажиллагаа эрхэлж буй 100-аас дээш ор хоногийн хүчин чадалтай ААН-үүдэд зориулан 2019 оны 8 сард гаргасан. Зээлийг ХААН, Хас банкнууд өөрсдийн эх үүсвэрээс олгох бөгөөд БОАЖЯ-наас зээлийн 9 хувийн хүүгийн санхүүжилтийг банкнуудад олгоно. Харин ААН-үүдийн банкнаас авах зээлийн хүү 9 хүртэл хувь байх бол зээлийн дээд хэмжээ 200 сая төгрөг байна. Түүнчлэн, зээлийг дараах чиглэлээр олгоно:

- ☐ Цахилгаан халаагуур суурилуулах
- ☐ Бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах
- ☐ Эко ариун цэврийн байгууламж байгуулах
- ☐ Ариун цэврийн өрөө бүхий жуулчны гэр байгуулах

- ☐ Эрүүл ахуйн шаардлага хангасан тоног төхөөрөмж суурилуулах²²

Тус зээлийн эх үүсвэр нь БОАЖЯ-наас гаргасан иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүний эх үүсвэр бөгөөд тус яамнаас нийт 33 тэрбум төгрөгийн зээл олгох боломжтой гэж тооцсоныг боломжит эх үүсвэрийн хэмжээ гэж үзсэн.

Бүлэг Х.1.2 Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

Зээлийн бүтээгдэхүүн 1. БОАЖЯ - Иргэдэд зориулсан ногоон зээл – 33 тэрбум ₮

БОАЖЯ-наас иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүн 2019 оны 8 сард гаргасан. Зээлийн нийт эх үүсвэр нь 33 тэрбум төгрөг байх бөгөөд банкнууд өөрсдийн хөрөнгөөр зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж, БОАЖЯ-наас зээлийн 9 хувийн хүүгийн санхүүжилтийг банкнуудад олгоно. Зээлийн боломжит эх үүсвэрийн хэмжээг БОАЖЯ-аас тооцсоны дагуу 33 тэрбум гэж үзсэн. Зээлийн зориулалт нь цахилгаан халаагуур, гэр, байшингийн дулаалга, эко ариун цэврийн байгууламж зэрэг байна. Уг зээлийг ХААН, Хас, Төрийн банкнуудаар дамжуулан олгох бөгөөд банкнууд дараах нөхцөлтэйгөөр уг зээлийг олгоно.

Хүснэгт Х2.3 ОББҮХорооны ногоон зээлийг олгох банкнууд, зээлийн нөхцөл

Банк	Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
ХААН	5-15 сая төгрөг	8%	30 сар
Хас	Тодорхой болоогүй	Тодорхой болоогүй	Тодорхой болоогүй
Төрийн Банк	10-15 сая төгрөг	9%	30 сар

Зээлийн бүтээгдэхүүн 2. Иргэдэд зориулсан ногоон зээлийн бусад бүтээгдэхүүн

Одоогийн байдлаар ХААН Банк, Төрийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Капитрон Банк болон Ариг Банк өөрсдийн эх үүсвэрээс санхүүжүүлж, иргэдэд зориулан гаргасан ногоон зээлийн бүтээгдэхүүнтэй байна. Харин томоохон ББСБ-уудаас зөвхөн Транскапитал ББСБ иргэдэд зориулсан ногоон зээлийн

²² <https://www.facebook.com/mne.mn/posts/2441829979247711> (БОАЖЯ албан хуудас)

бүтээгдэхүүнтэй байна. Уг ногоон зээлийн хүү нь банкны зээлийн хүүтэй харьцуулахад өндөр байна.

Хүснэгт Х2. 4 Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүт ээгдэхүүнүүд, т эдгээрийн нөхцөл

Бүт ээгдэхүүн	Жилийн хүү	Хугацаа	Зээлийн хэмжээ	Юуг санхүүжүүлэх вэ?
ХААН Банк: Иргэдэд зориулсан ногоон зээл	16.8%-18.6%	30 сар хүртэл	15 сая төгрөг	Иргэдийн эко бараа бүтээгдэхүүний хэрэглээ (агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн)
Төрийн Банк: Ногоон зээл	18-19.2%	12-30 сар	30 сая төгрөг	Унадаг дугуй, цахилгаан скүүтер, 100% цахилгаан автомашин
Ариг Банк: Эко автомашины зээл	19.2-21.6%	30 сар	50 сая төгрөг	Эко автомашин
ХХБанк: Эко автомашины зээл	19.2%	Иргэн 30 сар ААН 48 сар	40 сая төгрөг	Эко автомашин (цахилгаан, хий, хосолсон хөдөлгүүртэй)
Капитрон Банк: Цахилгаан дугуйны зээл	20.4%	30 сар	1.4 сая төгрөг	Цахилгаан дугуйны худалдан авалт
Транскапитал ББСБ: Ногоон зээл	28.8-36%	2-5 жил	50 сая хүртэл төгрөг (орон сууц хязгааргүй)	Иргэдийн эко хэрэглээ (орон сууц, автомашин, хэрэглээний бараа)

Бүлэг Х.2. Ногоон санхүүжилт олгох үйл ажиллагаа нь зогссон эсвэл эхлээгүй байгаа төслүүд болон зээлийн бүтээгдэхүүнүүд

Эхлээгүй байгаа ногоон санхүүжилтийн ДҮН = 202 тэрбум төгрөг

1. Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл – 202 тэрбум төгрөг (75.7 сая ам.доллар)

Энэхүү төслийг Азийн Хөгжлийн Банк, БОАЖЯ хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд Уур Амьсгалын Ногоон Сан, Өндөр Түвшний Технологийн Сан, Азийн

Хөгжлийн Сан зэрэг сангуудын хөрөнгөөр санхүүжүүлж байна. Нийт санхүүжилт нь 228 сая ам.доллар байгаагаас 53 сая ам.доллар нь буцалтгүй тусламж, 175 сая ам.доллар нь зээл хэлбэрээр олгогдох юм. Төсөл 2018 онд батлагдсан бөгөөд 2024 он хүртэл хэрэгжих төлөвлөгөөтэй байна. Энэ төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын гэр хорооллын 100 га газрыг эко-дүүрэг болгон хөгжүүлэхэд оршиж байна. Үүний тулд 10000 ногоон орон сууцны нэгж (housing unit) барих бөгөөд барилгын ажлыг гүйцэтгэх ААН-үүдийг ногоон зээлээр санхүүжүүлэх юм. Нийт ногоон орон сууцны 55%-ийг нь банкны хөнгөлөлттэй зээлээр, зах зээлийн үнээс хямд худалдан авах боломжтой байх бол, 15% нь түрээсийн, 30% нь зах зээлийн үнээр бөгөөд банкны зээлээр авах боломжтой орон сууц байх юм. НУАСангаас олгох зээлийн 75.7 сая ам.доллар хүртэлх

хэмжээний санхүүжилт эдгээр ногоон зээлийг олгоход зориулагдсан Эко-дүүрэг Орлогд Нийцсэн Орон Сууцны Сан-д төвлөрнө. Ногоон зээл олгоход Хас, ХААН, Голомт, ХХБанкуудтай хамтарч ажиллах хүлээлттэй байгаа ч одоогийн байдлаар ногоон зээл олгох үйл ажиллагаа хараахан эхлээгүй байна. Барилгын компаниудад олгох зээлийн дундаж хүү 15% орчим байхаар хүлээгдэж байгаа бол, ногоон орон сууцны зээл 8-10%-ийн хүүтэй байхаар тооцогдсон байна.²³

2. Switch-Off Air Pollution буюу “Дулаан шийдэл” төсөл – Эх үүсвэрийн хэмжээ тодорхойгүй

Европын Холбооны Switch Asia хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй уг төсөл нь Хас Банктай хамтран ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэхээр төлөвлөж байна. Уг төсөл нь Улаанбаатар хотын гэр хороололд дулааны алдагдал багатай байшин барихад дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэхэд чиглэж байна. Төслийн зорилтот бүлэг нь гэр хорооллын бага, дунд орлоготой өрхүүд бөгөөд тэдэнд орон байраа дулаалахын тулд хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг хангахыг зорьж буй юм. Түүнчлэн барилгын салбарын ЖДҮ эрхлэгчид эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын шийдэл, зөвлөгөө, санхүүгийн зуучлалын үйлчилгээг уг төслөөс авч болох юм. Гэвч одоогоор ногоон зээл олгох үйл ажиллагаа эхлээгүй байна.²⁴

Зогссон ногоон санхүүжилт

3. Ногоон зээлийн баталгааны сан

Тус санг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Голландын Засгийн Газар хамтран 2007 онд байгуулсан бөгөөд цэвэр үйлдвэрлэлийн ААН (clean production) болон эрчим хүч хэмнэх төслүүдэд зээлийн баталгаа гаргах зорилготойгоор Голомт банктай хамтарч ажиллаж байсан. Уг сан нь үүсгэн байгуулагдсанаас хойш, 2007-2009 онд нийт 8 аж ахуйн нэгжид 385 сая төгрөгийн зээлийн батлан даалт гаргаж ажилласан бөгөөд

одоогоор үйл ажиллагаа явуулахгүй байна. Батлан даалтыг дараах чиглэлүүдэд гаргасан:

- ☐ Хатуу хог хаягдал дахин боловсруулах, химийн хорт бодисын хэрэглээг бууруулах
- ☐ Ойн нөхөн сэргээлтийг сайжруулах
- ☐ Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох
- ☐ Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Баталгаа гаргуулах төслүүдэд тавьдаг үндсэн шалгуурууд нь:

- ☐ Эрчим хүчний үр ашгийн эсвэл технологийн хувьд цэвэр хөрөнгө оруулалтын төсөл байх
- ☐ Одоогийнхоос эрчим хүчний үр ашиг дээшилсэн, байгаль орчны бохирдол (хаягдал) буурсан байх

Мөн төсөл хэрэгжүүлэгчдэд дараах техникийн болон санхүүгийн шалгуурыг тавьдаг:

- ☐ Хамгийн багадаа 2 техникийн шинжээчтэй байх, тэдгээр нь 6-аас доошгүй жилийн ажлын туршлагатай байх.
- ☐ Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлийн төсөл хэрэгжүүлж байсан техникийн дадлага туршлагатай байх.
- ☐ Хөрөнгө оруулалтын төслийн талаар тодорхой ойлголттой байх.
- ☐ Ямар нэг банк, санхүүгийн болон татварын байгууллагад өр, зээлгүй байх.
- ☐ Тухайн төслийн зээл, хөрөнгийн харьцаа 50 хувиас бага байх.
- ☐ Хамгийн багадаа сүүлийн нэг жил ашигтай ажилласан байх.

4. Хас Банкны Хүлэмжийн хийг бууруулахад зориулсан орон сууцны зээл

Энэ зээлийн бүтээгдэхүүнийг 2013 оноос хойш олгоогүй бөгөөд одоогоор олголт хийгдэхгүй байна. Зээлийн нөхцөлийг Хүснэгт Х2.5-д харууллаа. Тус зээлийг олгогдож байх хугацаанд нийт 30 зээлдэгч 891.7 мянган ам.долларын зээл авсан.

²³ Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк, “Ulaanbaatar Green Affordable Housing and Resilient Urban Renewal Sector Project: Project Administration Manual”, 2018 оны 8 сар, <https://www.adb.org/sites/default/files/project-documents/49169/49169-002-pam-en.pdf>

²⁴ Эх сурвалж: ЖЭРЭС (Сэргээгдэх эрчим хүч болон байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм) байгууллагын Монгол улс дахь нэгж

5. Хас Банкны Эко автомашины зээл

Энэ зээлийн олголт одоогоор зогсонги байдалд байна. Зээлийн нөхцөлийг Хүснэгт Х2.5-д харууллаа. Тус зээлийг олгогдож байх хугацаанд нийт 804 зээлдэгч 3.7 сая ам.долларын зээл авсан.

Хүснэгт Х2.5 Одоогоор олгогдохгүй байгаа зээлийн бүт ээгдэхүүнүүд

Бүт ээгдэхүүн	Жилийн хүү	Хугацаа	Зээлийн хэмжээ	Юуг санхүүжүүлэх вэ?
Хас Банк: Хүлэмжийн хийг бууруулахад зориулсан орон сууц худалдан авах зээл	18%	20 жил хүртэл	N/A	Нийтийн орон сууц, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц худалдан авах
Хас Банк: Эко автомашины зээл	16.8%	60 сар хүртэл	150 сая төгрөг	Монгол улсад ашиглаж байгаагүй, улсын дугаар аваагүй, эко машин худалдан авах

Бүлэг Х.3. Нэхмэлийн салбарт чиглэсэн болон нэхмэлийн салбарын ААН-үүд авч болох ЖДҮ-ийг дэмжих зорилготой бусад (ногоон биш) зээлийн бүтээгдэхүүнүүд

Боломжит эх үүсвэрийн ДҮН – 402 тэрбум төгрөг

Зээлийн бүтээгдэхүүн 1. Ноолуур хөтөлбөрийн зээл – 260,500,000,000 төгрөг

Энэхүү хөтөлбөрийг ХХААХҮЯам “Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” зорилготойгоор 2018-2021 онд хэрэгжүүлнэ. Санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, ЗГ-ын гадаад, дотоод үнэт цаас зэрэг байна. Төслийн нийт санхүүжилт нь 973.3 орчим тэрбум төгрөг байх бол үүний 500 тэрбумыг нь МУХБ-ны хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ.

2018 оны гүйцэтгэлээр МУХБанкнаас нийт 188.2 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл 20 ААН-д олгосон байна (6 зээлдэгчид шүүд зээлээр 96.6 тэрбум төгрөгийг, Голомт, ХААН, ХХБ, Хас, Капитрон банкнуудаар дамжуулан 14 дэд зээлдэгчид 91.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон).²⁵ Хөтөлбөрийн хүрээнд олгож буй зээл нь одоогоор голдуу эргэлтийн хөрөнгийн санхүүжилт хийж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн зээл хараахан олгож эхлээгүй. 2019 оны 6 сарын байдлаар МУХБ-аас шүүд зээл авахаар 8 компани нийт 245 тэрбум төгрөгийн хүсэлт илгээснээс, МУХБ-аас тавьж буй шалгуурууд болон барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүйгээс 4 компанийн хүсэлт буцаагдаж, 3 компани өөрсдөө хүсэлтээ цуцалжээ. Харин арилжааны банкнуудаас 152.3 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн хүсэлт ирж, үүнээс 51.3 тэрбум төгрөгийн зээлийг 14 зээлдэгчдэд олгохоор шийдвэрлэжээ.²⁶ 2019 онд ноолуур хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт санхүүжилт 150 тэрбум төгрөг байхаар батлагдсан байна. Түүнчлэн 2019 оны 6 сараас эхлэн МУХБ-аас шүүд олгох зээлийн дүн 20 тэрбум төгрөгөөс доошгүй байхаар болсон байна.

²⁵ Эх сурвалж: ХХААХҮЯ, “НООЛУУР” ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, 2019 оны 3 сарын 20, <http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/nooluur2018.pdf>

²⁶ Эх сурвалж: МУХБ-ны Зээлийн газар

Тус зээлийн боломжит эх үүсвэрийн хэмжээг нийт эх үүсвэр 500 тэрбум төгрөгөөс одоогоор олгогдсон нийт зээлийн хэмжээ 239.5 тэрбум төгрөгийг хасаж, 260.5 тэрбум төгрөг гэж тооцов.

Зээлийг МУХБ-аас шууд болон арилжааны банкнуудаар дамжуулан олгож байгаа бөгөөд зээлийн нөхцөл одоогоор дараах байдалтай байна:

- ☐ Жилийн хүү: 12%
- ☐ Зээлийн хэмжээ: Төслийн нийт өртгийн 85 хүртэлх хувь
- ☐ Хугацаа: 2 жил хүртэл

Зээл хүсэгчид дараах шаардлагыг тавьдаг:

- ☐ Сүүлийн 3 жил үйл ажиллагаа тогтвортой эрхэлсэн байх
- ☐ Төслийн нийт санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг шийдсэн байх
- ☐ Ноолуур самнах буюу түүнээс дээш шат дамжлагад үйлдвэрлэл явуулж байх
- ☐ Төслийн ТЭЗҮ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ зэргийг заавал хийсэн байх
- ☐ Бусад шаардлагуудын дэлгэрэнгүйг <http://dbm.mn/activity/project-program/requirement> веб хуудаснаас харах боломжтой.

Зээлийн бүтээгдэхүүн 2. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийн зээл – 22.4 тэрбум төгрөг

Энэ төсөл нь Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2016-2020 онд хэрэгжиж байгаа бөгөөд агробизнесийн чиглэлийн хувийн аж ахуйн

нэгжүүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд хөрөнгө оруулснаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой. Төсөлд хамаарах салбарууд нь арьс шир, ноос ноолуур, оёдол зэрэг хөнгөн үйлдвэр, мөн хүнс хөдөө аж ахуйн салбарууд (мах, сүү, жимс, зөгийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, эрчимжсэн МАА гэх мэт) байна. Уг төслийн санхүүжилтээр арилжааны 6 банк (Хүснэгт Х2.6) зээл олгож байна.

Тус төслийн зээлийн нийт эх үүсвэр нь 41.3 сая ам.доллар бөгөөд уг дүнг 2016-2019 оны дундаж ханшаар төгрөгт шилжүүлбэл 100.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс зээлийн нийт олголт 78.1 тэрбум төгрөгийг хасвал одоогийн боломжит эх үүсвэр 22.4 тэрбум төгрөг гэж тооцогдож байна.

Төслүүдэд тавих зарим ерөнхий шалгуур:

- ☐ Монголын талын эзэмшил 50%-аас доошгүй байх
- ☐ Бизнесээ доод тал нь 2 жил явуулж буй
- ☐ Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангаар цэвэр ашгийн хэмжээ 2.5%-аас дээш байх
- ☐ Барьцаа хөрөнгөтэй байх
- ☐ Төслийн нийт зардлын 15-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх
- ☐ Хөрөнгө оруулалтын санхүүгийн дотоод өгөөжийг тооцоолсон хувь хэмжээ нь хөрөнгийн жигнэсэн дундаж өртгөөс их байх;
- ☐ Хөрөнгө оруулалтын эдийн засгийн дотоод өгөөжийг тооцоолсон хувь хэмжээ нь 12%-аас дээш байх

Хүснэгт Х2. 6 “ХААХХ т өслийн нэмэлт санхүүжилт” т өслийн зээл олгогч банкнууд, зээлийн нөхцөл

Банк	Юуг санхүүжүүлэх вэ?	Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
ХААН	Монголын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай төслүүдэд зориулан олгоно.	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил
Хас	Мах, сүү, арьс шир, ноос ноолуур, оёдол, зөгийн аж ахуй, жимс жимсгэнэ, эрчимжсэн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, шилмэл малын үржил, үрийн үйлдвэрлэлийн салбарт үйл	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил

	ажиллагаа явуулж буй бизнесийн үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлнэ.			
Голомт	Агробизнесийн чиглэлийн хувийн аж ахуйн нэгжүүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил
ХХБ	Аж ахуйн нэгжийн нэмүү өртгийн сүлжээг цогцоор нь боловсронгуй болгох зорилгоор төсөл хэрэгжүүлэгчийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын санхүүгийн хэрэгцээг хангахад зориулагдана.	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил
Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк	Агробизнесийн чиглэлийн хувийн аж ахуйн нэгжүүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил
УБ хотын банк	Агробизнесийн чиглэлийн хувийн аж ахуйн нэгжүүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх	150,000-3,000,000 ам.доллартой тэнцэх төгрөг	8%	7 жил

Ноос, ноолуурын салбарт дараах тусгай, нэмэлт шаардлагуудыг тавьдаг:

- ☐ Ээрмэл, нэхмэл бүтээгдэхүүн хийх төсөл байх;
- ☐ Сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хувьд санал болгож буй НӨСХО нь экспортод гаргахаар байх;
- ☐ Угааж, самнасан ноос, ноолуур үйлдвэрлэгчдийг (а) зөвхөн олон улсад танигдсан нэр хүндтэй брэндтэй хамтарсан брэнд хөгжүүлэлт хийх зорилгоор сүүлийн 3 жилд экспорт хийж байгаа болон (б) НӨСХО-ын дэд төслийн зээл авснаас хойш 3 жилийн дотор экспортын борлуулалтыг 20%-иар нэмэгдүүлэх тохиолдолд санхүүжүүлнэ;
- ☐ Үйлдвэрлэлийн процессыг нэлэнхийд нь хамарсан чанарын хяналтын боловсон хүчний нөөц, нэгжтэй байх;
- ☐ Монгол улсын боловсруулах болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй салбарын дотор болон бусад салбартай хамтран ажиллаж байх.

Зээлийн бүтээгдэхүүн 3. Германы КФВ банкны ЖДҮ-г дэмжих төслийн зээл – 9.4 тэрбум төгрөг (2019 оны эхний хагасын байдлаар)

Уг төслийн зээл нь ХАА болон боловсруулах үйлдвэрийн ЖДҮ-г дэмжих зорилготойгоор Германы КФВ банкнаас Монголбанкаар дамжин арилжааны банкнуудад, арилжааны банкнуудаас ААН-үүдэд олгогддог зээл юм. Эх үүсвэр нь МУ-ын ЗГ, ХБНГУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай олгосон 8.7 сая еврогийн зээл бөгөөд Монголбанк зээлийг төсөлд оролцогч ХХБ, Голомт, УБХБ, Капитрон, Тээвэр хөгжлийн банкнуудаар дамжуулан олгодог. Уг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш уг төслийн зээлд нийт 171 ЖДҮ хамрагдаж, 86.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. 2019 оны 2-р улирлын эцсийн байдлаар 48 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 7.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй зээлийн дундаж хэмжээ 146 сая төгрөг байна. Түүнчлэн зээлийн боломжит эх үүсвэр 9.4 тэрбум төгрөг байна.²⁷

Хүснэгт Х2. 7 Германы КФВ банкны ЖДҮ-г дэмжих төслийн зээлийн нөхцөл

Банк	Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
Голомт	500 сая төгрөг	12%	60 сар
Бусад	250 мян.евро	16-18%	60 сар

²⁷ Эх сурвалж: Монгол банк, Дамжуулан олгох төслийн зээлийн 2019 оны 2-р улирлын тайлан

Зээлийн бүтээгдэхүүн 4. Азийн Хөгжлийн Банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл – 2.3 тэрбум төгрөг

Монгол Улс, Азийн Хөгжлийн Банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2154 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн. Монголбанк эцсийн зээлдэгчид төсөлд оролцогч Голомт, Улаанбаатар хотын банк, Ариг, Богд банкнуудаар дамжуулан зээл олгодог. 2019 оны 2-р улирлын эцсийн байдлаар төслийн хүрээнд банкнуудад дамжуулан олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 2.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд эргэлтийн санд зээлдүүлэх боломжит эх үүсвэр 2.3 тэрбум төгрөг байна. Мөн улирлын байдлаар нийт 88 эцсийн зээлдэгч үлдэгдэлтэй байгаа бөгөөд тэдний шинээр бий болгох ажлын байрны тоо 266 байна.²⁸

Хүснэгт Х2. 8 Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
30 сая төгрөг	10%	24 сар

Зээлийн бүтээгдэхүүн 5. Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангийн зээл – 21 тэрбум төгрөг

Уг сангийн үйл ажиллагаа 2009 оноос хойш явагдаж байгаа бөгөөд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилготой. Уг сангаас 2009-2012 онд 5171 иргэн, ААН-д зээл олгосон бол 2013 онд нийт 490 төсөлд 59 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээс 28 хувь нь хөнгөн үйлдвэрийн салбарт олгогджээ. Харин 2014-2015 онд нийт 947 төсөлд 150 тэрбум төгрөгийн зээл олгожээ²⁹. 2016 он гэхэд нийт 7173 төсөлд 775.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байсан бол 2019 оны эхний хагаст зээлдэгчийн тоо 7747 болж, зээлийн үлдэгдэл 215 тэрбум төгрөг

²⁸ Эх сурвалж: Монгол банк, Дамжуулан олгох төслийн зээлийн 2019 оны 2-р улирлын тайлан

²⁹ Эх сурвалж: Монгол банк, “ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал”, 2015 оны 6 сар

байна. Тус сангаас зээл авсан нэхмэлийн салбарын ААН-ийн төлөөллөөр “Цаст Согоот”, “Нано Вүүл” зэрэг сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг нэрлэж болохоор байна. Түүнчлэн 2019 онд ноос ноолуурын салбарын 24 төсөлд 2.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор батлагдсан байна.³⁰ Харин одоогийн боломжит эх үүсвэрийг 2019 оны батлагдсан төсөв 47 тэрбум төгрөгөөс 2019 онд олгогдсон зээлийн дүн болох 26 тэрбум төгрөгийг хасаж 21 тэрбум төгрөг гэж тооцов. Зээлийг ЖДҮХСангаас шууд болон арилжааны банкнуудаар дамжуулан олгодог бөгөөд төслийн нийт өртгийн 30-аас багагүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлага тавьдаг. Зээлийн нөхцөл дараах байдалтай байна.

Хүснэгт Х2. 9 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн нөхцөл

Зээлдүүлэгч	Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа
ЖДҮХС	300 сая төгрөг	3%	5 жил
Арилжааны банкнууд	1 тэрбум төгрөг	7%	5 жил

Зээлийн бүтээгдэхүүн 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээл – 14.4 тэрбум төгрөг

Уг сан нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд 2011 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Сангаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн нэг болох “Жижиг зээл” нь ажлын байр бий болгох зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, ААН, нөхөрлөл хоршоо хэлбэрээр бичил бизнес эрхлэгчдэд олгогддог. Жижиг зээлийг 2002 оноос хойш арилжааны банкнуудаар дамжуулан олгож эхэлсэн бөгөөд 2018 оны 9 сарын байдлаар Голомт, ХААН, Төрийн банкнууд дамжуулан зээлийн үлдэгдэлтэй байсан. 2017-2018 онд Голомт банкнаас нийт 1878 зээлдэгчид 20 тэрбум төгрөгийн зээл олгоод байсан бөгөөд тус банкны дамжуулан зээлийн хугацаа 2019 оны 9 сарын 10-нд дуусна. Харин ХААН, Төрийн банкнууд 2018 онд авсан дамжуулан зээлийн эх үүсвэр (харгалзан 9 тэрбум болон 6.9 тэрбум төгрөг)-ээсээ 2018 оны 9 сар гэхэд нийт 164 зээлдэгчид 1.5 тэрбум орчим төгрөгийн зээл олгоод байсан байна³¹.

³⁰ ЖДҮХС, Зээлийн удирдлагын хэлтэс

³¹ Эх сурвалж: Сангийн Яам, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тэмдэглэл”, 2018 он

Иймд зээлийн боломжит эх үүсвэрийг ХААН, Төрийн банкнуудад байршуулсан 15.9 тэрбум төгрөгөөс олгогдсон 1.5 тэрбум төгрөгийг хасаж, 14.4 тэрбум гэж тооцов. Одоогийн байдлаар ХААН Банк, Төрийн Банкаар дамжин, зөвхөн хөдөө

Хүснэгт Х2. 10 Хөдөлмөр эрхлэлт ийг дэмжих сангийн жижиг зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа	Үндсэн т өлбөрөөс чөлөөлөх
Иргэн 10 сая, ААН 20 сая	7.2%	24 сар	6 сар

Зээлийн бүтээгдэхүүн 7. “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээл – 71.9 тэрбум төгрөг

Хүснэгт Х2. 11 “Зээлийн бат лан даалт ын т огт олцоог дэмжих замаар эдийн засгийг т өрөлжүүлэх, ажил эрхлэлт ийг нэмэгдүүлэх т өсөл”-ийн зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ	Жилийн хүү	Хугацаа	Үндсэн т өлбөрөөс чөлөөлөх	Бат лан даалт ын хувь
1 тэрбум төгрөг	12-15%	120 сар	24 сар	30-60% /500 сая төгрөгөөс хэтрэхгүй/

Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр 2016-2021 онд хэрэгжиж буй түс төслийн зээл нь Зээлийн Батлан Даалтын Сангийн батлан даалттайгаар барьцаа

Зээлийн бүтээгдэхүүн 8. Банк бус санхүүгийн байгууллагуудын бизнесийн зээл

Нэхмэлийн салбарын үйлдвэрлэгчид ББСБ-уудаас зээл авах нь ховор байна. Тухайлбал Ард кредит ББСБ болон Инвескор ББСБ-д нэхмэлийн салбарын нэг

орон нутагт жижиг зээл олгогдож байгаа бөгөөд зээлийн нөхцөл дараах байдалтай байна.

хөрөнгийн дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд арилжааны банкнуудаар (ХААН, ХХБ, Капитрон, Хас, Төрийн Банк) дамжуулан олгож буй зээл юм. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш нийт 219 зээлдэгчид 74 тэрбум орчим төгрөгийн зээл олгогдсоноос нэхмэлийн салбарын 7 зээлдэгчид 2.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. 2019 оны 2-р улирлын байдлаар зээлийн нийт үлдэгдэл 70.5 тэрбум төгрөг байгаагаас 2.5 тэрбум орчим нь нэхмэлийн салбарынх байна.³² Түс төслийн зээлийн нийт эх үүсвэр нь 60 сая ам.доллар буюу 2016-2019 оны дундаж ханшаар төгрөгт шилжүүлбэл 146 тэрбум төгрөг бөгөөд үүнээс олгогдсон зээл 74 тэрбум төгрөгийг хасвал боломжит эх үүсвэр 71.9 тэрбум төгрөг гэж тооцогдож байна. Зээлийн нөхцөл, тавигдах шаардлага дараах байдалтай байна.

Зээл хүсэгчид тавигдах шаардлага:

- ☐ Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа эрхэлдэг байх,
- ☐ Сүүлийн 6 сарын хугацаанд хугацаа хэтэрсэн, чанаргүй өр зээлийн үлдэгдэл үүсээгүй байх,
- ☐ Нэгээс дээш жил үйл ажиллагаа явуулсан, санхүүгийн орлоготой байх.
- ☐ Зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байх.
- ☐ Төсөл (энгийн, ойлгомжтой)
- ☐ ЖДҮ эрхлэгч байх (гэрчилгээ, тодорхойлолт)

³² Эх сурвалж: Зээлийн Батлан Даалтын Сан

ч ААН зээлийн үлдэгдэлгүй байна. Энэ нь банкнуудын олгож буй төслийн зээлүүдтэй харьцуулахад ББСБ-ын зээлийн хүү өндөр байгаатай холбоотой. Түүнчлэн 2018 онд ББСБ-уудаас олгосон нийт зээлийн 2% нь л боловсруулах үйлдвэрлэлийн салбар (энэ нь дотроо нэхмэлийн салбарыг агуулна)-т олгогдсон байна. ББСБ-уудын олгосон зээлийн дийлэнх нь барилга, худалдааны салбарууд, мөн иргэдийн хэрэглээний зээл байдаг байна.³³ Транскапитал, Ард Кредит зэрэг ББСБ-ууд ЖДҮ болон бичил бизнест зориулсан зээлийн бүтээгдэхүүнтэй байна. Зарим томоохон ББСБ-уудын бизнесийн зээлийн нөхцөл дараах байдалтай байна

Хүснэгт Х2. 12 ББСБ-уудын бизнесийн зээлийн нөхцөл

<i>Бүт ээгдэхүүн</i>	<i>Инвескор ББСБ: Бизнесийн зээл</i>	<i>Нэт капит ал ББСБ: Бизнесийн зээл</i>	<i>Транскапит ал ББСБ: Бизнесийн зээл</i>	<i>Ард Кредит ББСБ: Бизнесийн зээл</i>
Жилийн хүү	33.6%- 40.8%	38.4-58.8%	28.8-34.8%	25.2-27.6%
Хугацаа	36 сар хүртэл	36 сар хүртэл	60 сар хүртэл	36 сар хүртэл
Зээлийн хэмжээ	2 тэрбум хүртэл төгрөг	500,000-100 сая төгрөг	400 сая хүртэл төгрөг	2-200 сая төгрөг

³³ Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо, Банк бус санхүүгийн байгууллагын газар, “Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга”

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БУЙ, НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСЛҮҮДИЙН ТОЙМ

Монгол улсад ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр одоо хэрэгжиж буй олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүдийг тоймлон авч үзлээ. Эдгээр нь ихэвчлэн эрчим хүчний үр ашиг, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжиж буй бүтээн байгуулалт, техникийн тусламж хэлбэрийн төслүүд байгаа бөгөөд ногоон санхүүжилтийн элемент агуулаагүй байна.

Азийн Хөгжлийн Банкны төслүүд

- ☐ Сэрмсанг Хөшигтийн Хөндийн нарны цахилгаан станцын төсөл
- ☐ Сэргээгдэх эрчим хүчний салбарыг өргөтгөх төсөл
- ☐ Ногоон хот төлөвлөлт (Техникийн тусламж)
- ☐ Energy Storage Option for Accelerating Renewable Energy Penetration (Техникийн тусламж)
- ☐ Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр
- ☐ Усны засаглалыг сайжруулахад шинэлэг арга барил нэвтрүүлэх нь (Техникийн тусламж)
- ☐ Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны хөтөлбөрийн хотуудад нүүрстөрөгч бага ялгаруулдаг хөгжлийг дэмжих төсөл
- ☐ Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл
- ☐ Дархан хотын бохир усны менежментийн төсөл

ЯОУХАБ (JICA)-ын төслүүд:

- ☐ Хүлэмжийн хийн тооллого хийх чадавхыг бэхжүүлэх замаар үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх мөчлөгийг тасралтгүй сайжруулах төсөл
- ☐ Нийтийн тээврийн автобусыг дизелийн тортгийн "DPF" шүүлтүүрээр тоноглож утаан дахь тортгийн ялгарлын бууралтыг түрших төсөл

Дэлхийн Банкны төслүүд:

- ☐ Эрчим хүчний салбарын 2 дахь төсөл
- ☐ Улаанбаатар Цэвэр Агаар төсөл

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны төслүүд:

- ☐ Говийн Нарны Эрчим Хүч Төсөл
- ☐ Улаанбаатарын Төвийн дулаан хангамжийн төсөл
- ☐ Сайншандын салхин цахилгаан станцыг барьж байгуулах төсөл
- ☐ Улаанбаатар хот дахь хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл
- ☐ "Ногоон хотууд" төсөл
- ☐ Цэций салхин цахилгаан станцыг барьж байгуулах төсөл
- ☐ Салхитын салхин цахилгаан станцыг барьж байгуулах төсөл
- ☐ Магнай трейд компанийн шингэрүүлсэн шатдаг хийн нийлүүлэлтийн төсөл

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн төслүүд:

- ☐ UN-REDD Үндэсний Хөтөлбөр
- ☐ Монгол Улсын баруун бүс нутаг дахь газрын доройтлыг нөхөн сэргээх, таслан зогсоох

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн төслүүд:

- ☐ Эрчим хүчний салбар дахь төрийн хөрөнгө оруулалт - 2 дахь үе шат
- ☐ "Ногоон алт" бэлчээрийн төсөл
- ☐ Тогтвортой Бичил Уурхай төсөл

Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн төслүүд: "Эрчим хүчинд хэмнэлттэй барилгын сэргээн засалт" төсөл

Европын Холбооны төслүүд:

- ☐ Монгол Улсад Ногоон, эрчим хүчний үр ашигтай барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих төсөл
- ☐ "Хонины ноосоор байгальд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх: Нийлүүлэлтийн сүвгийг хөгжүүлэх цогц арга зам" төсөл
- ☐ Барилгын материал дахин боловсруулах төсөл
- ☐ "Green Products Development and Labelling in Mongolia" төсөл

Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Байгууллагын төслүүд:

- ☐ Монголын Ногоон Хөгжлийн Шилжилт - 2-р үе шат
- ☐ Монголын Ногоон Зээлийн Сан

ХАВСРАЛТ 4. НЭХМЭЛИЙН САЛБАРЫГ ДЭМЖСЭН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСЛҮҮД

Төсөл 1. Юниетerra хөтөлбөр

Энэ хөтөлбөрийг Канадын Засгийн Газрын санхүүжилтээр Канад Улсын Дэлхийн Их Сургуулийн Үйлчилгээ ТББ болон Олон Улс Сүдлал Хамтын Ажиллагааны Төв хамтран 2015-2018 онд хэрэгжүүлсэн. Уг төсөл нь барилга болон нэхмэлийн салбарын нэмүү өртгийг нэмэгдүүлэх, залуучууд, эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломжийг сайжруулахад чиглэсэн. Төслийн зүгээс ноос ноолуурын салбарт хийсэн зарим гол ажлууд нь:

- ☐ Тус салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилготой сургалт, семинарууд
- ☐ Тус салбарын ирээдүйн ажиллах хүчийг бэлтгэдэг их дээд сургуулиуд болон салбарын үйлдвэрлэгчдийн харилцаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах
- ☐ “Ноос, ноолуурын салбарын Хамтын ажиллагааны зөвлөл”-ийг санаачлан байгуулсан
- ☐ Ноос ноолуурын салбарт залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой StartUp Weekends хөтөлбөр
- ☐ Ноос ноолуур боловсруулах мини технологиудыг сурталчлах

ХАВСРАЛТ 5. НЭХМЭЛИЙН САЛБАРТ НОГООН САНХҮҮГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Энэ хавсралтад нэхмэлийн салбарын ногоон үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд амжилттай хэрэгжсэн, ногоон санхүүжилтийн арга хэрэгсэл ашигласан 2 төслийг товч танилцуулна.

Туршлага 1. Хятад улсын “Improving energy-efficiency and environmental performance of Chinese SMEs and large companies facilitated by voluntary public-private partnerships” (VA3) төсөл

Энэ төсөл нь төр-хувийн хэвшлийн сайн дурын хамтын ажиллагаагаар дамжуулан тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх зорилготойгоор 2012-2015 онд хэрэгжсэн. Beijing, Nanjing, Jingzhou болон Jinan, Hangzhou, Xian, Baoding, Tianjin зэрэг хотуудад хэрэгжсэн. Нийт төсөв нь 1.9 сая евро, үүний 80 хувийг Европын холбоо санхүүжүүлсэн.

Төслийн зорилтот бүлэг, оролцогч талууд:

- БНХАУ-ын угаалга болон нэхмэлийн салбарын ЖДҮ-үүд (550 угаалга, 150 нэхмэл)
- Эрчим хүчний хэрэглээ өндөртэй томоохон компаниуд
- ТББ-ууд, ЖДҮ эрхлэгчдийн холбоод (олон тооны ЖДҮ-үүдийг төсөлд хамруулах үүрэгтэй)
- Улс, орон нутгийн түвшний төрийн байгууллагууд, орон нутгийн байгаль орчин, эдийн засаг, худалдааны байгууллагууд (үйлдвэрлэгчидтэй сайн дурын хэлэлцээр хийх үүрэгтэй)

Төслийн гол бүрэлдэхүүн/хийгдсэн ажлууд:

- ЖДҮ-үүдийн төслийн тухай сургалт
- ЖДҮ эрхлэгчдийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллуулах
- ЖДҮ эрхлэгчдийг санхүүгийн хөшүүргээр хангах

Төслийн стратеги:

- ТХХТ нь том компаниудаас эхэлж, ЖДҮ-үүд болон бусад хотууд руу тархсан.

- Орон нутгийн захиргааны байгууллагууд (ЕРВ буюу байгаль орчныг хамгаалах товчоо) өөрсдийн байгаль орчны сангаас ЖДҮ-үүдэд санхүүгийн хөшүүрэг өгөх замаар сайн дурын хамтын ажиллагааг идэвхжүүлсэн. Үүнд ЖДҮ-үүдийн холбоод чухал нөлөө үзүүлсэн. Учир нь гол асуудал нь ЖДҮ-үүд богино хугацааны ашиг сонирхол буюу ашгаа хэт анхаарч, байгаль орчны асуудлыг тоохгүй байсан.
- Дараагийн ээлжид буюу төслийн эхний үр дүнгүүд гарч эхэлсний дараа орон нутгийн банкнууд ЖДҮ-үүдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлсэн бөгөөд энэ төсөлтэй холбоотой үйл ажиллагааг өөрсдийн ногоон хөгжлийг дэмжих стратегид тусгасан. Өөрөөр хэлбэл ТХХТ-ийн хэрэгжүүлсэн ногоон санхүүгийн хөшүүргээс банкнууд суралцаж, хэрэгжүүлсэн.

Төслийн үр дүн:

- 30 ТХХТ хэрэгжүүлэгчид (салбарын болон засгийн газрын сургагч нар) сургалтад хамрагдаж, үр дүнд нь Европын холбоо, БНХАУ 2-ын хоорондох VA3 төслийн талаарх ойлголт, мэдлэгийн зөрүү багассан. Тэдгээр сургагчид нь Nanjing, Jingzhou хотын ЖДҮ-үүдэд төслийн тухай сургалт өгсөн.
- Сургалтад хамрагдсан ЖДҮ-үүд “Эрчим хүч хэмнэх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах боломж”-ийн тайлан гаргаж, тэдгээр тайлангийн мэдээллийг ТХХТ-ийн хэлэлцээрт ашигласан. Тэдгээр хэлэлцээр хийгдсэнээр ЖДҮ-үүдэд тогтвортой үйлдвэрлэл явуулахад нь тулгарч буй бэрхшээлүүд, ЖДҮ-үүдийн хэрэгцээ шаардлагын талаар нэгдсэн ойлголцолд хүрсэн.
- Төслийн цахим хуудсыг хөгжүүлж, холбогдох талуудад (төрийн байгууллагууд, банкнууд, ЖДҮ-үүд, олон нийт) мэдээлэл түгээх, холбоо харилцаа үүсгэх, ТХХТ-ийг сурталчлан таниулахад ашигласан. Энэ нь харилцан ярианы менежмент болон итгэлийн менежментийг хэрэгжүүлэхэд тусалсан.
- 2012-2015 онд нийт 960 ТХХТ-ийн хэлэлцээр байгуулагдсан. Үүний үр дүнд байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөө: Эрчим хүчний хэмнэлт 503 петажоуль, хүлэмжийн хийн бууралт 17 сая тонн, усны хэмнэлт 464 сая м.куб.
- Төр-хувийн хэвшлийн сайн дурын хэлэлцээр нь орон нутгийн 13-р 5 жилийн төлөвлөгөөнд багтсан.

Амжилттай хэрэгжихэд нөлөөлсөн хүчин зүйлс:

- ☐ Тохиромжтой хамтын ажиллагаа
- ☐ Үе шаттай арга хэмжээнүүд
- ☐ Байгаль орчны тодорхой зорилтууд
- ☐ Үр дүнтэй хяналтын тогтолцоо
- ☐ Мэдээллийн солилцоо (харилцан ярианы менежмент хэрэгжүүлснээр төсөлд оролцогч талууд хэрэгтэй мэдээллээ хоорондоо солилцож, бие биеэсээ суралцах боломжтой болсон.)
- ☐ Итгэл (харилцан ярианы менежмент болон итгэлийн менежментийг хэрэгжүүлсэн нь төр, хувийн хэвшлийн талаас илүү хүчтэй оролцоо хийгдэхэд нөлөөлж, тэдгээрийн доторх дээрээс доошоо, доороос дээшээ харилцааг сайжруулж, төр-хувийн хэвшлийн хооронд үр бүтээлтэй харилцаа үүсэхэд түсэлсэн.)
- ☐ Хүчин чармайлт

Суралцах зүйл: Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын оролцоо, санхүүгийн хөшүүрэг чухал үүрэг гүйцэтгэсэн. Өөрөөр хэлбэл нэхмэлийн салбарын үйлдвэрүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд төрөөс өгсөн санхүүгийн хөшүүрэг түс болсон.

Түршлага 2. Бангладеш улсад хэрэгжсэн Partnership for Cleaner Textile (PaCT) төсөл

Бангладеш улсад Олон Улсын Санхүүгийн Корпорацийн хэрэгжүүлсэн Partnership for Cleaner Textile (PaCT) төсөл нь Бангладеш улсын нэхмэлийн салбарын үйлдвэрлэлийг тогтвортой болгох буюу тус салбарын байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор 2013-2016 онд хэрэгжсэн.

Төслийн зорилтот бүлэг, оролцогч талууд:

- ☐ Нэхмэл бүтээгдэхүүний худалдан авагчид (хувцасны брэндүүд)
- ☐ Нэхмэлийн үйлдвэрүүд
- ☐ Засгийн газар
- ☐ Сонгогдсон кластер (бүс нутаг) дахь төрийн байгууллагууд, хувийн байгууллагууд, иргэд
- ☐ Нэхмэлийн салбарын холбоод
- ☐ Санхүүгийн байгууллагууд

Төслийн гол бүрэлдэхүүн/хийгдсэн ажлууд:

- ☐ Нөөцөд хэмнэлттэй худалдан авалтын шаардлагыг хөгжүүлэх
- ☐ Үйлдвэрүүдийн чадавхыг нэмэгдүүлэх
- ☐ Техникийн мэдлэгийг нэмэгдүүлэх
- ☐ Нэхмэлийн салбарын усны тогтвортой хэрэглээний талаарх үндэсний хэмжээний хэлэлцүүлгийн механизм (Textile Sustainability Platform)-ийг бий болгосон
- ☐ Бангладешийн нэхмэлийн холбоо төсөлтэй хамтран ажиллаж, “Textile Technology Business Center”-ийг байгуулж, техникийн болон санхүүгийн мэдээллийг түгээх замаар дэмжлэг үзүүлсэн.
- ☐ Бангладеш улсын BRAC банкнаас нэхмэлийн салбарт тусгайлан зориулсан “Planet Solutions” хэмээх ногоон зээлийн бүтээгдэхүүнийг ОУСК-ын тусламжтайгаар хөгжүүлэн, 2016 оны 2 сард зах зээлд гаргасан. Энэ нь Бангладеш улс дахь анхны эрчим хүчний хэмнэлтийг санхүүжүүлэх зээл болсон. Нэхмэлийн салбарын эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэхээр зорьж буй үйлдвэрүүд болон эрчим хүчний хэмнэлтийн шийдэл санал болгож буй технологийн компаниудад уг зээл зориулагдсан.

Төслийн ногоон санхүүжилтийн стратеги:

- ☐ Ногоон санхүүжилт авах хүсэлтэй нэхмэлийн үйлдвэрүүд эхлээд төсөлд оролцогчоор бүртгүүлж, төслийн мэргэжилтнүүдээр техникийн болон санхүүгийн үнэлгээ хийлгэнэ. Өөрөөр хэлбэл тэдгээр үйлдвэрүүдэд нөөцийн үр ашгийг дээшлүүлэх ямар боломж байгаа, түүнийг нь хэрхэн санхүүжүүлж болох талаар үйлдвэрүүд өөрсдөө биш, мэргэжлийн зөвлөхүүд үнэлгээ дүгнэлт гаргадаг. Улмаар, төсөлд оролцогч банкнууд үнэлгээ хийлгэсэн үйлдвэрүүдийн зардал-үр ашгийн тооцоо зэргийг хийж, зээлийг олгох, мөн боломжит технологийн компаниудтай холбож өгдөг.

Төслийн үр дүн:

- ☐ 21.6 тэрбум литр ус хэмнэсэн
- ☐ 2.5 сая МВт.цаг эрчим хүч хэмнэсэн
- ☐ 460,428 тонн хүлэмжийн хийн ялгаралтаас сэргийлсэн
- ☐ 39 сая ам.долларын ногоон хөрөнгө оруулалт хийгдсэн

Суралцах зүйл: Нэхмэлийн салбарын үйлдвэрүүдийн ногоон үйлдвэрлэл явуулах техникийн боломж, ногоон санхүүгийн хэрэгцээг тодорхойлоход мэргэжлийн зөвлөхүүдийн туслалцааг авснаар тэдгээр үйлдвэрлэгчдийн

ногоон зээл авах, улмаар ногоон үйлдвэрлэл рүү хийх шилжилтээ амжилттай хийх магадлал нэмэгдсэн.

ХАВСРАЛТ 6. СУДАЛГААНД ХАМРАГДСАН 17 ҮЙЛДВЭРИЙН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ЭРЭЛТ БА ЗОРИУЛАЛТУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

НОГООН САНХҮҮЖИЛТИЙН НИЙТ ХЭРЭГЦЭЭ	сая ₮	%
	24,486	100.0%
Эрчим хүчний хэмнэлтийн	15,286	62.4%
Цахилгаан	4,374	17.9%
1. Мэдрэгчтэй гэрлийн унтраалга	15	0.1%
2. Лед гэрэлтүүлэг	62	0.3%
3. Нарны зай хураагуур	3,855	15.7%
4. Инвертер суурилуулах, солих	302	1.2%
5. Цахилгаан хэмнэгч, алдагдал бууруулагч	59	0.2%
6. Цахилгааны тоолуур	8	0.0%
7. Тог тогтворжуулагч	23	0.1%
8. Жижиг оврын под станцаас тог татах	20	0.1%
9. Сүлжихийн машинд чийгшүүлэгч	18	0.1%
10. Хэрэглээний халуун усны дулааны насос (цахилгаан зарцуулалтыг 75% бууруулна)	12	0.0%
Дулаан	10,685	43.6%
11. Барилгын дулаалга, ханын хавтан, дээвэр	4,071	16.6%
12. Шинэ үйлдвэрийн барилга, байгууламжийн дулаан алдагдалгүй шийдэл, нэмэлтүүд	6,008	24.5%
13. Вакум цонх, хаалга	532	2.2%
14. Ялтсан бойлуур тавих	45	0.2%
15. Орчны температурын зөрүүгээр хэрэглээний халуун ус гаргах эко төхөөрөмж (эко халаалт г.м)	29	0.1%
Уур	227	0.9%
16. Хаягдал уурыг дахин ашиглах нэмэлт тоноглол, систем	151	0.6%
17. Газар уур үүсгэх төхөөрөмж	76	0.3%
Усны хэрэглээг хэмнэх	4,899	20.0%
Цэвэр ус	97	0.4%
18. Мэдрэгчтэй угаагуур	28	0.1%
19. Ус зөөлрүүлэгч төхөөрөмж	66	0.3%
20. Усны тоолуур	1	0.0%
21. Шаараг түүгч/олон дахин хэрэглэдэг	2	0.0%

Бохир үс	4,801	19.6%
22. Цэвэрлэх байгууламж байгуулах	4,140	16.9%
23. Бохир ус дахин ашиглах төхөөрөмж, систем	347	1.4%
24. Бохир усны хоолойд нарийн шүүлтүүр тавих	0	0.0%
25. Усны нөөцийн сав	314	1.3%
Хог хаягдлын менежмент	284	1.2%
Тоног төхөөрөмж	246	1.0%
26. Задлах, ээрэх машин, оёдлын цех	186	0.8%
27. Хүнсний хог хаягдал дахин боловсруулах төхөөрөмж	60	0.2%
28. Ангилан, ялгах зориулалтын хогийн сав, зөөвөрлөх зардал	38	0.2%
Химийн бодисын зохистой хэрэглээ	8	0.0%
29. Угаалгын бодис/Зөөлрүүлэгч	6	0.0%
30. Угаалгын бодис/Шингэн саван	2	0.0%
Нийгмийн асуудал	1,659	6.8%
31. Ажилчдын амралтын газар	120	0.5%
32. Ажилчдад зориулсан сургалт	97	0.4%
33. Агааржуулалтын систем хийх, сайжруулах	97	0.4%
34. Ажилчдын автобус, унааг эко болгох /гибрид, газ/	670	2.7%
35.Цэцэрлэг, өдөр өнжүүлэх /түрээс, ашиглалтын зардал/	675	2.8%
Үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилготой тоног төхөөрөмж авах (ногоон байхад нийцэх)	1,008	4.1%
36. Угаалгын машин	47	0.2%
37. Хатаагч машин, индүүний тоног төхөөрөмж	31	0.1%
38. Үйлдвэрлэлийг өргөжүүлэх бол шинэ тоног төхөөрөмжийг илүү ногоон байхаар сонгоход гарах санхүүжилтийн зөрүү	930	3.8%
Бусад	1,342	8.3%
39. Эко сав, баглаа боодол	606	2.5%
40. Эко сав, баглаа боодлыг үйлдвэрлэх тоног төхөөрөмж	68	0.3%
41. Орчны тохижилт, мод тарих г.м	351	1.4%
42. Бусад	317	1.3%

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 3. 1 Боловсруулах салбарын зээл, зээлийн төрлөөр (хувь).....	15
Зураг 4. 1 Нэхмэлийн үйлдвэрүүдэд шаардлагатай байгаа ногоон санхүүгийн эрэлт ба зориулалтууд (сая төгрөг).....	20
Зураг 4. 2 Ногоон санхүүгийн нэн тэргүүний зориулалтууд (давтамж, нийлбэр үнийн дүнгээр).....	21
Зураг 4. 3 Нэхмэлийн салбарын ногоон зээлийн боломжит эх үүсвэрийн нийлүүлэлт.....	26

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 3. 1 Ноос, ноолуурын салбарын эдийн засгийн байр суурь, нөлөөлөл.....	13
Хүснэгт 3. 2 Төслөөр хэрэгжсэн зээл (сая төгрөг).....	15
Хүснэгт 4. 1 Судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээлд эзлэх байр суурь (2017-2018 он).....	16
Хүснэгт 4. 2 Ногоон санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг үндсэн 7 дэд чиглэлээр ангилсан нь.....	18
Хүснэгт 4. 3 Нэхмэлийн салбарын ногоон санхүүгийн эрэлтийн шинжилгээ.....	19
Хүснэгт 4. 4 Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийн нэмэлт шаардлага.....	31
Хүснэгт 4. 5 Зээлийн бүтээгдэхүүнүүдийн нөхцөл, бүлгээр.....	32
Хүснэгт Х1. 1 Цэвэрлэх байгууламжийн үнэ, борлуулагч, технологи.....	36
Хүснэгт Х1. 2 Дулаалгын материалуудын үндсэн үзүүлэлт, харьцуулалт....	37

Хүснэгт Х1. 3 Дулаалгын материалуудын төрөл, үнэ ханш, худалдаалж буй байгууллагуудын харьцуулалт.....	37
Хүснэгт Х1. 4 Ус зөөлрүүлэгч төхөөрөмж.....	38
Хүснэгт Х2. 1 МТЭХСҮ төслийн хүрээнд зээл олгож буй банкнууд, зээлийн нөхцөл.....	40
Хүснэгт Х2. 2 ТSL төслийн хүрээнд зээл олгож буй банкнууд, зээлийн нөхцөл.....	41
Хүснэгт Х2. 3 ОББҮХорооны ногоон зээлийг олгох банкнууд, зээлийн нөхцөл.....	42
Хүснэгт Х2. 4 Иргэдэд зориулсан ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд, тэдгээрийн нөхцөл.....	43
Хүснэгт Х2. 5 Одоогоор олгогдохгүй байгаа зээлийн бүтээгдэхүүнүүд.....	45
Хүснэгт Х2. 6 “ХААХХ төслийн нэмэлт санхүүжилт” төслийн зээл олгогч банкнууд, зээлийн нөхцөл.....	46
Хүснэгт Х2. 7 Германы КФВ банкны ЖДҮ-г дэмжих төслийн зээлийн нөхцөл.....	47
Хүснэгт Х2. 8 Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээлийн нөхцөл.....	48
Хүснэгт Х2. 9 Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн нөхцөл....	48
Хүснэгт Х2. 10 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн нөхцөл.....	49
Хүснэгт Х2. 11 “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээлийн нөхцөл.....	49
Хүснэгт Х2. 12 ББСБ-уудын бизнесийн зээлийн нөхцөл.....	50

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХААХХТ	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл
АХБ	Азийн хөгжлийн банк
ЗБДТДЗЭЗТАЭНТ	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл
ЯОУХАБ	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
МТЭХСҮ	Монголын тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн үйлчилгээ
МННХ	Монголын ноос, ноолуурын холбоо
МУХБ	Монгол улсын хөгжлийн банк
ХХБ	Худалдаа Хөгжлийн Банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ҮХОБ	Үндэсний хөрөнгө оруулалтын банк
УБХБ	Улаанбаатар хотын банк
МБ	Монгол банк
ТоС Холбоо	Монголын тогтвортой санхүүгийн холбоо
МБХ	Монголын банкны холбоо

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Арилжааны банкуудын ногоон зээлийн судалгаа

40-50 үйлдвэрийн ногоон санхүүжилтийн эрэлтийн онлайн асуулга

Сонгогдсон 20 үйлдвэрийн ногоон санхүүжилтийн эрэлтийн судалгаа

Үндэсний Статистикийн Хороо

Гаалийн Ерөнхий Газар

Арилжааны банкнуудын зээлийн тайлан, Монголбанк

Дулаалгын материалуудын сонголт ба харьцуулалт, www.barilgachin.mn

Монголбазальт, Росторг, Пирамид Индастри компаниудын албан ёсны вэбсайт

www.barilgachin.mn

Аргил сувд ХХК, Том Ком Сервис ХХК, Aqua electronics, Монвеком ХХК, Ecowater Shop компаниудын албан ёсны вэбсайт

Блүүмберг, <https://www.bloomberg.com/graphics/2019-green-finance/>

Дэлхийн ногоон санхүүгийн индекс: https://www.finance-watch.org/wp-content/uploads/2019/03/GGFI_3_Full_Report.pdf

Азийн Хөгжлийн Банк, “Ulaanbaatar Green Affordable Housing and Resilient Urban Renewal Sector Project: Project Administration Manual”, 2018 оны 8 сар,

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/49169/49169-002-pam-en.pdf>

ЖЭРЭС (Сэргээгдэх эрчим хүч болон байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм) байгууллагын Монгол улс дахь нэгж

ХХААХҮЯ, “НООЛУУР” ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН, 2019 оны 3 сарын 20,

<http://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/nooluur2018.pdf>

Монгол банк, Дамжуулан олгох төслийн зээлийн 2019 оны 2-р улирлын тайлан

Монгол банк, “ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн байдал”, 2015 оны 6 сар

ЖДҮХС, Зээлийн удирдлагын хэлтэс

Сангийн Яам, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тэмдэглэл”, 2018 он

Санхүүгийн Зохицуулах Хороо, Банк бус санхүүгийн байгууллагын газар, “Банк бус санхүүгийн байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга”

Зээлийн Батлан Даалтын Сан

ЯОУХАБ-ын 2 үе шаттай төслийн нэгж

Сангийн Яам

МТЭХСҮ төслийн нэгж

АХБ-ны ХААХХ төслийн нэгж

МУХБ-ны Зээлийн Газар

Органик Монгол төслийн нэгж

